



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Жигжидгийн БАТЖАРГАЛ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,
Утас: 26-08-78, Факс: 32-70-16
E-mail: batjargal@parliament.mn
http://www.parliament.mn

2024.03.25 № УИХ-03/2180
танай _____ -ны № _____ -т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай


Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийг санаачлан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Хавсралт ¹³¹ хуудастай.

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Ж.БАТЖАРГАЛ

А.АДЪЯАСҮРЭН

Ш.АДЬШАА

Н.АЛТАНХУЯГ

Ц.АНАНДБАЗАР

Т.АУБАКИР

Х.БАДЕЛХАН

С.БАТБОЛД

Д.БАТЛУТ

Ж.БАТСУУРЬ

Б.БАТТӨМӨР

000020



Б.БАТ-ЭРДЭНЭ

Ж.БАТ-ЭРДЭНЭ

Б.БАЯРСАЙХАН

Б.БЕЙСЕН

Х.БОЛОРЧУЛУУН


С.БЯМБАЦОГТ

С.ГАНБААТАР

Д.ГАНБАТ

Т.ГАНБОЛД

Н.ГАНИБАЛ



Ц.ДАВААСҮРЭН

Г.ДАМДИННЯМ

Б.ДЭЛГЭРСАЙХАН

Б.ЖАВХЛАН

Г.ЗАНДАНШАТАР

Ц.ИДЭРБАТ

Д.МӨНХБААТАР

Г.МӨНХЦЭЦЭГ

Н.НАРАНБААТАР

Д.ӨНӨРБОЛОР

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Б.ПҮРЭВДОРЖ



Ш.РАДНААСЭД

Ц.СЭРГЭЛЭН

Д.ТОГТОХСҮРЭН

Ц.ТУВААН

Г.ТЭМҮҮЛЭН



 Ч.УНДРАМ

Ч.ХҮРЭЛБААТАР

 О.ЦОГТГЭРЭЛ

Ц.ЦЭРЭНПУНЦАГ

 С.ЧИНЗОРИГ

Б.ЧОЙЖИЛСҮРЭН

 Б.ЭНХ-АМГАЛАН

Л.ЭНХ-АМГАЛАН

 Н.ЭНХБОЛД

Т.ЭНХТҮВШИН

Ж.ЭРДЭНЭБАТ

 М.Сонгор Очир

 Б.Саранмिशот

 С.Амарсайхан



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Жигжидийн БАТЖАРГАЛ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,
Утас: 26-08-78, Факс: 32-70-16
E-mail: batjargal@parliament.mn
<http://www.parliament.mn>

2024.03.22 № УИХ-03/2106
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
тов тогтоолгох тухай


Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслүүдийг санаачлан боловсрууллаа. Хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулга болон холбогдох материалыг хавсаргав.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйл, 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсэгт заасны дагуу хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тов тогтоож өгнө үү.

Хавсралт^{1/2} хуудастай.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Ж.БАТЖАРГАЛ



МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Д.АМАРБАЯСГАЛАН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Жигжидийн БАТЖАРГАЛ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон.

Утас: 26-08-78, Факс: 32-70-16

E-mail: batjargal@parliament.mn

<http://www.parliament.mn>

2024.01.17 № ЧУХ-03/526

танай _____-ны № _____-т

Хуулийн төсөлд санал
авах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт заасны дагуу Монгол Улсын Их Хурлын дарга болон орон нутгаас сонгогдсон Улсын Их Хурлын гишүүдийн санаачилгаар Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийг санаачлан боловсрууллаа. Хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулга болон холбогдох материалыг хавсралтаар хүргүүлэв.

Боловсруулсан хуулийн төсөлтэй холбогдуулан Засгийн газрын холбогдох саналыг нэгтгэн ирүүлэхийг Танаас хүсье.

Хавсралт: 119 хуудас.

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Ж.БАТЖАРГАЛ

000013



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ж.БАТЖАРГАЛ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn


2024. 03. 13 № ХТТ/468
танай _____-ны № _____-т

**Хуралдааны тэмдэглэл
хүргүүлэх тухай**

Таны санаачлан боловсруулсан Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэлийг хүргүүлж байна.

Хавсралт 05 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА




Д.АМАРБАЯСГАЛАН

000245005474

БАТЛАВ:

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Ж.БАТЖАРГАЛ

**МАЛЧИН ӨРХИЙН ХОЛБООНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг боловсруулах дараах хууль зүйн болон практик үндэслэл, шаардлага байна.

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 5 дахь хэсэгт “Мал сүрэг бол үндэсний баялаг бөгөөд төрийн хамгаалалтад байна” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого¹-ын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 8.3.3-т “Бэлчээрийн газрыг ашиглах, сайжруулах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулсан эрх зүйн орчныг тодорхой болгож, бэлчээрийн менежментийн нэгдсэн системийг бий болгож, бэлчээрийн доройтол, цөлжилтийг бууруулна.” гэж, 8.3.4-т “Байгаль экологи, бэлчээрийн даацтай уялдуулж, малын тоо, төрөл, бүтцийн дээд хязгаарыг тогтоох, бэлчээрийн мэрэгч амьтад, шавжтай тэмцэх, малын бэлчээр, хадлан, тэжээл, усны хангамж, хүрэлцээг нэмэгдүүлж, мал аж ахуйн эрсдэлийг бууруулна.” гэж, Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”²-ын 3.5.2.5-д “Бэлчээрийн мал аж ахуй, малчдын ахуй амьдралд шинжлэх ухаан, технологийн ололтыг нэвтрүүлэх, уламжлалт сэтгэлгээ, арга хэвшлийг сэргээж, хурдацтай явагдаж байгаа экосистемийн өөрчлөлтийг мэдэрч түүнд тохирсон, дасан зохицсон амьдралын хэв маяг, аж ахуй эрхлэх менежментийн арга барилыг боловсруулж заан сургах, туршин нэвтрүүлэх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж, олон нийтэд хүргэх сургалт, сурталчилгааг өргөжүүлнэ.” гэж, 3.5.2.2-т “Бэлчээр ашигласны төлбөр тогтоох, эзэмшүүлэх, хамгаалах болон нөхөн сэргээх хариуцлага хүлээлгэх чиглэлээр эрх зүйн орчныг бүрдүүлж, бэлчээрийн одоогийн төлөв байдал, цаашдын хандлагад суурилсан бэлчээрийн даацыг бүс нутаг бүрээр шинэчлэн тогтоож малын тоо толгой, төрөл, сүргийн бүтцийн зохистой харьцааг хангана” гэж заасан байна.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”³-ийн 3.3.4-т “Бэлчээрийг усжуулах, худагжуулах ажлыг үргэлжлүүлэн малын бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлэх, хамгаалах, нөхөн сэргээх, тогтвортой байдлыг хангах, малын чанар, ашиг шимийг сайжруулж, малын тоог чанарт шилжүүлж малын генийн санг хамгаалах, биотехнологийн ололтыг нэвтрүүлэх, эрчимжсэн мал аж ахуйн салбарын хөгжлийг дэмжиж, “Монгол мал-II” арга хэмжээг хэрэгжүүлнэ.” гэж, 3.3.5-

¹ Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2020 он №25

² Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2010 он №36

³ Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2020 он №38

д “Бэлчээрийн ашиглалт, хамгаалалт, сайжруулалтын хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, бэлчээрийн доройтол, цөлжилтийг бууруулна.” гэж, 3.3.12.Хөдөө аж ахуйн тээвэр, борлуулалтын логистикийн сүлжээг байгуулж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн чанарын хяналт, баталгаажуулалтын оновчтой тогтолцоог бүрдүүлнэ.” гэж тус тус заажээ.

Ийнхүү Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомж, бодлогыг баримт бичгүүдэд манай улсын эдийн засгийн суурь салбар, уламжлалт өв соёл - нүүдлийн мал аж ахуйн үндэс болох бэлчээрийг хамгаалах, зүй зохистой ашиглахтай холбоотой асуудлууд тусгагдсан байна.

1.2.Практик шаардлага

Манай улс нүүдлийн мал аж ахуйгаа хадгалж авч үлдэхийн үндэс нь малчин, мал, бэлчээр гурвын харилцан шүтэлцээг хангах буюу малчин өрхүүдийн хамтын ажиллагааг дэмжих замаар бэлчээрийн доройтлоос хамгаалах, малыг эрүүлжүүлэх, үүлдэр угсааг сайжруулах, нутаг орны байгалийн нөөцийг малчдын оролцоонд суурилан хамгаалах асуудал болоод байна. Тус салбарын хөгжил нь газар (бэлчээр) болон мал хэмээх биологийн зүй тогтлоороо нөхөн сэргээгдэж байдаг байгалийн нөөцөд тулгуурладаг билээ.⁴

Монгол Улсын Их Хурлын 2009 оны 39 дүгээр тогтоолоор баталсан “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-д малчдын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, тэдний эрүүл мэнд, нийгмийн хамгааллыг сайжруулах, нийгмийн даатгалын тогтолцоонд хамруулах, мэдлэг, чадварыг дээшлүүлэх, хүч, хөдөлмөрөө хоршихыг урамшуулах, бэлчээрийн мал аж ахуйг эрхлэн хөтлөх аргыг боловсронгуй болгох замаар малчдын тав тухтай амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэх, мал аж ахуйг эрсдэл багатай, баталгаатай хөгжүүлэхээр заасан боловч 2019 онд Хүнс, хөдөө аж ахуйн яамны захиалгаар Байгаль орчин, хөдөө аж ахуйн эдийн засгийн хүрээлэн” ТББ-ын хийсэн хөндлөнгийн үнэлгээгээр уг бодлогын хэрэгжилт хангалтгүй дүнтэй гарчээ.

Төрөөс малчдын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд үр дүнд суурилсан, үр нөлөөтэй, төсөв, санхүүгийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, төсвийн дэмжлэг, урамшууллыг үр дүнтэй ашиглахын тулд түүнийг хэрэгжүүлж байгаа арга хэлбэр, үр дүнд шинжилгээ хийж, салбарын зорилт, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ядуурлыг бууруулах, эдийн засгийн өсөлтийг хангахад төсвийн зардлыг илүү үр ашигтай зарцуулах шаардлагатай байна.

Уламжлалт мал аж ахуйн салбарт жилийн дөрвөн улиралд бэлчээрийн мал аж ахуй зонхилдог бөгөөд байгалийн эрсдэлд орох магадлал өндөр, улирал байгаль цаг уурын нөхцөл байдлаас хамааран нэг малаас авах ашиг шим харьцангуй бага, мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэх, боловсруулах үйлдвэрүүдийн байршил, төрөл, хүчин чадлаас хамааран түүхий эд бэлтгэн нийлүүлэлтийн оновчтой тогтолцоо бүрдээгүй байна.⁵

Түүнчлэн монгол орны газар зүй, уур амьсгал, бэлчээрийн мал аж ахуйн онцлогоос хамааран монголчууд эрт дээр үеэс айл саахалтаараа хүч хөдөлмөрөө нэгтгэн байгаль цаг уурын хүндрэл бэрхшээлийг даван туулж ирсэн уламжлалыг

⁴ БОАЖЯ, ХААИС, UNDP, Монгол орны бэлчээрийн тулгамдсан асуудал: Гарц ба шийдэл 2019 он

⁵ Хөдөө аж ахуйн дэмжлэг, урамшууллын судалгааны тайлан 2023 он

өнөөгийн нийгмийн хэрэгцээ шаардлагатай уялдуулж, хөгжүүлэх шаардлага өнөөдөр нэгэнт тулгараад байна.

Малчид амьдарч буй нутаг усныхаа бэлчээр, байгалийн нөөцийг тогтвортой хамгаалж, ашигласнаар Монгол Улсын нийт газар нутгийн 70,1 хувийг эзэлдэг бэлчээрийн ашиглалт, хамгаалалтын асуудлыг төрөөс нэгдсэн бодлогоор хангах нөхцөл бүрдэх юм.

Нутгийн иргэдэд түшиглэсэн байгаль хамгаалал олон улсын сайн туршлагын нэг болох нь гадаад орнуудад батлагдаад байгаа билээ. Энэ нь Беркес болон Фикрет нарын (2007) тодорхойлсноор "нутгийн иргэд зохион байгуулалтад орж, өөрсдийн амьдарч буй хүрээлэн буй орчны байгалийн нөөцийг орон нутгийн түвшинд хамтдаа тогтвортой ашиглах, хамгаалах үйл хэрэг" юм. Малчин өрхийн амьжиргааны эх үүсвэр нь байгалийн нөхөн сэргээгдэх нөөцтэй шууд хамааралтай байдаг учраас малчин өрхийн амьжиргаа, байгалийн нөөц хоёрын харилцан уялдааг хангаж, тогтвортой амьжиргааны эх үүсвэрээ нэмэгдүүлэх боломжийг бий болгох нь зайлшгүй чухал байна.

Манай улсын хувьд сүүлийн 30 орчим жилд газрын харилцаа, тэр дундаа бэлчээрийн газрын ашиглалт, хамгаалалтыг төлөвлөх, хэрэгжилтэд хяналт тавих асуудал хангалтгүй байснаас сэлгэн нүүдэллэж, бэлчээрийг хуваарьтай ашиглаж ирсэн уламжлал алдагдаж байна. Газрын тухай хуулийн бэлчээрийг нийтээр, дундаа ашиглах зохицуулалт нь урт хугацаандаа бэлчээрийг доройтуулж, даацыг нь хэтрүүлж, талхлах, талхалсан ч ямар ч хариуцлага хүлээдэггүй нийтээр дундаа ашигладаг тогтолцоо муу үр дагаварт хүргэж байна. Мөн малын тоо толгойн татвар малын тоог бэлчээрийн даацад тохируулах, бэлчээрийг хамгаалах механизм болж чадахгүй байгаагаас үнэгүй шахам бэлчээрт малаа өсгөж, ашиг хүртэх сонирхол давамгайлснаас чанарт бус тооны өсөлтөд илүү анхаарч, байгалийн жамаар бэлчээр нөхөн сэргэх боломжийг олгохгүй байна. Түүнчлэн малын тоог бэлчээрийн даацад нийцүүлэхэд урамшуулах хөшүүрэг байхгүй учир бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх ажиллагаанд хөрөнгө оруулалт хийх сонирхолгүй болгож байна.

Үүний уршгаар нийт бэлчээрийн газар нутгийн 65.0 хувь доройтож, 13.0 хувь цөлжилтөд өртөөд байна.⁶ Хязгаарлагдмал нөөцийг хэмжээнээс хэтрүүлэн зохицуулалтгүй ашиглах нь байгаль экологийн тэнцвэрт байдалд аюул учруулахаас гадна малын гаралтай органик бүтээгдэхүүн үйлдвэрлэх, нэмүү өртөг бий болгох, экспортлох боломжийг хязгаарлаж, улмаар монголчуудын нүүдлийн мал аж ахуйт соёл иргэншил, уламжлалт өв соёлоо алдах эрсдлийг дагуулж байна.

Манай улсын бэлчээрийн хэвийн даац хонин толгойд шилжүүлснээр 86 сая мал байхад тохиромжтой гэж үздэг ч 2022 оны жилийн эцсийн мал тооллогоор тооцоход 120,7 саяд хүрсэн⁷ ба бэлчээрийн доройтлын түвшин аймаг, сум, баг тус бүрт харилцан адилгүй байгааг судлаачид тогтоосон байна. Бэлчээр ашиглалтын ачааллын өнөөгийн горимыг зохицуулж чадвал нийт доройтсон бэлчээрийн 80 гаруй хувь нь байгалийн аясаар сэргэх боломжтой⁸ гэж судлаачид үздэг.

Бэлчээр ашиглагчид болох малчин, мал бүхий иргэн, малчин өрх, тэдний хамтын зохион байгуулалтын хэлбэр, эрх зүйн статус тодорхойгүй, бэлчээрийн

⁶ Газрын нэгдмэл сангийн тайлан 2021 он

⁷ <https://www.1212.mn>

⁸ С.Цэрэндаш нар, УБ 2006 он

ашиглалт, хамгаалалтын талаар сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгадаггүй, бэлчээрийн газрын ашиглалт, хамгаалалтад төрийн оролцооны чиг үүрэг, хяналт тодорхойгүй, оновчтой бус байна. Бэлчээрийн газар нь мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой эрхлэх суурь асуудал, хөгжлийн үндэс тул түүнийг зүй зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх асуудлыг хариуцах эзэнтэй болгож, хариуцлагажуулах нь нэн чухал байна.

Дээр дурдсан хэрэгцээ шаардлагыг үндэслэн Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай анхдагч хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан журмын дагуу боловсруулна.

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Энэ хуулийн зорилго нь малчин, мал, бэлчээрийн харилцан шүтэлцээнд тулгуурлан бэлчээрийн мал аж ахуйн уламжлалт соёлыг хадгалах, малчдын хамтын менежментийг төлөвшүүлж, малчдын нийтлэг эрх ашгийг хамгаалах, байгалийн нөөц, бэлчээрийг даацад нь тохируулан зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, малын чанар, ашиг шимийг нэмэгдүүлэх замаар малчдын амьжиргааг дээшлүүлэх үндсэн зорилготой болно. Хуулийн төсөл нь 5 бүлэгтэй.

Нэгдүгээр бүлэгт хуулийн үйлчлэх хүрээг заах ба үүнд малчин өрхийн анхдагч холбоонд бэлчээрийг гэрээгээр ашиглуулах, гэрээт бэлчээрийн газар дахь байгалийн нөөцийг ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, малчдын хамтын зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой харилцааг уг хуулиар зохицуулахаар, "малчин өрх", "гэрээт бэлчээрийн газар", "байгалийн нөөц" зэрэг уг хуулийн төсөлд хэрэглэх нэр томъёоны тодорхойлолтыг оруулах болно. Малчин өрхийн холбоо нь гишүүддээ үйлчилдэг, ашгийн төлөө бус хуулийн этгээд байх ба холбооны үйл ажиллагаанд баримтлах зарчим, дүрэмд тусгах асуудлыг төсөлд тусгайлан заах болно.

Хоёрдугаар бүлэгт малчин өрхийн холбооны үндсэн нэгж болох Малчин өрхийн анхдагч холбоог үүсгэн байгуулах, түүний эрхлэх үйл ажиллагааны талаарх зохицуулалтыг тусгах болно.

Тухайн сумын нутаг дэвсгэр дээр зэргэлдээ нутагладаг малчин өрхүүд бэлчээрийг зохистой ашиглаж, амьжиргаагаа дээшлүүлэх зорилгоор Малчин өрхийн анхдагч холбоог үүсгэн байгуулж болох бөгөөд анхдагч холбоо нь газар нутгийн онцлог, бэлчээрийн нөхцөл байдлаас хамаарч 20-оос доошгүй малчин өрхийн гишүүнчлэлтэй байх юм.

Малчин өрхийн анхдагч холбоо нь бэлчээрийн газрыг сумын Засаг даргатай байгуулсан гэрээний үндсэн дээр зохистой ашиглаж, доройтлоос сэргийлэх, сайжруулах, хамгаалах асуудлыг хариуцах; малчин өрхийн гишүүнийг боловсрол, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамруулах, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, тэдгээрт төрийн мэдээллийг хүргэх; малын эрүүл мэнд, үржил, чанар, ашиг шимийг дээшлүүлэх; мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэх, борлуулахад дэмжлэг үзүүлэх гэсэн 4 үндсэн чиглэлийн үйл ажиллагаанд малчин өрхүүдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалж, зохион байгуулж оролцохоор төсөлд тусгана.

Гуравдугаар бүлэгт Анхдагч холбооны удирдлага, зохион байгуулалт, санхүүжилтийн талаар тусгах бөгөөд Холбооны санхүүжилт нь гишүүнчлэлийн

хураамж; хууль тогтоомжийн дагуу олгосон санхүүжилт; хуульд заасан үйл ажиллагаа эрхэлж олсон орлого; гадаад, дотоодын хуулийн этгээд, хувь хүний хандив, тусламж; хууль тогтоомж, дүрэмд заасан бусад эх үүсвэрээс бүрдэх болно.

Дөрөвдүгээр бүлэгт сум, аймгийн малчин өрхийн холбоо болон улсын нэгдсэн холбооны эрх зүйн байдал, тэдгээрийн эрхлэх үйл ажиллагаа, зохион байгуулалтын талаар тусгах болно. Сумын малчин өрхийн холбоо нь Анхдагч холбоо бүрийн Ахлагч нараас бүрдэх, анхдагч холбоо бүр сумынхаа малчин өрхийн холбоонд гишүүнчлэлтэй байх, аймгийн малчин өрхийн холбоо нь сумын малчин өрхийн холбоо бүрээс сонгогдсон 2 гишүүний төлөөллөөс бүрдэхээр, улсын хэмжээнд Малчин өрхийн нэгдсэн холбоо ажиллах, уг холбоо нь аймгийн малчин өрхийн холбооны дарга нараас бүрдэхээр төсөлд тусгах болно.

Сум, аймгийн болон малчин өрхийн нэгдсэн холбоо доод шатны холбоодын үйл ажиллагааг уялдуулан, зохион байгуулалтаар хангах, тухайн шатны бодлогын баримт бичиг, төрийн бодлого, үйл ажиллагаанд малчин өрх, холбооны эрх, ашиг сонирхлыг тусгах нийтлэг чиг үүрэгтэй байхаар төсөлд тусгана.

Тавдугаар бүлэгт Малчин өрхийн холбооноос төрийн байгууллага, албан тушаалтантай хэрхэн харилцах, төрөөс үзүүлэх дэмжлэгийн талаар мөн холбооны тайлан, хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагын талаар тусгахаас гадна хуулийг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тусгах болно.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар

Хуулийн төсөл батлагдсанаар юуны өмнө малчин өрхүүдийн хамтын ажиллагаа, идэвх санаачилга, оролцоо, өөрсдийгөө удирдах, манлайлах чадвар нэмэгдэх, бэлчээр, байгалийн нөөцийн менежмент сайжирч, малчдын мэдлэг, чадвар, амьжиргаа, эдийн засгийн боломж дээшлэх юм.

Монгол орны бэлчээрийн мал аж ахуй эрхлэх өвөрмөц онцлогт тохируулан, бэлчээрийг ашиглаж ирсэн уламжлал, зан заншилд тулгуурлан бэлчээрийн сэргэх чадавхид суурилсан ашиглалт, хамгаалалтыг төлөвшүүлэхэд чиглэсэн эрх зүйн орчин бүрдэх болно.

Гэрээгээр ашиглаж байгаа бэлчээртээ өөриймсөг хандаж, даацад нь тааруулан хуваарь сэлгээтэйгээр зохистой ашиглах, хамгаалах, малын тооны араас хөөцөлдөх бус харин ашиг шим, чанарыг эрхэмлэх сэтгэлгээг бий болгож, төлөвшүүлэх болно.

Малчин өрхүүд эдийн засаг, нийгмийн эрэлт хэрэгцээгээ хамтран хангахаас гадна амьдарч буй нутаг усныхаа бэлчээр, байгалийн нөөцийг тогтвортой хамгаалж, ашигласнаар урт удаан хугацааны тогтвортой амьжиргаа, амьдралын нөхцөлөө сайжруулах боломж бүрдэнэ.

Дөрөв.Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах хууль тогтоомжийн талаар

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулна. Хуулийн төсөлтэй холбогдуулан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт

оруулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Малын тоо толгойн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Хоршооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Амьтны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Байгалийн ургамлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Тогтоолд нэмэлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Тогтоолд нэмэлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг тус тус боловсруулна.

-----oOo-----

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

*Малчин өрхийн холбооны эрх зүйн
байдлын тухай хуулийн төслийн талаар*

Манай улс нүүдлийн мал аж ахуйн өв уламжлал, соёлоо хадгалах, байгаль экологийн тэнцвэрт байдлыг хамгаалахын үндэс нь малчин, мал, бэлчээр гурвын харилцан шүтэлцээг хангах буюу малчин өрхүүдийн хамтын ажиллагааг дэмжих замаар тэдний нийтлэг эрх ашгийг хамгаалах, байгалийн нөөц, бэлчээрийг даацад нь тохируулан зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, малын чанар, ашиг шимийг нэмэгдүүлэх, нутаг орны байгалийн нөөцийг малчдын оролцоотойгоор хамгаалах асуудал болоод байна.

1. Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд малчдын хамтын үүсгэл санаачилгын байгууллага болох Малчин өрхийн анхдагч холбоог зэргэлдээ нутагладаг буюу бэлчээрийг хамтран ашигладаг, газар нутгийн онцлог, бэлчээрийн нөхцөл байдлаас хамаарч 20-оос доошгүй малчин өрх нийлж байгуулахаар тусгалаа. Энэхүү анхдагч холбоо нь сумын Засаг даргатай байгуулсан гэрээний үндсэн дээр бэлчээрийн газрыг зохистой ашиглаж, доройтлоос сэргийлэх, сайжруулах, хамгаалах асуудлыг хариуцах бөгөөд гишүүдийн боловсрол, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, төрийн мэдээллийн үйлчилгээг хүргэх; малын эрүүл мэнд, үржил, чанар, ашиг шимийг дээшлүүлэх, гэрээт бэлчээрийн газар, байгалийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэх, борлуулахад дэмжлэг үзүүлэх гэсэн 4 үндсэн чиглэлийн үйл ажиллагаанд гишүүдийнхээ эрх, ашиг сонирхлыг илэрхийлж, зохион байгуулж оролцох юм.

Хуулийн төсөлд “малчин өрх” гэж мал аж ахуй эрхэлж, мал, түүний ашиг шимээр үндсэн орлогоо олдог өрхийг; “малчин өрхийн анхдагч холбоо” гэж сайн дурын үндсэн дээр, малчдын нийтлэг эрх ашгийн төлөө өөрөө удирдах зарчимд үндэслэн энэ хуулийн дагуу байгуулагдсан хуулийн этгээдийг; “гэрээт бэлчээрийн газар” гэж малчин өрхийн анхдагч холбоонд гэрээний дагуу ашиглуулж байгаа улирлын бэлчээрийг хамааруулж ойлгохоор нэр томъёоны тодорхойлолтыг хийв. Малчин өрхийн холбоо нь гишүүддээ үйлчилдэг, ашгийн төлөө бус хуулийн этгээд байх ба холбооны үйл ажиллагаанд баримтлах зарчим, дүрэмд тусгах асуудлыг төсөлд тусгайлан заасан болно.

Төсөлд Сумын малчин өрхийн холбоо нь Анхдагч холбооны Ахлагч нараас бүрдэх ба анхдагч холбоо бүр сумынхаа малчин өрхийн холбоонд гишүүнчлэлтэй байх, аймгийн малчин өрхийн холбоо нь сумын малчин өрхийн холбоо бүрээс сонгогдсон 2 гишүүний төлөөллөөс бүрдэхээр, улсын хэмжээнд Малчин өрхийн нэгдсэн холбоо ажиллах, уг холбоо нь аймгийн малчин өрхийн холбооны дарга нараас бүрдэхээр тусгалаа. Сум, аймгийн болон малчин өрхийн нэгдсэн холбоо доод шатны холбоодын үйл ажиллагааг уялдуулан, зохион байгуулалтаар хангах, тухайн шатны бодлогын баримт бичиг, төрийн бодлого, үйл ажиллагаанд малчин өрх, холбооны эрх, ашиг сонирхлыг тусгах нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх юм.

Малчин өрхийн анхдагч холбоо нь суурь нэгж болохын хувьд бүх гишүүдийн хурал, түүний чөлөө цагт Тэргүүлгэчид, Ахлагч гэсэн удирдлагын бүтэцтэй байх бөгөөд эдгээр

институцын үйл ажиллагаа, зохион байгуулалт, эрх, үүрэг, түүнчлэн гишүүнчлэлийн талаар төсөлд тусгайлан зохицуулсан болно.

Холбооны санхүүжилт нь гишүүнчлэлийн хураамж; хууль тогтоомжийн дагуу олгосон санхүүжилт; хуульд заасан үйл ажиллагаа эрхэлж олсон орлого; гадаад, дотоодын хуулийн этгээд, хувь хүний хандив, тусламж; хууль тогтоомж, дүрэмд заасан бусад эх үүсвэрээс бүрдэх ба түүнийг дээр дурдсан 4 үндсэн чиглэлийн үйл ажиллагаа ба дүрэмд заасан бусад үйл ажиллагаанд зарцуулахаар тусгав.

Түүнчлэн малчин өрхийн холбооноос төрийн байгууллага, албан тушаалтантай хэрхэн харилцах, холбоонд төрөөс үзүүлэх дэмжлэгийн талаар төсөлд тусгасан болно.

2.Улсын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоолоор баталсан “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-д малчдын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, тэдний эрүүл мэнд, нийгмийн хамгааллыг сайжруулах, нийгмийн даатгалын тогтолцоонд хамруулах, мэдлэг, чадварыг дээшлүүлэх, хүч, хөдөлмөрөө хоршихыг урамшуулах, бэлчээрийн мал аж ахуйг эрхлэн хөтлөх аргыг боловсронгуй болгох замаар малчдын тав тухтай амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэх, мал аж ахуйг эрсдэл багатай, баталгаатай хөгжүүлэхээр заасан боловч уг бодлогын хэрэгжилтэд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны захиалгаар Байгаль орчин, хөдөө аж ахуйн эдийн засгийн хүрээлэн” ТББ-аар 2019 онд хөндлөнгийн үнэлгээ хийлгэхэд хэрэгжилт хангалтгүй дүнтэй гарчээ.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын Хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод Байгаль экологи, бэлчээрийн даацтай уялдуулж, малын тоо, төрөл, бүтцийн дээд хязгаарыг тогтоох, бэлчээрийн мэрэгч амьтад, шавжтай тэмцэх, малын бэлчээр, хадлан, тэжээл, усны хангамж, хүрэлцээг нэмэгдүүлж, мал аж ахуйн эрсдэлийг бууруулахаар заасан боловч энэ чиглэлээр бодлогын хэмжээнд дорвитой хийсэн ажил одоогоор алга байна.

Газрын тухай хууль, Хоршооны тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуулиар малчид хоршоо байгуулан аж ахуйн үйл ажиллагаа явуулах, малчдын бүлэг байгуулж бэлчээрийг гэрээгээр ашиглах, нөхөрлөл байгуулах замаар байгалийн нөөцийн менежментийг хийх асуудлыг зохицуулж байгаа боловч Монгол орны байгаль цаг уурын нөхцөл, бэлчээрийн мал аж ахуйн онцлогоос хамаарч малчин өрхүүд айл саахалт нутаглаж хөдөлмөр, хүчээ хорших замаар малаа маллаж, байгаль цаг уурын хүндрэл бэрхшээлийг даван туулж ирсэн уламжлалыг орчин үеийн техник, технологийн хөгжил, мэдлэгтэй хоршин хөгжүүлэх шаардлага тулгараад байна.

Газрын тухай хуулийн бэлчээрийг нийтээр ашиглах зохицуулалт нь урт хугацаандаа бэлчээрийг доройтуулж, талхлах муу үр дагаварт хүргэж байна. Малын тоо толгойн татвар бэлчээрийн даацад малын тоог тохируулах, бэлчээрийг хамгаалах механизм болж чадахгүй байгаагаас үнэгүй шахам бэлчээрт малаа өсгөж, ашиг хүртэх сонирхол давамгайлснаас чанарт бус тооны өсөлтөд илүү анхаарч, байгалийн жамаар бэлчээр нөхөн сэргэх боломжийг олгохгүй байна. Түүнчлэн бэлчээрийг нийтээр ашиглах нь бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх ажиллагаанд хөрөнгө оруулалт хийх сонирхолгүй болгож байгаа явдал ажиглагдаж байгаа юм.

Анхдагч холбооны гишүүн малчин өрхүүд дээр дурдсан хуулиудын хүрээнд хоршоо, нөхөрлөл байгуулан ажиллах нь нээлттэй байх бөгөөд харин бэлчээрийг Анхдагч

холбоо байгуулах замаар хамтран зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх нь илүү дэвшилттэй гэж үзэж төсөлд тусгасантай уялдуулан Газрын тухай хуулийн бэлчээрийг малчдын бүлэгт ашиглуулахтай холбоотой хэсгийг өөрчлөн найруулахаар хамт өргөн мэдүүлэх хуулийн төслийг боловсруулсан болно.

3. Мал аж ахуйг тогтвортой эрхлэхэд тулгарч буй үндсэн асуудлын нэг бол бэлчээрийн бүтээмж, биологийн олон янз байдлыг тэтгэдэг бэлчээрийн экосистемийн төлөв байдал, орчны нөхцөлүүд олон газар буурч байгаа явдал юм.

Бэлчээрийн мониторингийн 2016 оны мэдээллээр, мониторингийн бүх цэгийн 42 хувь нь төлөв байдлын хувьд “соргог” буюу “талхлагдаагүй”, 13.5 хувь нь сул, 21.1 хувь нь дунд зэрэг, 12.8 хувь хүчтэй талхлагдсан, харин 10.3 хувь нь сэргэлтгүй талхлагдсан гэж тогтоогджээ. 2018 онд доройтсон бэлчээрийн хувь хэмжээ 65%, эрүүл соргог бэлчээрийн эзлэх хувь хэмжээ 10%-иар буурч, хүчтэй доройтож цөлжих аюулд хүрсэн бэлчээр нутгийн хэмжээ 13% болж нэмэгдсэн нь зайлшгүй анхаарах ёстой асуудлын нэг болоод байна. 2018 оны байдлаар, ургац 20-30 хувиар буурч, ургамлын зүйлийн бүрдэл цөөрч, малд идэмжтэй, тэжээллэг үетэн болон алаг өвст бэлчээр хумигдаж, шарилжит, нэг наст ургамлын эзлэх хувь ихэсч байна.¹

Монгол Улсын нийт газар нутгийн 70,1 хувийг бэлчээрийн газар эзэлдэг. Бэлчээрийн боломжит даацыг хонин толгойд шилжүүлэхэд 86 сая байх ёстой ч 2022 оны байдлаар малын тоо 120,7 саяд хүрсэн² ба бэлчээрийн доройтлын түвшин аймаг, сум, баг тус бүрт харилцан адилгүй байгааг, түүнчлэн бэлчээр ашиглалтын ачааллыг зохицуулж чадвал нийт доройтсон бэлчээрийн 80 гаруй хувь нь байгалийн аясаар сэргэх боломжтой³ талаар судлаачид тогтоосон байна.

Бэлчээрийн доройтлыг даган малчдын амьжиргаа, мал аж ахуйн үйлдвэрлэл тогтворгүй, бүтээмж доогуур, уур амьсгал, байгалийн эрсдэлд улам бүр эмзэг болж байна. Бий болсон нөхцөл байдал залуучуудыг мал маллахаас татгалзахад хүргэж, малчдын залуу халаа тасрах эрсдэл учраад байна.

4. Сүүлийн жилүүдэд бэлчээрийн төлөв байдлыг сэргээх зорилгоор олон улсын төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсний үр дүнд бэлчээрийн ургамлын сэргэх чадавхид суурилсан бэлчээрийн менежмент хэмээх шинэ ойлголт, хандлагыг нэвтрүүлж эхлээд байна. Энэ нь “бэлчээр ашиглалтын гэрээ” хэлбэрээр хэрэгжиж байна.

Бэлчээр ашиглалтын гэрээний гол нөхцөл нь бэлчээрийг даацад малын тоо тоог тохируулах явдал бөгөөд энэ аргыг хүлээн зөвшөөрч буй малчдын тоо нэмэгдсээр байна. 2018 ны байдлаар 11 аймагт бэлчээр ашиглагчдын 830 хэсэг (БАХ) сумын Засаг даргатайгаа бэлчээр ашиглалтын гэрээ байгуулжээ. Гэрээг 15 хүртэл жилийн хугацаатай байгуулж байгаа бөгөөд энэ ажилд 15 000 орчим малчин өрх, 16 сая га бэлчээрийн газар хамаарч байна. Энэхүү гэрээ нь малчдын хооронд гарах бэлчээрийн маргаан зөрчил, бэлчээрийн газрыг өөр зориулалт/ангилалд шилжүүлэх асуудлыг зохистой арга замаар шийдвэрлэх хэрэгсэл болж байгаа юм.

¹ Монгол орны бэлчээрийн төлөв байдлын үндэсний тайлан 2018 он

² <https://www.1212.mn>

³ С.Цэрэндаш нар, УБ, 2006 он

5.Нутгийн иргэдэд түшиглэсэн байгаль хамгаалал олон улсын сайн туршлагын нэг болох нь гадаад орнуудад батлагдаад байгаа билээ. Энэ нь Беркес болон Фикрет нарын (2007) тодорхойлсноор “нутгийн иргэд зохион байгуулалтад орж, өөрсдийн амьдарч буй хүрээлэн буй орчны байгалийн нөөцийг орон нутгийн түвшинд хамтдаа тогтвортой ашиглах, хамгаалах үйл хэрэг” юм. Малчин өрхийн амьжиргааны эх үүсвэр нь байгалийн нөхөн сэргээгдэх нөөцтэй шууд хамааралтай байдаг учраас малчин өрхийн амьжиргаа, байгалийн нөөц хоёрын харилцан уялдааг хангаж, тогтвортой амьжиргааны эх үүсвэрээ нэмэгдүүлэх боломжийг төрөөс бий болгох нь зайлшгүй шаардлагатай байна.

6.Хуулийн төслийн талаар Улсын Их Хурлын гишүүд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Жижиг, дунд үйлдвэрийн газар, Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах газар, Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн, МИУС, ШУТИС, ШУАкадеми, Хөдөө аж ахуйн их сургууль, Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо зэрэг иргэний нийгмийн байгууллагуудын төлөөллийг оролцуулсан “Шинэ хөдөө” сэдэвт хэлэлцүүлгийг 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулсан.

Хэлэлцүүлгийн үеэр хэлэлцүүлэгт оролцогчид бэлчээрийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудлаар санал нэгдэж, төслийг дэмжсэн ба Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн нарын өргөн мэдүүлсэн Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй уялдуулах, одоо үйл ажиллагаа явуулж байгаа бэлчээрийн холбоод, мал, малын гаралтай түүхий эд бэлтгэх, боловсруулах хоршоо, нөхөрлөл зэрэг хуулийн этгээдээс ямар ялгаатай болох талаар асууж тодруулан, санал солилцсон болно.

---oOo---

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

*Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай
болон түүнийг дагаж гарах хууль, УИХ-ын бусад
шийдвэрийн төслийн талаар*

Нэг.Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн талаар:

Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд малчдын хамтын үүсгэл санаачилгын байгууллага болох Малчин өрхийн анхдагч холбооны эрх зүйн байдлын талаар зохицуулсан бөгөөд зэргэлдээ нутагладаг буюу нэг нутаг усны, бэлчээрийг хамтран ашигладаг, газар нутгийн онцлог, бэлчээрийн нөхцөл байдлаас хамаарч 20-оос доошгүй малчин өрх нийлж энэ холбоог байгуулахаар тусгалаа. Анхдагч холбоо нь гишүүдийнхээ боловсрол, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, төрийн мэдээллийн үйлчилгээг хүргэх; малын эрүүл мэнд, үржил, чанар, ашиг шимийг дээшлүүлэх, гэрээт бэлчээрийн газар, байгалийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэх, борлуулахад дэмжлэг үзүүлэх гэсэн 4 үндсэн чиглэлийн үйл ажиллагаанд гишүүдийнхээ эрх, ашиг сонирхлыг илэрхийлж, зохион байгуулж оролцох юм. Бэлчээрийг сумын Засаг даргатай байгуулсан гэрээний үндсэн дээр хуваарьтай ашиглаж, доройтлоос сэргийлэх, сайжруулах, хамгаалах ажлыг хийхээр төсөлд тусгалаа.

Хуулийн төсөлд “малчин өрх” гэж мал аж ахуй эрхэлж, мал, түүний ашиг шимээр үндсэн орлогоо олдог өрхийг ойлгохоор тусгасан. Малчин өрх нь өөрийн болон бусдын өмчийн малыг малладаг байж болох бөгөөд малынхаа ашиг шимээр амьжиргаагаа залгуулдаг байх нь гол шалгуур болно. “Малчин өрхийн анхдагч холбоо” гэж сайн дурын үндсэн дээр, нийтлэг эрх ашгийнхаа төлөө нэгдэж, энэ хуулийн дагуу байгуулагдсан хуулийн этгээдийг ойлгохоор нэр томьёоны тодорхойлолтыг хийв. Бэлчээрийн газрын тухай ойлголт нь газрын хуулиар зохицуулах харилцаанд хамаарах тул “гэрээт бэлчээрийн газар” гэсэн нэр томьёог уг төсөлтэй хамт боловсруулсан Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгаж, анхдагч хуулийн төсөлдөө эшилж оруулав. Сумын Засаг дарга сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг үндэслэн малчин өрхийн анхдагч холбоотой гэрээ байгуулж ашиглуулж байгаа 4 улирлын бэлчээрийг хамааруулахаар тусгав.

Малчин өрхийн холбоо нь гишүүддээ үйлчилдэг, ашгийн төлөө бус хуулийн этгээд байх бөгөөд холбооны үйл ажиллагаанд баримтлах зарчим, дүрэмд тусгах асуудлыг төсөлд тусгайлан заасан болно.

Сумын малчин өрхийн холбоо нь тухайн суманд үйл ажиллагаа явуулж байгаа Анхдагч холбоодын гишүүнчлэлтэй байх ба тэдгээр анхдагч холбооны Ахлагч нараас бүрдэнэ. Аймгийн малчин өрхийн холбоо нь сумын малчин өрхийн холбоо бүрээс сонгогдсон 2 гишүүний төлөөллөөс бүрдэхээр, улсын хэмжээнд Малчин өрхийн нэгдсэн холбоо ажиллах, уг холбоо нь аймгийн малчин өрхийн холбооны дарга нараас бүрдэхээр тусгалаа. Сум, аймгийн болон малчин өрхийн нэгдсэн холбоо доод шатны холбоодын үйл ажиллагааг уялдуулан, зохион байгуулалтаар хангах, тухайн шатны бодлогын баримт бичиг, төрийн бодлого, үйл ажиллагаанд малчин өрх, холбооны эрх, ашиг сонирхлыг тусгах нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх юм.

Малчин өрхийн анхдагч холбоо нь суурь нэгж болохын хувьд бүх гишүүдийн хурал, түүний чөлөө цагт Тэргүүлэгчид, Ахлагч гэсэн удирдлагын бүтэцтэй байх бөгөөд эдгээр институцын үйл ажиллагаа, зохион байгуулалт, эрх, үүрэг, түүнчлэн гишүүнчлэлийн талаар төсөлд тусгайлан зохицуулсан болно.

Холбооны санхүүжилт нь гишүүнчлэлийн хураамж; хууль тогтоомжийн дагуу олгосон санхүүжилт; хуульд заасан үйл ажиллагаа эрхэлж олсон орлого; гадаад, дотоодын хуулийн этгээд, хувь хүний хандив, тусламж; хууль тогтоомж, дүрэмд заасан бусад эх үүсвэрээс бүрдэх ба түүнийг дээр дурдсан 4 үндсэн чиглэлийн үйл ажиллагаа болон дүрэмд заасан бусад үйл ажиллагаанд зарцуулахаар тусгав.

Түүнчлэн малчин өрхийн холбооноос төрийн байгууллага, албан тушаалтантай хэрхэн харилцах, холбоонд төрөөс үзүүлэх дэмжлэгийн талаар төсөлд тусгасан болно.

Хоёр.Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлтэй хамт боловсруулсан хууль тогтоомжийн төслийн талаар:

Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлтэй хамт дараах хууль тогтоомжийн төслүүдийг боловсрууллаа. Үүнд:

- 1/Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- 2/Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- 3/Малын тоо толгойн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 4/Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
- 5/Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- 6/Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 7/Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай;
- 8/Хоршооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
- 9/Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- 10/Амьтны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
- 11/Байгалийн ургамлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
- 12/Байгаль орчныг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
- 13/Тогтоолд нэмэлт оруулах тухай /Улсын Их Хурлын 2011 оны 30 дугаар тогтоол/;
- 14/Тогтоолд нэмэлт оруулах тухай /Улсын Их Хурлын 2012 оны 74 дүгээр тогтоол/.

Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Малчин өрхийн холбооны тухай хуулийн төслийн үзэл баримтлалд малчин өрхийн анхдагч холбоонд бэлчээрийг гэрээгээр ашиглуулахаар заасантай холбоотойгоор Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 4 зүйлтэй байхаар боловсрууллаа.

Хуулийн төсөлд гэрээт бэлчээрийн газар, бэлчээрийн даац зэрэг нэр томъёог тодорхойлж, гэрээгээр ашиглуулах бэлчээрийн зааг, хэмжээ, байршлыг тогтоох, бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааг төлөвлөх,

хариуцан гүйцэтгэх этгээд, бусад оролцогч талуудын эрх, үүргийг тогтоох зэрэг харилцааг зохицуулахаар тусгалаа.

Гэрээгээр ашиглуулах бэлчээрийн зааг, хэмжээ, байршлыг аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө болон сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд нийцүүлэн бэлчээр ашиглагч малчин өрхийн анхдагч холбоодын нэгдсэн шийдэл буюу багийн иргэдийн Нийтийн Хурлын шийдвэрийг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтоохоор, уг шийдвэрийг үндэслэн сумын Засаг дарга анхдагч холбоотой бэлчээр ашиглалтын гэрээ байгуулахаар төсөлд тусгалаа. Гэрээний бүртгэл болон гэрээгээр ашиглуулсан бэлчээрийн талаарх мэдээллийг газрын нэгдмэл сангийн тайланд тусгах ажлыг сумын газрын даамал хариуцахаар зохицуулав.

Бэлчээрийн даацыг сумын газрын даамал, сумын бэлчээр хариуцсан мэргэжилтэнтэй хамтран жил бүр тогтоож, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих болно.

Малчин өрхийн анхдагч холбоонд бэлчээрийн газар ашиглуулах гэрээ байгуулах журам, гэрээний загварыг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хамтран батлахаар тусгав. Уг гэрээг 15 хүртэл жилийн хугацаатай байгуулах бөгөөд гэрээний үүргийн биелэлтийг харгалзан анх гэрээ байгуулсан хугацаагаар сунгаж болно.

Байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюулын улмаас өөр аймаг, сумын нутаг дэвсгэрт нүүдэллэх шаардлага гарвал тухайн шатны Засаг дарга нар уг асуудлыг бэлчээрийн даацад нийцүүлэн хэлэлцэн шийдвэрлэх, анхдагч холбооны гэрээгээр ашиглаж байгаа бэлчээрт бусдын мал оруулах асуудлыг гэрээний нөхцөлд тусгахаар заав.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар малчин өрхийн анхдагч холбоонд гэрээгээр ашиглуулах бэлчээрийн зааг, хэмжээ, байршлыг тогтоохоор Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаатай холбоотойгоор Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн сумын чиг үүрэг хэсэгт бэлчээрийн ашиглалт, хамгаалалтын асуудлыг нэмж тусгав.

Багийн газар нутгийн хэмжээ, малчин өрхийн тооноос хамаарч нэг багт хэд хэдэн анхдагч холбоо байж болох тул баг дотроо бэлчээрийн зааг, байршлаа шийдэх зорилгоор Нэгжийн хуулийн 23 дугаар зүйлд багийн чиг үүрэгт малчин өрхийн анхдагч холбоонд бэлчээрийн зориулалтаар ашиглуулах газрын зааг, байршлын талаар шийдвэр гаргах талаар зохицуулалтыг тусгав.

Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд сумын Засаг дарга бэлчээрийн газрыг малчин өрхийн анхдагч холбоонд ашиглуулах гэрээг байгуулахаар тусгасантай холбогдуулан уг гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх ажлыг зохион байгуулах асуудлыг Нэгжийн хууль дахь сумын Засаг даргын бүрэн эрхэд нэмэхээр тусгасан болно.

Малын тоо толгойн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Малын тоо толгойн албан татварын тухай хуулиар тухайн сумын нутаг дэвсгэрт байгаа малын тоо толгой тутамд 0-2000 төгрөгийн албан татвар ногдуулах эрх хэмжээг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд олгосон байдаг. Татварын хэмжээг тогтоохдоо харгалзан үзэх шалгуур үзүүлэлтийг хуульд заагаагүй байсан тул бэлчээрийг хуваарьтай ашиглах, байгалийн жамаар нөхөн сэргэх нөхцөл боломжоор хангах зорилгоор малын тоог бууруулах шаардлагын үүднээс уг татварын хэмжээг тогтоохдоо бэлчээрийн даацыг харгалзан хуульд заасан дээрх хязгаарт багтаан шийдвэрлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэгт заасан Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийн нэг болох малын тоо толгойн албан татварын орлогыг бэлчээрийн менежментийг сайжруулахад зарцуулахаар заасныг бэлчээрийн даац тогтоох, бэлчээрийн төлөв байдлын үнэлгээ хийх, бэлчээр ашиглалтын гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулахад зарцуулахаар нарийвчлан тодорхой болгов.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13.1.29-д малчин, мал бүхий этгээдийн борлуулсан таван хошуу мал, анхан шатны боловсруулалтад ороогүй мах, сүү, арьс шир, ноолуур, хонь болон тэмээний ноос, сарлагийн хөөврийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсөн атал мөн хуулийн 14.1-д мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг **хувь хүн**, хуулийн этгээд өөрөө бэлтгэсэн буюу тариалсан, үйлдвэрлэлийн анхан шатны боловсруулалтад ороогүй мах, сүү, өндөг, арьс шир, хонь, тэмээний ноос, ноолуур, сарлагийн хөөвөр, мах боловсруулах үйлдвэрлэлд зориулан бэлтгэх таван хошуу мал, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ болон дотооддоо үйлдвэрлэсэн гурилыг дотоодын үйлдвэрлэгчдэд борлуулсан бол үнийн дүнд нь 10 хувийн албан татвар шингэсэн гэж үзэж, тэдгээрийг худалдан авсан албан татвар суутган төлөгчийн албан татварыг уг хувиар хасч тооцохоор заасан нь логикгүй, ойлгомжгүй байдлыг үүсгэж байгаа юм.

Өөрөөр хэлбэл, малчин, мал бүхий этгээд эдгээр түүхий эдийг борлуулахад нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдөж байгаа тул малчин гишүүдийнхээ эдгээр түүхий эдийг борлуулж байгаа малчдын хоршоог мөн чөлөөлөх нь логикийн хувьд зөв болох юм.

Үүнээс гадна түүхий эд бэлтгэлийн тогтолцоог бүрдүүлэх, ченжийн оролцоог бууруулахад малчдын хоршоог дэмжих нь оновчтой хөшүүрэг болох талаар судлаачдын хийсэн судалгаа, дүгнэлт, зөвлөмжийн дагуу мөн хуулийн 13.1.29-ийн “хувь хүн” гэснийг хасч, татварын чөлөөлөлт хэсэгт “малчдын хоршоо”-г нэмэхээр төсөлд тусгав.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн үзэл баримтлал, зохицуулах харилцааны гол цөм нь байгалийн нөөц, бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах асуудал байгаа тул бэлчээр хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд Байгаль орчин, уур амьсгалын сангийн хөрөнгийн тодорхой хэсгийг зарцуулах шаардлагатай гэж үзэж, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 7.3-т нэмэлт оруулахаар төсөлд тусгав.

Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн үзэл баримтлалын хүрээнд малчдын боловсрол, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор Боловсролын ерөнхий хуулийн 3.1.7-д “насан туршийн суралцахуй” гэж хүн хэрэгцээ, сонирхол, боломж, нөхцөлдөө нийцүүлэн орон зай, цаг хугацаанаас үл хамааран мэргэжил, боловсрол, мэдлэг, чадвараа албан, албан бус сургалтаар болон амьдралын орчинд суралцах замаар тасралтгүй хөгжүүлэх, дээшлүүлэх үйл ажиллагааг; 17 дугаар зүйлийн 17.1-д боловсролын байгууллага нь боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн, үнэлгээний, чанарын баталгаажуулалт-магадлан итгэмжлэлийн, боловсролын сургалтын байгууллага, насан туршийн суралцахуйн төвөөс бүрдэхээр, 17.6-д насан туршийн суралцахуйн төв нь иргэний албан, албан бус сургалтаар боловсрол эзэмших, бие даан суралцахад мэдээллээр ханган, зөвлөн туслах, удирдан зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлэхээр, 17.7-д насан туршийн суралцахуйн төв нь бичиг үсгийн болон ерөнхий боловсрол нөхөн эзэмшүүлэх сургалтыг төлбөргүй зохион байгуулахаар, 29 дүгээр зүйлийн 29.1.4-т аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал насан туршийн суралцахуйн төвийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, санхүүжилтийг батлахаар тус тус заасныг хэрэгжүүлэх хөшүүрэг болгож, мөн хуулийн 31 дүгээр зүйл дэх сумын Засаг даргын бүрэн эрхэд малчин өрхийн анхдагч холбоотой хамтран ажиллах, малчин өрхийн гишүүнийг насан туршийн суралцахуйн сургалтад хамруулах асуудлыг тусгав.

Хоршооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн үзэл баримтлалд заасан малын гаралтай түүхий эд нийлүүлэлтийн оновчтой тогтолцоо бүрдүүлэх ажлын хүрээнд хоршоо бусад хоршоодтой, эсхүл аж ахуйн нэгжтэй хамтран дундын хоршоо байгуулахыг дэмжих зорилгоор дундын хоршооны өөрийн хөрөнгөд нэг гишүүний оруулах хувь хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзэж Хоршооны тухай хуулийн 24.2-ыг өөрчлөн найруулахаар төсөлд тусгав.

Дундын хоршооны үйл ажиллагааг хоршооны дарга л удирдан зохион байгуулах боломжтой бөгөөд хууль батлагдсанаас хойших хугацаанд энэ талаар хоршоологчдоос ирүүлсэн саналын дагуу 36.6-ын “Дундын хоршооны даргаар аль нэг гишүүн хоршоо болон хуулийн этгээдийн удирдлагад давхар ажиллахыг хориглоно.” гэсэн заалтыг хүчингүй болсонд тооцохоор төсөлд тусгасан болно.

Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Амьтны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Байгалийн ургамлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн үзэл баримтлалд нийцүүлэх зорилгоор Усны тухай хуульд заасан багийн Засаг даргын бүрэн эрх, Амьтны тухай хуульд заасан сумын Засаг даргын бүрэн эрх, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд заасан багийн Засаг даргын бүрэн эрхэд тус тус малчин өрхийн анхдагч холбоотой хамтран ажиллах асуудлыг нэмж тусгав.

Түүнчлэн Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлд Засгийн газар байгаль орчныг хамгаалах талаархи төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг гэрээний үндсэн дээр байгаль орчныг хамгаалах дүрмийн зорилго бүхий төрийн бус байгууллагад эсхүл тухайн нутгийн иргэдийн сайн дурын үндсэн дээр нэгдэн байгуулагдсан этгээдэд шилжүүлж, түүний хэрэгжилтийг санхүүжүүлж болохоор заасныг тодотгон малчин өрхийн холбоогоор гүйцэтгүүлж болох зохицуулалтыг хийсэн болно.

Байгалийн ургамлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт ургамлыг нөхөн сэргээх буюу нөхөн сэргэх нөхцөлийг бүрдүүлэх, хамгаалах зорилгоор бэлчээр, хадлангийн газрыг хуваарьтай, даацад нь тохируулж ашиглуулах асуудлыг сум, баг, дүүрэг, хорооны Засаг дарга шийдвэрлэхээр заасныг Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн үзэл баримтлалд уг шийдвэрийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гаргахаар заасантай нийцүүлэх зорилгоор холбогдох хуульд заасны дагуу шийдвэрлэхээр төсөлд тусгав.

Монгол Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн талаар:

Улсын Их Хурлын 2011 оны “Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” 30 дугаар тогтоолоор хонь, тэмээний ноос, сарлагийн хөөвөрт олгох, Улсын Их Хурлын 2012 оны “Малчид, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай” 74 дүгээр тогтоолоор бог малын арьс, адуу, үхрийн ширэнд олгох урамшууллын хэмжээг тогтоосон ба үүнд малчин, мал бүхий этгээдийн бэлтгэж, үндэсний боловсруулах үйлдвэрт тушаасан түүхий эдийг хамааруулахаар заасан байдаг.

Эдгээр тогтоолыг анх батлахдаа хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд олгохоор заасан байсныг 2015 оны 40, 2016 оны 45 дугаар тогтоолоор тус тус өөрчлөлт оруулж, “хоршооны гишүүн” гэснийг хассан бөгөөд энэ нь Малчин өрхийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн үзэл баримтлалд заасан түүхий эд бэлтгэлийг хоршоогоор дамжуулах, малчдын хоршоог дэмжих асуудалтай нийцэхгүй байх тул хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд дээрх урамшууллыг олгохоор тогтоолд нэмэлт оруулахаар төсөлд тусгав.

---oOo---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ний өдөр

Улаанбаатар
хот

МАЛЧИН ӨРХИЙН ХОЛБООНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилго, зорилт

1.1.Энэ хуулийн зорилго нь малчин, мал, бэлчээрийн харилцан шүтэлцээнд тулгуурлан бэлчээрийн мал аж ахуйн уламжлалт соёлыг хадгалах, малчдын хамтын менежментийг төлөвшүүлж малчдын нийтлэг эрх ашгийг хамгаалах, байгалийн нөөц, бэлчээрийг даацад нь тохируулан зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, малын чанар, ашиг шимийг нэмэгдүүлэх замаар малчдын амьжиргааг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

1.2.Энэ хуулийн зорилт нь малчин өрхийн холбооны зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын хууль тогтоомж

2.1.Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль², Газрын тухай хууль³, Байгаль орчныг хамгаалах тухай хууль⁴, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжоос бүрдэнэ.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Малчин өрхийн анхдагч холбоонд бэлчээрийг гэрээгээр ашиглуулах, гэрээт бэлчээрийн газар дахь байгалийн нөөцийг хууль тогтоомжид заасны дагуу ашиглах, хамгаалах, нөхөн сэргээхэд малчдын оролцоог хангах, малчин өрхийн холбооны тогтолцоог өөрөө удирдах ёсны зарчимд нийцүүлэн зохион байгуулахтай холбоотой харилцааг энэ хуулиар зохицуулна.

¹ Монгол Улсын Үндсэн хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

² Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2021 оны 07 дугаарт нийтлэгдсэн.

³ Газрын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2002 оны 27 дугаарт нийтлэгдсэн.

⁴ Байгаль орчныг хамгаалах тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1995 оны 5, 6 дугаарт нийтлэгдсэн.

3.2.Малчин өрхийн эрх зүйн байдалтай холбоотой, энэ хуулиар зохицуулаагүй бусад харилцааг холбогдох хуулиар зохицуулна.

3.3.Гэрээт бэлчээрийн газрыг ашиглахтай холбоотой, энэ хуулиар зохицуулаагүй бусад харилцааг Газрын тухай хуулиар зохицуулна.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд заасан дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“малчин” гэж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн⁵ 3.1.9-д заасныг;

4.1.2.“малчин өрх” гэж мал аж ахуй эрхэлж, мал, түүний ашиг шимээр үндсэн орлогоо олдог өрхийг;

4.1.3.“Малчин өрхийн анхдагч холбоо” гэж сайн дурын үндсэн дээр, малчдын нийтлэг эрх ашгийн төлөө өөрөө удирдах зарчимд үндэслэн энэ хуулийн дагуу байгуулагдсан хуулийн этгээдийг.

4.1.4.“гэрээт бэлчээрийн газар” гэж Газрын тухай хуулийн 3.1.13-т заасныг;

4.1.5.“байгалийн нөөц” гэж гэрээт бэлчээрийн газар дахь байгалийн ургамал, ой, ойн дагалт баялаг, уст цэг, булаг шанд, ан амьтан зэргийг;

5 дугаар зүйл.Малчин өрхийн холбооны эрх зүйн байдал, үйл ажиллагаанд баримтлах зарчим

5.1.Малчин өрхийн холбоо нь гишүүддээ үйлчилдэг, ашгийн төлөө бус хуулийн этгээд байна. Малчин өрхийн холбоо нь малчин өрхийн анхдагч холбоо, сумын, аймгийн, нэгдсэн холбооны зохион байгуулалттай байна.

5.2.Төрийн зарим чиг үүргийг малчин өрхийн холбоогоор хуульд заасны дагуу, эсхүл гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.

5.3.Малчин өрхийн холбоо үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална:

5.3.1.гишүүдийн оролцоо, үүрэг, хариуцлагын тэгш, шударга байдлыг хангах;

5.3.2.үйл ажиллагаа гишүүдэд ил тод, нээлттэй байх;

5.3.3.улс төрөөс ангид байх.

6 дугаар зүйл.Малчин өрхийн холбооны дүрэм

6.1.Малчин өрхийн холбооны дүрэмд дараах асуудлыг тусгана:

⁵ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2011 оны 40 дугаарт нийтлэгдсэн.

6.1.1.холбооны оноосон нэр;
6.1.2.холбооны бүтэц, зохион байгуулалт;
6.1.3.холбооны санхүүжилт, түүнийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах;
6.1.4.гишүүний эрх, үүрэг;
6.1.5.гишүүн элсүүлэх, гишүүний эрхийг түдгэлзүүлэх, сэргээх үндэслэл, гишүүнээс гарах;

6.1.6.холбооноос хоршоо, нөхөрлөл, компани зэрэг бусад этгээдтэй харилцах зарчим, журам

6.1.7.холбоог өөрчлөн байгуулах, татан буулгах;
6.1.8.дүрэм зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага;
6.1.9.энэ хуульд заасан бусад.

6.2.Дүрэм, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд⁶ заасны дагуу улсын бүртгэлд бүртгүүлнэ. Дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн талаар холбогдох татварын албанд бичгээр мэдэгдэнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ МАЛЧИН ӨРХИЙН АНХДАГЧ ХОЛБОО, ТҮҮНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

7 дугаар зүйл.Малчин өрхийн анхдагч холбоог үүсгэн байгуулах, улсын бүртгэлд бүртгүүлэх

7.1.Тухайн сумын нутаг дэвсгэр дэх зэргэлдээ малчин өрхүүд бэлчээрийг зохистой ашиглаж, амьжиргаагаа дээшлүүлэх зорилгоор сайн дурын үндсэн дээр нэгдэж, Малчин өрхийн анхдагч холбоо /цаашид “Анхдагч холбоо” гэх/-г үүсгэн байгуулж болно. Анхдагч холбоо нь газар нутгийн онцлог, бэлчээрийн нөхцөл байдлаас хамаарч 20-оос доошгүй малчин өрхийн гишүүнчлэлтэй байна.

7.2.Анхдагч холбоог үүсгэн байгуулах хурлыг энэ хуулийн 7.1-д заасан малчин өрхийн төлөөлөл зохион байгуулж, уг хурлаар дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ:

7.2.1.холбоо үүсгэн байгуулах тухай шийдвэр гаргах;
7.2.2.холбооны дүрмийг батлах;
7.2.3.холбооны удирдлагын бүтцийг тогтоож, бүрэлдэхүүнийг сонгох, томилох.

7.3.Малчин өрх нэг Анхдагч холбооны гишүүн байна.

7.4.Холбоог үүсгэн байгуулах шийдвэр гарснаас хойш 30 хоногийн дотор Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу улсын бүртгэлд бүртгүүлнэ.

⁶ Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2018 оны 30 дугаарт нийтлэгдсэн.

8 дугаар зүйл. Анхдагч холбоо, түүний үйл ажиллагаа

8.1. Анхдагч холбоо нь хуульд заасны дагуу дараах үйл ажиллагаанд гишүүдийнхээ эрх, ашиг сонирхлыг илэрхийлж, **зохион байгуулж оролцоно:**

8.1.1. малчин өрхийн гишүүнийг боловсрол, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамруулах, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, тэдгээрт төрийн мэдээллийг хүргэх;

8.1.2. гэрээт бэлчээрийн газар, байгалийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх;

8.1.3. малын эрүүл мэнд, үржил, чанар, ашиг шимийг дээшлүүлэх;

8.1.4. мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэх, борлуулахад дэмжлэг үзүүлэх.

8.2. Анхдагч холбоо гишүүдийн бүртгэлийг хөтөлнө.

8.3. Анхдагч холбооны гишүүн өрхийн малчин нь бусад нөхөрлөл, хоршоо, аж ахуйн нэгжийн гишүүн байж болно.

9 дүгээр зүйл. Боловсрол, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамруулах, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, төрийн мэдээллийг хүргэх

9.1. Анхдагч холбоо нь малчин өрхийн гишүүдийг боловсрол, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамруулах, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, төрийн мэдээллийг хүргэх чиглэлээр дараах үйл ажиллагааг зохион байгуулж, дэмжлэг үзүүлнэ:

9.1.1. малчин өрхийн гишүүдийн нарийн мэргэжлийн болон эрүүл мэндийн бусад тусламж, үйлчилгээ авах хүсэлтийг сумын эрүүл мэндийн төвд уламжилж, хамтран ажиллах;

9.1.2. малчин өрхийн гишүүдийг албан болон албан бус сургалтад хамруулах;

9.1.3. холбогдох байгууллагаас зохион байгуулах мал аж ахуйн үйлдвэрлэлийн арга, технологи, бизнесийн үйл ажиллагааны талаар мэдлэг түгээх, малчдын ур чадварыг сайжруулахад чиглэсэн мэргэжил, арга зүйн зөвлөн нэвтрүүлэх үйлчилгээнд гишүүдийг хамруулах;

9.1.4. орон нутгийн удирдлагаас мэдээлэл хүргэх.

9.2. Энэ хуулийн 9.1.1, 9.1.2-т заасан харилцааг холбогдох хууль тогтоомжоор зохицуулна.

10 дугаар зүйл. Гэрээт бэлчээрийн газар, байгалийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх

10.1.Анхдагч холбоо нь гэрээт бэлчээрийн газар, байгалийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр дараах үйл ажиллагаанд Засаг даргатай байгуулсан гэрээний дагуу гишүүдийг зохион байгуулж, дэмжлэг үзүүлнэ:

10.1.1.байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, доройтсон бэлчээрийг нөхөн сэргээх, хөрсний үржил шимийг сайжруулах ажлыг зохион байгуулах;

10.1.2.бэлчээрийн ургамлын ургалт, нөхөн сэргэлтэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байдлаар гэрээт бэлчээрийн газрыг гишүүн малчин өрхөд хуваарьтай ашиглуулах;

10.1.3.малын тоог бэлчээрийн даацад тохируулах;

10.1.4.байгалийн гамшгаас хамгаалах нөөц бүрдүүлэх, хашаа саравч, хадлан, тэжээл бэлтгэх;

10.1.5.гэрээт бэлчээрийн газар, байгалийн нөөцийг зүй зохистой ашиглахад хяналт тавих;

10.1.6.гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас өөр аймаг, сумын малчдын малыг сумын засаг даргын шийдвэрийн дагуу бэлчээрийн даацад тохируулан гэрээт бэлчээрийн газрыг түр ашиглуулахад хяналт тавих;

10.1.7.тухайн жилийн бэлчээрийн гарц, байгаль, цаг уурын урьдчилсан төлөв байдлыг харгалзан өвөлжилтийн бэлтгэл хангах;

10.1.8. гэрээт бэлчээрийн газарт хорио цээртэй өвчин гарах, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамал тархахаас урьдчилан сэргийлэх, гарсан тохиолдолд холбогдох арга хэмжээг авах;

10.1.9.бэлчээрийн усан хангамжийг сайжруулах, хөв цөөрөм байгуулах;

10.1.10.мал, амьтны сэг зэм устгал, орчны халдваргүйтгэлийн арга хэмжээг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах;

10.1.11.газрын нэгдмэл сангийн ангилалд бүртгэгдсэн хадлан, тариалангийн талбайг ашиглах;

10.1.12.гэрээт бэлчээрийн газарт гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, эргүүл хийх, баримтжуулах, таслан зогсоох, мэдээлэх зэргээр эрх бүхий байгууллагатай хамтран ажиллах;

10.1.13.тухайн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх байгаль хамгаалах хөтөлбөр, төлөвлөгөөний төсөлд санал өгөх;

10.1.14.байгалийн нөөцийг хамгаалахтай холбогдсон хуульд заасан бусад үүрэг.

10.2.Өвөлжөө, хаваржааны орчны газар дахь малын бууцтай холилдсон үүсмэл хөрсөнд тэжээлийн ургамал тариалж болно.

10.3.Гэрээт бэлчээрийн газарт энэ хуулийн 10.2-т зааснаас бусад таримал ургамал тарихыг хориглоно.

10.4.Гэрээт бэлчээрийн газраас бусад газарт тэжээлийн болон бусад таримал ургамал тариалах асуудлыг Тариалангийн тухай хуулиар⁷ зохицуулна.

11 дүгээр зүйл.Малын эрүүл мэнд, үржлийн ажил, чанар, ашиг шимийг дээшлүүлэх

11.1.Анхдагч холбоо нь малын эрүүл мэнд, үржлийн ажил, чанар, ашиг шимийг дээшлүүлэх чиглэлээр дараах үйл ажиллагаанд гишүүдийг зохион байгуулж, дэмжлэг үзүүлнэ:

11.1.1.мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулж, гарал үүслийг бүртгэх;

11.1.2.мал, амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, мал, амьтны өвчинтэй тэмцэх, малыг эрүүлжүүлэх;

11.1.3.малын тарилга, туулга, дархлаажуулалт болон мал эмнэлгийн бусад үйлчилгээнд малыг тогтоосон хугацаанд бүрэн хамруулах, малын эрүүл мэндийн дэвтрийг тогтмол хөтлөх;

11.1.4.бүс нутгийн онцлог, уур амьсгалд дасан зохицсон ашиг шим сайтай малыг сонгож, өсгөн үржүүлэх;

11.1.5.нэмэлт ажиллах хүч шаардагдах ажлын үед дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

11.1.6.малын индексжүүлсэн даатгалд хамруулах.

12 дугаар зүйл.Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэх, борлуулахад дэмжлэг үзүүлэх

12.1.Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэх, борлуулах чиглэлээр дараах үйл ажиллагаанд гишүүдийг зохион байгуулж, дэмжлэг үзүүлнэ:

12.1.1.мал, малын гаралтай түүхий эдийг нэг цэгт төвлөрүүлэн анхан шатны ангилалт, тордолт хийж, чанар, гарал үүслийг хянан баталгаажуулах;

12.1.2.чанар, гарал үүслийн баталгаатай мал, малын гаралтай түүхий эдийг малчдын хоршоо болон малчид өөрсдөө үүсгэн байгуулсан ашгийн төлөө этгээдээр дамжуулан боловсруулах үйлдвэрт борлуулах.

ГУРАВДУГААР БҮЛЭГ АНХДАГЧ ХОЛБООНЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, САНХҮҮЖИЛТ

⁷ Тариалангийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2016 оны 08 дугаарт нийтлэгдсэн.

13 дугаар зүйл.Анхдагч холбооны удирдлага, зохион байгуулалт

13.1.Анхдагч холбооны эрх барих байгууллага нь бүх гишүүдийн хурал, түүний чөлөөт цагт Тэргүүлэгчид байна.

13.2.Анхдагч холбооны бүх гишүүдийн хурлын шийдвэрийг хэрэгжүүлж, өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах үүрэг бүхий, бүх гишүүдийн хурлаас сонгогдсон ахлагч /цаашид "Ахлагч" гэх/-тай байна. Ахлагч үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангаа бүх гишүүдийн хуралд жил бүр хэлэлцүүлнэ.

13.3.Анхдагч холбоо Хяналтын зөвлөлтэй байна. Хяналтын зөвлөлийн эрх, үүргийг дүрмээр тогтооно.

14 дүгээр зүйл.Анхдагч холбоог төлөөлөх эрх

14.1.Ахлагч нь сумын малчин өрхийн холбоонд болон бусад этгээдийн өмнө Анхдагч холбоог төлөөлнө.

14.2.Анхдагч холбооны Тэргүүлэгчдийн шийдвэрээр Ахлагчийн эрх, үүргийг аль нэг Тэргүүлэгчид түр шилжүүлж болно.

15 дугаар зүйл.Бүх гишүүдийн хурлын бүрэн эрх

15.1.Анхдагч холбооны бүх гишүүдийн хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

15.1.1.дүрэм батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах;

15.1.2.Ахлагч болон Тэргүүлэгчдийг сонгох, чөлөөлөх, огцруулах;

15.1.3.гишүүний хураамжийн хэмжээг тогтоох;

15.1.4.Анхдагч холбооны жилийн төлөвлөгөө, төсвийг батлах, санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хэлэлцэж, дүгнэлт өгөх;

15.1.5.гишүүн малчин өрх гэрээт бэлчээрийн газрыг ашиглах, сэлгэх, нөхөн сэргээх хуваарийг батлах;

15.1.6.гишүүн элсүүлэх, гишүүнээс гаргах, гишүүний эрхийг түдгэлзүүлэх, сэргээх тухай шийдвэр гаргах;

15.1.7.Анхдагч холбоог өөрчлөн байгуулах, татан буулгах;

15.1.8.хууль болон холбооны дүрэмд заасан бусад бүрэн эрх.

15.2.Бүх гишүүдийн хурал нь ээлжит болон ээлжит бус хуралдааны хэлбэрээр бүрэн эрхээ хэрэгжүүлнэ.

15.3.Шилжиж ирсэн малчин өрхийг анхдагч холбоонд элсүүлэх шийдвэрийг бэлчээрийн даацад тохируулан сумын Засаг даргын гаргасан саналыг үндэслэн бүх гишүүдийн хурал шийдвэрлэнэ.

16 дугаар зүйл.Анхдагч холбооны гишүүнчлэл дуусгавар болох

16.1.Анхдагч холбооны гишүүнчлэл дараах үндэслэлээр дуусгавар болно:

- 16.1.1.өөрийн хүсэлтээр холбооны гишүүнээс гарсан;
- 16.1.2.холбооны үйл ажиллагаа дуусгавар болсон;
- 16.1.3.холбооны гишүүнчлэлээс гаргасан.

16.2.Гишүүнчлэл нь дуусгавар болсон этгээдийн Анхдагч холбоонд төлсөн гишүүний хураамжийг буцаан олгохгүй.

16.3.Дүрэмд өөрөөр заагаагүй бол холбооны гишүүнчлэлээс гарахдаа энэ тухайгаа бичгээр мэдэгдэнэ.

16.4.Анхдагч холбооны гишүүнчлэлээс гаргах асуудлыг шийдвэрлэх хуралд тухайн гишүүн өрхийн төлөөллийг оролцуулна. Түүний эзгүйд, өөрийнх нь зөвшөөрснөөр уг шийдвэрийг гаргаж болно.

16.5.Гишүүнчлэлээс гаргасан тухай шийдвэрийг тухайн этгээдэд даруй бичгээр мэдэгдэнэ.

16.6.Анхдагч холбооны гишүүнээс түдгэлзүүлэх, сэргээх, гишүүнчлэлээс гаргах үндэслэл, журмыг дүрэмд заана.

16.7.Гишүүнчлэлээс гаргасантай холбоотой гомдлыг хянан шийдвэрлэх журмыг холбооны дүрэмд зааж болох бөгөөд дүрэмд заагаагүй бол шүүхэд гомдол гаргаж болно.

17 дугаар зүйл.Бүх гишүүдийн хурлыг зарлан хуралдуулах

17.1.Дүрэмд өөрөөр заагаагүй бол бүх гишүүдийн ээлжит хурлыг жилд хоёроос доошгүй удаа хуралдуулна.

17.2.Дүрэмд заасан бол бүх гишүүдийн ээлжит хурлыг цахимаар явуулж болно.

17.3.Хурлын тов, хэлэлцэх асуудлыг Ахлагчийн саналыг үндэслэн Тэргүүлэгчид тогтооно.

17.4.Анхдагч холбооны нийт гишүүдийн гуравны нэгээс дээш хувийн саналаар ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж болно.

17.5.Дүрэмд өөрөөр заагаагүй бол бүх гишүүдийн хурлын зарыг хурал болохоос 14-өөс доошгүй хоногийн өмнө гишүүдэд хүргэнэ. Хурлын зард хурал болох газар, огноо, цаг, хэлэлцэх асуудлыг тусгана.

17.6.Дүрэмд өөрөөр заагаагүй бол Тэргүүлэгчид ээлжит бус хурлын товыг энэ хуулийн 17.4-т заасан санал гарснаас хойш 10 хоногийн дотор багтаан тогтоож, хурал болох газар, огноо, цаг, хэлэлцэх асуудлыг гишүүдэд мэдэгдэнэ.

17.7.Тэргүүлэгчид ээлжит бус хурлын товыг энэ хуулийн 17.6-д заасан хугацаанд багтаан товлгоогүй бол санаачилга гаргасан гишүүд хурлын товыг тогтоож болно.

17.8.Анхдагч холбооны гишүүдэд хурлын зар хүрээгүй бөгөөд үүнийг санаатайгаар хүргүүлээгүй гэж үзвэл гишүүн хяналтын зөвлөлд гомдол гаргаж болно.

17.9.Хяналтын зөвлөл энэ хуулийн 17.8-д заасан гомдлыг үндэслэлтэй гэж үзвэл удирдах зөвлөлийн хурлыг дахин хуралдуулах шийдвэр гаргаж, үүнтэй холбогдон гарах зардлыг буруутай этгээдээр төлүүлнэ.

18 дугаар зүйл.Бүх гишүүдийн хурал болон түүний шийдвэр хүчин төгөлдөр болох

18.1.Анхдагч холбооны нийт гишүүдийн олонх оролцсоноор бүх гишүүдийн хурлыг хүчин төгөлдөр болсонд тооцно.

18.2.Бүх гишүүдийн хуралд оролцсон гишүүн тус бүр нэг саналын эрхтэй байна.

18.3.Бүх гишүүдийн хуралд оролцох малчин өрхийн төлөөлөл нь эрх зүйн бүрэн чадамжтай иргэн байна.

18.4.Бүх гишүүдийн хурлаас гарах шийдвэр хуралд оролцсон гишүүдийн олонхын саналаар хүчин төгөлдөр болно.

18.5.Дүрэмд өөрөөр заагаагүй бол хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй асуудлыг хурлаар хэлэлцэх эсэхийг хуралд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.

18.6.Бүх гишүүдийн хурлын шийдвэр тогтоол хэлбэртэй байх бөгөөд дүрэмд өөрөөр заагаагүй бол түүнд хурал даргалагч гарын үсэг зурж баталгаажуулна.

18.7.Хуралдааны тэмдэглэлд дараах мэдээллийг тусгана:

18.7.1.хурал болсон, газар, огноо, дугаар;

18.7.2.хурал даргалагчийн нэр;

18.7.3.хурлаар хэлэлцсэн асуудал;

18.7.4.хурлын ирц;

18.7.5.хэлэлцсэн асуудал тус бүрээр зөвшөөрсөн, татгалзсан саналын тоо, гарсан шийдвэрийн бүрэн томъёолол.

18.8.Бүх гишүүдийн хурлын шийдвэр хууль, холбооны дүрэмтэй зөрчилдсөн гэж үзвэл гишүүн энэ тухай шүүхэд гомдол гаргаж болно.

19 дүгээр зүйл.Тэргүүлэгчид, түүний эрх, үүрэг

19.1.Анхдагч холбоо нь гурваас таван Тэргүүлэгчтэй байх бөгөөд тэдгээрийг хоёр жил тутамд бүх гишүүдийн хурлаас шинэчлэн сонгоно.

19.2.Тэргүүлэгчдийн үйл ажиллагааг Ахлагч зохион байгуулж удирдана.

19.3.Тэргүүлэгчид үйл ажиллагаагаа хуралдааны хэлбэрээр явуулна.

19.4.Энэ хуульд зааснаас бусад Тэргүүлэгчдийн эрх, үүргийг тухайн холбооны онцлогт тохируулан дүрмээр тодорхойлно.

20 дугаар зүйл.Ахлагч, түүний эрх, үүрэг

20.1.Ахлагчийг гишүүд дундаасаа нэр дэвшүүлж, бүх гишүүдийн хурлаас 2 жилийн хугацаатай сонгоно.

20.2.Ахлагч дараах эрхтэй:

20.2.1.Тэргүүлэгчдээс олгосон бүрэн эрхийн хүрээнд холбоог төлөөлөн гэрээ, хэлцэл хийх;

20.2.2.дүрэмд заасан эрх хэмжээний хүрээнд холбооны эд хөрөнгийг захиран зарцуулах шийдвэр гаргах;

20.2.3.дүрэмд заасан бусад.

20.3.Ахлагч дараах үүрэгтэй:

20.3.1.холбооны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

20.3.2.холбооны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг жил бүр бүх гишүүдийн хурлаар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах;

20.3.3.холбооны гишүүдийн бүртгэлийг хөтлөх ажлыг зохион байгуулах;

20.3.4.Нягтлан бодох бүртгэлийг хуульд заасан журмын дагуу хөтлөх ажлыг зохион байгуулах;

20.3.5.санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хуульд заасан журмын дагуу гаргаж, бүх гишүүдийн хурлаар хэлэлцүүлэх;

20.3.6.дүрэмд заасан бусад.

20.4.Ахлагчид урамшуулал олгож болох бөгөөд урамшууллын хэмжээг бүх гишүүдийн хурлаас тогтооно.

21 дүгээр зүйл.Анхдагч холбооны санхүүжилт

21.1.Холбооны санхүүжилт дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

21.1.1.гишүүний хураамж;

21.1.2.хууль тогтоомжийн дагуу олгосон санхүүжилт;

21.1.3.энэ хуульд заасан үйл ажиллагаа эрхэлж олсон орлого;

21.1.4.гадаад, дотоодын хуулийн этгээд, хувь хүний хандив, тусламж;

21.1.5.хууль тогтоомж, дүрэмд заасан бусад эх үүсвэр.

21.2.Холбооны хөрөнгийг дараах үйл ажиллагаанд зарцуулна:

21.2.1.энэ хуулийн 8.2-т заасан үйл ажиллагаа;

21.2.2.дүрэмд заасан бусад.

21.3.Малчин өрхийн анхдагч холбоо нь үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх явцад олсон орлогоо зөвхөн дүрэмд заасан зорилгыг хэрэгжүүлэхэд зарцуулна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
СУМ, АЙМГИЙН БОЛОН УЛСЫН МАЛЧИН ӨРХИЙН НЭГДСЭН ХОЛБОО,
ТЭДГЭЭРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

22 дугаар зүйл.Сумын малчин өрхийн холбоо, түүний
зохион байгуулалт

22.1.Анхдагч холбоод нэгдэж, сумын малчин өрхийн холбоог байгуулна.

22.2.Сумын малчин өрхийн холбоо /цаашид "Сумын холбоо" гэх/ нь гишүүн Анхдагч холбоо бүрийн Ахлагч нараас бүрдэнэ.

22.3.Сумын холбоог үүсгэн байгуулах хурлыг Анхдагч холбоодын саналыг үндэслэн сумын Засаг дарга зохион байгуулна.

22.4.Сумын холбоог үүсгэн байгуулах хурлаар дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ:

22.4.1.холбоо үүсгэн байгуулах тухай шийдвэр гаргах;

22.4.2.холбооны дүрмийг батлах;

22.4.3.холбооны зохион байгуулалтыг тодорхойлж, удирдлагыг сонгох.

22.5.Сумын холбоог үүсгэн байгуулах шийдвэр гарснаас хойш 30 хоногийн дотор Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу улсын бүртгэлд бүртгүүлнэ.

22.6.Сумын холбооны хурлыг жилд 1-ээс доошгүй удаа хуралдуулна.

22.7.Сумын холбооны даргыг гишүүд дундаасаа нэр дэвшүүлж, 2 жилийн хугацаатай сонгоно.

22.8.Сумын холбооны удирдлага, зохион байгуулалт, санхүүжилттэй холбоотой, энэ хуулиар зохицуулаагүй бусад асуудлыг дүрмээр тогтооно.

22.9.Сумын холбоо үйл ажиллагаагаа явуулахад сумын Засаг дарга дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.

23 дугаар зүйл.Сумын холбооны үйл ажиллагаа

23.1.Сумын холбоо дараах үйл ажиллагааг явуулна:

23.1.1.гишүүдийн үйл ажиллагааг дэмжих, хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах;

23.1.2.энэ хуулийн 8.2-т заасан үйл ажиллагааны хүрээнд сумын түвшинд баримтлах бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж, энэ талаарх саналаа сумын удирдлагад тавьж шийдвэрлүүлэх;

23.1.3.гишүүдийн мал, малын гаралтай түүхий эд бэлтгэх, борлуулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

23.1.4.сумын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөний төсөлд санал гаргах;

23.1.5.сумын төсвийн төсөл, Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэх мал аж ахуй, бэлчээр, байгаль хамгаалах арга хэмжээний талаар санал гаргах;

23.1.6.гишүүдийн саналд тулгуурлан гадаад, дотоодын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх;

23.1.7.энэ хуулийн 8.2-т заасан үйл ажиллагааны хүрээнд гишүүд, бусад аймаг, сумын холбооны сайн туршлага, үйлдвэрлэлийн шинэ арга технологийг зөвлөн нэвтрүүлэх үйлчилгээг зохион байгуулах.

24 дүгээр зүйл.Аймгийн малчин өрхийн холбоо, түүний зохион байгуулалт

24.1.Сумын малчин өрхийн холбоод нэгдэж, аймгийн малчин өрхийн холбоог байгуулна.

24.2.Аймгийн малчин өрхийн холбоо /цаашид “Аймгийн холбоо” гэх/ нь Сумын малчин өрхийн холбоо бүрээс сонгогдсон 2 гишүүний төлөөллөөс бүрдэнэ.

24.3.Аймгийн холбоог үүсгэн байгуулах хурлыг сумын холбоодын саналыг үндэслэн аймгийн Засаг дарга зохион байгуулна.

24.4.Аймгийн холбоог үүсгэн байгуулах хурлаар энэ хуулийн 22.4.1-22.4.3-т заасан асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.

24.5.Аймгийн холбоог үүсгэн байгуулах шийдвэр гарснаас хойш 30 хоногийн дотор Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу улсын бүртгэлд бүртгүүлнэ.

24.6.Аймгийн холбооны даргыг гишүүд дундаасаа нэр дэвшүүлж, Аймгийн холбооны хурлаас 3 жилийн хугацаатай сонгоно.

24.7.Аймгийн холбооны удирдлага, зохион байгуулалт, санхүүжилттэй холбоотой, энэ хуулиар зохицуулаагүй бусад асуудлыг Аймгийн холбооны дүрмээр тогтооно.

25 дугаар зүйл.Аймгийн холбооны үйл ажиллагаа

25.1.Аймгийн холбоо дараах үйл ажиллагааг явуулна:

25.1.1.сумын холбооны үйл ажиллагааг дэмжих, гишүүдийн хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах;

25.1.2.энэ хуулийн 8.2-т заасан үйл ажиллагааны хүрээнд аймгийн түвшинд баримтлах бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх саналаа аймгийн удирдлагад тавьж шийдвэрлүүлэх;

25.1.3.аймгийн төсвийн төсөл, Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэх мал аж ахуй, бэлчээр, байгаль хамгаалах арга хэмжээний талаар санал гаргах;

25.1.4.аймгийн хөгжлийн төлөвлөлтийн баримт бичигт санал гаргах.

26 дугаар зүйл.Малчин өрхийн нэгдсэн холбоо, түүний зохион байгуулалт

26.1.Аймгийн малчин өрхийн холбоод нэгдэж, улсын хэмжээнд Малчин өрхийн нэгдсэн холбоог /цаашид “Нэгдсэн холбоо” гэх/ байгуулна.

26.2.Нэгдсэн холбоонд аймгийн холбоодыг аймгийн холбооны дарга нар төлөөлнө.

26.3.Нэгдсэн холбоог үүсгэн байгуулах хурлыг аймгийн холбоодын саналд үндэслэн хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн зохион байгуулна.

26.4.Нэгдсэн холбоог үүсгэн байгуулах хурлаар энэ хуулийн 22.4.1-22.4.3-т заасан асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.

26.5.Нэгдсэн холбоог үүсгэн байгуулах шийдвэр гарснаас хойш 30 хоногийн дотор Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу улсын бүртгэлд бүртгүүлнэ.

26.6.Нэгдсэн холбооны Тэргүүнийг гишүүд дундаасаа нэр дэвшүүлж, 4 жилийн хугацаатай сонгоно.

26.7.Нэгдсэн холбооны гишүүдийн хурлыг жилд 1-ээс доошгүй удаа хуралдуулна.

26.8.Нэгдсэн холбооны удирдлага, зохион байгуулалт, санхүүжилттэй холбоотой, энэ хуулиар зохицуулаагүй бусад асуудлыг дүрмээр тогтооно.

27 дугаар зүйл.Нэгдсэн холбооны үйл ажиллагаа

27.1.Нэгдсэн холбоо дараах үйл ажиллагааг явуулна:

27.1.1.малчин, мал аж ахуй, байгалийн нөөцийн менежментийн чиглэлийн хууль тогтоомж, бодлогын баримт бичгийг боловсронгуй болгох талаар гишүүдийн саналыг нэгтгэн боловсруулж, хууль тогтоомж, бодлогын баримт бичигт тусгуулах арга хэмжээ авах;

27.1.2.нүүдлийн мал аж ахуйн уламжлалт өв соёл, заншил, мал маллах арга ухааныг сурталчлах;

27.1.3.бүс нутгийн болон олон улсын хэмжээнд ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагатай хамтран ажиллах;

27.1.4.мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэх нэгдсэн сүлжээ бий болгох талаар эрх бүхий байгууллагад санал гаргах;

27.1.5.Нэгдсэн холбооны үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг хууль тогтоомжийн хүрээнд олж бүрдүүлэх;

27.1.6.холбооны мэдээллийн нэгдсэн цахим санг бүрдүүлэх, эрхлэн хөтлөх.

28 дугаар зүйл.Малчин өрхийн холбоонд хориглох үйл ажиллагаа

28.1.Малчин өрхийн холбоо нь доор дурдсан үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

28.1.1.улс төрийн нам, улс төрийн намын байгууллагын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, тэдгээрийг санхүүжүүлэх;

28.1.2.шашин номлох, ухуулан дэлгэрүүлэх зэрэг шашны байгууллагын үйл ажиллагаа явуулах;

28.1.3.үндсэн зорилго, үйл ажиллагаагаа өөрчилж, ашгийн төлөө ажиллах, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмнөөс хөрөнгийн баталгаа гаргах.

ТАВДУГААР БҮЛЭГ БУСАД

29 дүгээр зүйл.Малчин өрхийн холбооноос төрийн байгууллага, албан тушаалтантай харилцах

29.1.Нэгдсэн холбоо нь зорилгодоо хамаарах аливаа асуудлаар бүх шатны төрийн байгууллага, албан тушаалтантай харилцах эрхтэй байна.

29.2.Аймгийн болон сумын холбоо нь орон нутгийн зохих шатны удирдлагад холбооны үйл ажиллагааны тайланг танилцуулна.

30 дугаар зүйл.Малчин өрхийн холбоонд төрөөс үзүүлэх дэмжлэг

30.1.Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын үед Анхдагч холбоонд өвс тэжээлийг хөнгөлөлтэй үнээр олгох болон бусад дэмжлэг үзүүлж болно.

30.2.Мал аж ахуйн үйлдвэрлэлд зохистой дадал нэвтрүүлэхэд залуу малчдад зориулсан сургалтын тогтолцоог бий болгох, хөгжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлнэ.

31 дүгээр зүйл.Холбоог өөрчлөх, татан буулгах

31.1.Холбоог өөрчлөх, татан буулгах асуудлыг Иргэний хуульд нийцүүлэн баталсан Холбооны дүрмээр зохицуулна.

32 дугаар зүйл.Холбооны тайлан

32.1.Холбоо нь үйл ажиллагаагаа хууль, дүрэмд заасны дагуу тайлагнана.

32.2.Холбоо үйл ажиллагааны болон санхүүгийн жилийн тайлангаа гишүүдэд нээлттэй байлгана.

32.3.Холбоо дүрэмдээ заасны дагуу үйл ажиллагаа, санхүүжилт, түүний зарцуулалтыг гишүүддээ тайлагнана.

32.4.Холбоо Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн⁸ 26 дугаар зүйлд заасны дагуу татварын тайлан гаргаж, харьяа татварын албанд тайлагнана.

32.5.Холбоо үйл ажиллагааны тайлангаа цахимаар хүргүүлж болно. Энэ тохиолдолд тайлан хүлээн авах байгууллагад мэдэгдэнэ.

32.6.Холбоо албан хэрэг хөтлөлт, архивын үйл ажиллагаандаа Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд заасан албан хэрэг хөтлөлт болон байгууллагын архивт баримтлах журмыг мөрдөнө.

33 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

33.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

33.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

34 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох хугацаа

34.1.Энэ хуулийг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

⁸ Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль. "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2019 оны 23 дугаарт нийтлэгдсэн.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ..-ны өдөр

Улаанбаатар
хот

**ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Газрын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/3 дугаар зүйлийн 3.1.11-3.1.14 дэх заалт:

“3.1.11. “малчин өрх” гэж Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 4.1.2-т заасныг;

3.1.12. “малчин өрхийн анхдагч холбоо” гэж Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 4.1.3-т заасныг;

3.1.13. “гэрээт бэлчээрийн газар” гэж малчин өрхийн анхдагч холбоонд гэрээний дагуу ашиглуулж байгаа улирлын бэлчээрийг;

3.1.14. “бэлчээрийн даац” гэж тухайн бэлчээрийн газрын ургамлын өсөлт, хөгжилт, нөхөн сэргэлтэд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр бэлчээж болох мал, амьтны тоогоор илэрхийлэгдэх бэлчээрийн чадавхийг.”

2/20 дугаар зүйлийн 20.1.6, 20.1.7 дахь заалт:

“20.1.6. тухайн орон нутгийн онцлогт тохируулж, бэлчээрийн газрыг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх журмыг батлах;

20.1.7. аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө болон сумын тухайн жилийн төлөвлөгөөнд нийцүүлэн багийн иргэдийн Нийтийн Хурлын шийдвэрийг үндэслэн малчин өрхийн анхдагч холбоонд гэрээгээр ашиглуулах бэлчээрийн газрын зааг, хэмжээ, байршлыг тогтоох.”

3/21 дүгээр зүйлийн 21.4.4, 21.4.5 дахь заалт:

“21.4.4. сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг үндэслэн бэлчээрийн газрыг малчин өрхийн анхдагч холбоонд ашиглуулах гэрээ байгуулах;

21.4.5. гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас өөр аймаг, сумын малчин өрхийн малыг бэлчээрийн даацад тохируулан малчин өрхийн анхдагч холбооны гэрээт бэлчээрийн газарт түр хугацаагаар оруулах, гаргах асуудлыг холбогдох аймаг, сумын Засаг даргатай хамтран шийдвэрлэх.”

4/23 дугаар зүйлийн 23.4.7, 23.4.8, 23.4.9 дэх заалт:

“23.4.7.бэлчээрийн даацыг сумын бэлчээр хариуцсан мэргэжилтэнтэй хамтран жил бүр тогтоох;

23.4.8.малчин өрхийн анхдагч холбоонд ашиглуулах бэлчээрийн газрын зааг, хэмжээ, байршлын зургийг үйлдэх, газрын мэдээллийн санд бүртгэх;

23.4.9.энэ хуулийн 21.4.4-т заасан гэрээг бүртгэх, гэрээт бэлчээрийн газрын ашиглалт, төлөв байдлын үнэлгээг үндэслэн сумын бэлчээр хариуцсан мэргэжилтэнтэй хамтран бэлчээр ашиглалтын гэрээний биелэлтэд тогтмол хяналт тавих, дүгнэх.”

5/52 дугаар зүйлийн 52.11, 52.12, 52.13 дахь хэсэг:

52.11.Гэрээт бэлчээрийн газрыг хашихыг хориглоно.

52.12.Малчин өрхийн анхдагч холбоонд бэлчээрийн газар ашиглуулах гэрээ байгуулах журам, гэрээний загварыг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хамтран батална.

52.13.Энэ хуулийн 52.12-т заасан гэрээг 15 хүртэл жилийн хугацаатай байгуулах бөгөөд гэрээний үүргийн биелэлтийг харгалзан анх гэрээ байгуулсан хугацаагаар сунгаж болно.”

2 дугаар зүйл.Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1, 52.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“52.1.Бэлчээрийн газрыг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх асуудлыг энэ хуульд заасан аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий болон сумын тухайн жилийн төлөвлөгөөнд үе шаттай төлөвлөж, хэрэгжүүлнэ.

52.2.Отрын бэлчээр, бэлчээр дэх уст цэг, хужир мараа бүхий газрыг нийтээр ашиглана. Бэлчээрийг талхлагдахаас хамгаалах, нөхөн сэргээх зорилгоор тухайн бүс нутгийн онцлог, бэлчээрийн даацыг харгалзан, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг үндэслэн сумын Засаг дарга малчин өрхийн анхдагч холбоонд бэлчээрийн газрыг гэрээний дагуу ашиглуулж болно.”

3 дугаар зүйл.Газрын тухай хуулийн 52.6 дахь хэсгийн “52.1-д заасан ерөнхий хуваарь,” гэснийг хассугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг 2024 оны ... дүгээр сарын ...-ны өдөр баталсан Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй:

1/22 дугаар зүйлийн 22.1.22 дахь заалт:

“22.1.22.бэлчээрийн ашиглалт, хамгаалалт.”

2 дугаар зүйл. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.5 дахь заалтын “бусдын” гэсний өмнө “малчин өрхийн анхдагч холбоонд бэлчээрийн зориулалтаар ашиглуулах газрын зааг, байршлын талаар шийдвэр гаргах,” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.13 дахь заалтын “бэлчээр” гэснийг “бэлчээрийн газрыг малчин өрхийн анхдагч холбоонд ашиглуулах гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх ажлыг зохион байгуулах,” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг 2024 оны ... дүгээр сарын ...-ны өдөр баталсан Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Малайн тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн "хэмжээг" гэсний дараа "бэлчээрийн даацыг харгалзан" гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2024 оны ... дүгээр сарын ...-ны өдөр баталсан Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ..-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8 дахь заалтын “бэлчээрийн менежментийг сайжруулах, бэлчээрийн болон” гэснийг “бэлчээрийн даац тогтоох, бэлчээрийн төлөв байдлын үнэлгээ хийх, бэлчээр ашиглалтын гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах,” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2024 оны ... дүгээр сарын ...-ны өдөр баталсан Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.29 дэх заалтын "малчин," гэсний өмнө "малчдын хоршоо" гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4 дэх заалтын хэсгийн "хувь хүн," гэснийг хассугай.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2024 оны ... дүгээр сарын ...-ны өдөр баталсан Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.9-ийн “мэрэгч” гэсний өмнө “бэлчээр хамгаалах, нөхөн сэргээх” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2024 оны ... дүгээр сарын ...-ны өдөр баталсан Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Боловсролын ерөнхий хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалтын "хамтран ажиллах, арга хэмжээ авах" гэснийг "малчин өрхийн анхдагч холбоотой хамтран ажиллах, малчин өрхийн гишүүнийг насан туршийн суралцахуйн сургалтад хамруулах" гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2023 оны ... дүгээр сарын ...-ны өдөр баталсан Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ..-ны өдөр

Улаанбаатар
хот

ХОРШООНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хоршооны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь заалтын “хоршооны өөрийн хөрөнгийн 15 хувиас” гэснийг “анхан шатны хоршооны өөрийн хөрөнгийн 15 хувь, дундын хоршооны өөрийн хөрөнгийн 49 хувиас” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Хоршооны тухай хуулийн 36.6 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2024 оны ... дүгээр сарын ...-ны өдөр баталсан Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

УСНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Усны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2 дахь заалтын "оролцуулах" гэсний дараа ", малчин өрхийн анхдагч холбоотой хамтран ажиллах" гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2024 оны ... дүгээр сарын ...-ны өдөр баталсан Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

АМЬТНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7.1 дэх заалтын “тусган” гэсний дараа “, малчин өрхийн анхдагч холбоотой хамтран” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2024 оны ... дүгээр сарын ...-ны өдөр баталсан Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

БАЙГАЛИЙН УРГАМЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Байгалийн ургамлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн "сумын сум, баг, дүүрэг, хорооны Засаг дарга" гэсний дараа "холбогдох хуульд заасны дагуу" гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2024 оны ... дүгээр сарын ...-ны өдөр баталсан Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ..-ны өдөр

Улаанбаатар
хот

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалтын "чиглүүлж" гэсний дараа ", малчин өрхийн анхдагч холбоотой хамтран ажиллах," гэж , 32 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "байгуулагдсан" гэсний дараа "малчин өрхийн холбоо зэрэг" гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2024 оны ... дүгээр сарын ...-ны өдөр баталсан Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТОГТООЛД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын 2011 оны “Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” 30 дугаар тогтоолын 2 дахь заалтын 1, 2 дахь дэд заалтын “малчин” гэсний өмнө “хоршооны гишүүн” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ тогтоолыг 2024 оны ... дүгээр сарын ...-ны өдөр баталсан Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны ... дугаар
сарын ..-ны өдөр

Улаанбаатар
хот

ТОГТООЛД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын 2012 оны "Малчид, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай" 74 дүгээр тогтоолын 2 дахь заалтын 1, 2, 3 дахь дэд заалтын "малчин" гэсний өмнө "хоршооны гишүүн" гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ тогтоолыг 2024 оны ... дүгээр сарын ...-ны өдөр баталсан Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МАЛЧИН ӨРХИЙН ХОЛБООНЫ ЭРХ ЗҮЙН
БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ,
ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛСАН
СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

Улаанбаатар хот
2024 он

АГУУЛГА

НЭГ. Асуудалд дүн шинжилгээ хийх

- 1.1. Тулгарч байгаа асуудал, түүний мөн чанар, цар хүрээ
- 1.2. Тухайн асуудал үүссэн шалтгаан нөхцөл

ХОЁР. Асуудлыг шийдвэрлэх зорилго

- 2.1. Гол зорилго, зорилт

ГУРАВ. Асуудлыг зохицуулах хувилбарууд, тэдгээрийн зэрэг болон сөрөг талын харьцуулалт

- 3.1. Асуудлын зохицуулалтын хувилбаруудыг тогтоох

ДӨРӨВ. Зохицуулалтын хувилбаруудын үр нөлөөний талаар

- 4.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө
- 4.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө
- 4.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө
- 4.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө
- 4.5. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжид нийцсэн байдал

ТАВ. Зөвлөмж

Энэхүү үнэлгээний ажлын зорилго нь Хууль тогтоомжийн тухай хуулийн¹ 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтад “энэ хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах,” гэж заасны дагуу Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуульд нийцэх эсэхийг судлан тухайн асуудлыг хууль тогтоомжоор зохицуулах шаардлагатай эсэхийг тодорхойлох, тухайн асуудлыг зохицуулах эрх зүйн хэм хэмжээг тодорхойлох, зохицуулах эрх зүйн хэм хэмжээний эерэг болон сөрөг талыг харьцуулан судлах, хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг урьдчилан тооцсоны үндсэн дээр тухайн асуудлыг шийдвэрлэх үр дүнтэй хувилбарыг тодорхойлох зэрэг асуудлыг судалж зөвлөмж өгөхөд оршино.

Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн /цаашид “Хуулийн төсөл” гэх/ үр нөлөөг үнэлэх ажиллагааг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын² нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-г баримтлан хийв.

¹ Төрийн мэдээлэл сэтгүүлийн 2015 оны №25 дугаарт албан ёсоор хэвлэгдсэн.

² Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 59 дүгээр тогтоолоор батлагдсан.


НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ

1.1. Тулгарч байгаа асуудал, түүний мөн чанар, цар хүрээ

Манай улс нүүдлийн мал аж ахуйн өв уламжлалаа хадгалж авч үлдэхийн үндэс нь малчин, мал, бэлчээр гурвын харилцан шүтэлцээг хангах буюу малчин өрхүүдийн хамтын ажиллагааг дэмжих замаар бэлчээрийн доройтлоос хамгаалах, малыг эрүүлжүүлэх, үүлдэр угсааг сайжруулах, нутаг орны байгалийн нөөцийг малчдын оролцоонд суурилан хамгаалах асуудал болоод байна.

Улсын Их Хурлын 2009 оны 39 дүгээр тогтоолоор баталсан “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-д малчдын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, тэдний эрүүл мэнд, нийгмийн хамгааллыг сайжруулах, нийгмийн даатгалын тогтолцоонд хамруулах, мэдлэг, чадварыг дээшлүүлэх, хүч, хөдөлмөрөө хоршихыг урамшуулах, бэлчээрийн мал аж ахуйг эрхлэн хөтлөх аргыг боловсронгуй болгох замаар малчдын тав тухтай амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэх, мал аж ахуйг эрсдэл багатай, баталгаатай хөгжүүлэхээр заасан боловч уг бодлогын хэрэгжилтэд Хүнс, хөдөө аж ахуйн яамны захиалгаар Байгаль орчин, хөдөө аж ахуйн эдийн засгийн хүрээлэн” ТББ-аар 2019 онд хийлгэсэн хөндлөнгийн үнэлгээгээр хэрэгжилт хангалтгүй дүнтэй гарчээ.

Зураг 1. "Төрөөс малчдын талаар баримтлах бодлого"-ын хэрэгжилт



Байгаль орчин, хөдөө аж ахуйн эдийн засгийн хүрээлэн” ТББ-аас хийсэн “судалгаанд хамрагдсан малчдын 40.9% нь тус бодлогыг “Маш муу, муу” гэж үнэлж байна. Учир нь төр засгаас тус бодлогыг хэрэгжүүлэх ажлыг орон нутагт хангалттай зохион байгуулдаггүй, мөнгө санхүү дутмаг зэрэг болно” гэжээ.

Мал аж ахуй нь Монгол улсын нийгэм, эдийн засгийн тогтвортой байдал, хэтийн хөгжилд чухал үүрэг рольтой салбар юм. Мөн тус салбар хүнс, хөнгөн үйлдвэрлэлийн түүхий эдийг бэлтгэн нийлүүлэгч [44] ба Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах чухал үүрэгтэй эдийн засаг, нийгмийн хөгжлийн суурь салбарын нэг юм.

Мал аж ахуйн салбар нийт газар нутгийн 72.1 хувийг ашиглаж, ДНБ-ны 10.52 хувийг үйлдвэрлэж байгаа эдийн засгийн хоёр дахь том салбар бөгөөд нийт ажиллах хүчний хамгийн их буюу 21.6 хувийг өөртөө шингээж байна. 2019 оны байдлаар улсын хэмжээнд нийт 894.5 мянган өрхөөс 304.1 мянган өрх буюу 34 орчим хувь нь хөдөөд суурьшиж байна. Үүнээс 19 орчим хувь буюу 169.7 мянган малчин өрх мал аж ахуйн салбараас хамааралтай амьдарч байна³.

Аймгуудын бэлчээрийн даацыг Архангай, Баянхонгор аймгаар жишээ болгож Ш.Сэржхүү, С.Цэрэндаш нарын "Монгол орны бэлчээрийн даац, нөхцөлтэй уялдан өсгөж үржүүлэх мал сүргийн тоог зохистой хэмжээнд тогтоох" тухай тооцоо судалгааны тайлан (2018 он)-аас тооцоолоход Архангай аймгийн хувьд:


Архангай аймгийн бэлчээрийн даацад тохирсон малын тоо, сумдаар



Сумын нэр	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямал	Бүгд
Батцэнгэл	39	12579	13674	87294	40553	154129
Булган	-	4955	15209	15896	15029	51090
Жаргалант	-	4835	10375	48604	28240	92054
Их тамир	35	10395	23207	69164	34887	137689
Өгийнуур	448	5789	7723	62075	35125	112160
Өлзийт	310	7735	7222	66941	34831	117039
Өндөр-Улаан	-	10694	22321	72936	27798	133799
Тарват	-	5851	16953	54203	24870	101876
Төвшрүүлэх	-	4271	5944	28371	21042	59628
Хайрхан	-	11598	10119	86655	34754	143126
Хангай	-	3698	13030	15654	9671	42053
Хашаат	462	8291	6182	75893	40469	131286
Хотонт	-	11675	11546	60366	45734	129320
Цахир	-	2477	8510	21184	10540	42711
Цэнхэр	23	11601	19342	55626	35015	121607
Цэцэрлэг	10	6050	6694	73469	37654	123877
Чулуут	-	5775	20078	34312	14701	74865
Эрдэнэбулган	23	6211	10287	37620	22747	76888
Эрдэнэмандал	33	10871	13037	126210	37534	187686
Дүн	1383	146350	241453	1092501	551195	2032882

Архангай аймгийн бэлчээрийн малын тоог дээрх бэлчээрийн даацын тоотой харьцуулбал ойролцоогоор 3 дахин хэтэрсэн байх бөгөөд энэ үзүүлэлт цаашид улам муудах төлөвтэй байна⁴.

Архангай аймгийн нийт даац хэтрэлт



Архангай аймгийн нийт даац хэтрэлт : current

³ М.Алтанбагана, Сумдын хүн ам, нийгэм, шилжилт хөдөлгөөн, эдийн засгийн потенциалийн үнэлгээ, бодлогын зөвлөмж, судалгааны тайлан 2023

⁴ Б.Ууганбаяр, Монгол Улсын 21 аймаг, 330 сумдын нийгэм, эдийн засгийн төлөв байдлын системийн анализ

Архангай аймгийн малчдын тоог харвал:

Аймаг, сум	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
Архангай	26591	26915	27474	27055	25756	25688	25907	27017	26700
Эрдэнэбулган	1037	1128	1106	921	933	982	975	1223	1190
Батцэнгэл	1408	1447	1440	1382	1412	1362	1396	1478	1443
Булган	781	826	869	939	872	896	919	971	967
Жаргалант	1747	1769	1758	1643	1628	1698	1660	1678	1663
Их тамир	1949	1963	1981	1899	1760	1833	1863	1898	1859
Өгийнуур	1060	1065	1087	1147	1162	1169	1154	1173	1149
Өлзийт	964	1024	1039	976	891	943	892	958	908
Өндөр-Улаан	2117	2096	2157	2095	2037	1968	2099	2031	2009
Тариат	1588	1570	1705	1697	1704	1718	1640	1680	1651
Төвшрүүлэх	898	882	884	896	873	828	829	829	787
Хайрхан	1380	1397	1424	1405	1256	1252	1341	1390	1376
Хангайн бүс	1063	1073	1148	1154	1094	1098	1102	1106	1030
Хашаат	1197	1180	1170	1123	1079	1051	1031	1149	1189
Хотонт	1609	1640	1590	1618	1581	1520	1526	1587	1567
Цахир	703	738	859	823	782	758	833	881	859
Цэнхэр	2026	2121	2210	2288	2163	2144	2132	2262	2343
Цэцэрлэг	1567	1546	1485	1553	1464	1450	1417	1463	1405
Чулуут	1340	1309	1368	1312	1295	1231	1198	1350	1336
Эрдэнэмандал	2157	2141	2194	2184	1770	1787	1900	1910	1969

Архангай аймгийн малчдын өсөлтийг авч үзвэл:

Аймаг, сум	2014-2018 он	2018-2022 он
Архангай	-3.14%	3.67%
Эрдэнэбулган	-10.03%	27.55%
Батцэнгэл	0.28%	2.20%
Булган	11.65%	10.89%
Жаргалант	-6.81%	2.15%
Их тамир	-9.70%	5.63%
Өгийнуур	9.62%	-1.12%
Өлзийт	-7.57%	1.91%
Өндөр-Улаан	-3.78%	-1.37%
Тариат	7.30%	-3.11%
Төвшрүүлэх	-2.78%	-9.85%
Хайрхан	-8.99%	9.55%
Хангайн бүс	2.92%	-5.85%
Хашаат	-9.86%	10.19%
Хотонт	-1.74%	-0.89%
Цахир	11.24%	9.85%

Цэнхэр	6.76%	8.32%
Цэцэрлэг	-6.57%	-4.03%
Чулуут	-3.36%	3.17%
Эрдэнэмандал	-17.94%	11.24%

Дээрх графикаас харахад нийт Архангай аймгийн хэмжээнд 2014-2022 онуудад малчдын тоо 3.14%-иар буурсан, харин 2018-2022 онуудад 3.67%-иар өссөн. 2014-2018 онуудад Эрдэнэмандал сум хамгийн ихдээ 17.94%-иар буурсан байна, харин 2018-2022 онуудад Эрдэнэбулган сум хамгийн ихдээ 27.55%-иар өссөн байна.

Эндээс Архангай аймгийн малчин өрхийн тоог харвал:


Аймаг, сум	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
Архангай	13858	14126	14436	15160	14978	15236	15527	16165	16170
Эрдэнэбулган	552	594	566	598	583	691	656	812	790
Батцэнгэл	813	827	837	868	879	872	926	925	902
Булган	430	457	483	544	524	549	559	564	577
Жаргалант	857	859	861	888	874	881	874	909	879
Их тамир	988	1014	1010	1003	1019	1054	1071	1104	1121
Өгийнуур	572	574	586	656	676	697	697	705	713
Өлзийт	520	561	578	580	583	609	627	664	638
Өндөр-Улаан	1070	1065	1061	1094	1126	1160	1167	1186	1193
Тариат	814	811	892	917	932	942	906	953	938
Төвшрүүлэх	494	489	492	537	530	522	542	531	509
Хайрхан	711	730	743	792	788	774	812	848	855
Хангайн бүс	530	536	584	626	601	615	620	619	601
Хашаат	639	644	641	638	626	631	650	679	734
Хотонт	885	897	879	952	957	920	930	962	974
Цахир	364	387	466	456	441	433	490	534	528
Цэнхэр	1036	1093	1142	1211	1204	1208	1272	1361	1386
Цэцэрлэг	773	777	763	842	863	858	862	862	856
Чулуут	693	683	710	717	718	723	730	768	757
Эрдэнэмандал	1117	1128	1142	1241	1054	1097	1136	1179	1219

Баянхонгор аймгийн хувьд:

Баянхонгор аймгийн бэлчээрийн даацад тохирсон малын тоо, сумдаар

Сумын нэр	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	Бүгд
Баацагаан	3082	7008	5667	52139	187330	255227
Баянбулаг	11	3761	5661	50208	35532	95172
Баянговь	4309	3379	1027	22991	134879	166585
Баянлиг	21673	3066	1054	25668	128839	180390
Баян-Овоо	421	6307	5691	86066	76475	174960
Баян-Өндөр	4815	1725	393	23147	121688	151768
Баянхонгор	239	5678	16789	41213	57902	121821
Баянцагаан	1934	4021	1619	50010	146359	203943
Богд	5927	4948	5016	30566	119576	166033
Бөмбөгөр	291	8445	4898	52335	130923	196852
Бууцагаан	2303	8336	5863	56478	147198	220183
Галуут	102	13540	23347	90270	74717	201975
Гурванбулаг	42	8538	11957	59756	35746	116039
Жаргалант	4	8922	20450	50640	38324	118340
Жинст	2522	4840	1847	35510	112160	156879
Заг	185	7212	7291	52643	49000	116331
Өлзийт	343	10535	10956	64435	101789	188059
Хүрээмарал	550	7128	5110	69064	74914	155766
Шинэжинст	5595	1721	244	16866	121607	146034
Эрдэнэцогт	-	8599	35517	50213	41885	136214
Дүн	54349	127711	170402	979218	1936842	3268522

Баянхонгор аймгийн бэлчээрийн малын тоог Ш. Сэржхүү нарын бэлчээрийн даацын тоотой харьцуулбал:



Баянхонгор аймгийн малчдын тоог харвал:

Аймаг, сум	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
Баянхонгор	20962	21062	21990	22255	21784	21771	23212	23168	22560
Баянхонгор	867	774	847	860	799	740	993	1013	1030
Баацагаан	1439	1430	1408	1388	1328	1334	1456	1459	1379
Баянбулаг	417	434	448	469	510	500	505	507	526
Баянговь	936	1002	1028	1045	1078	1099	1212	1192	1143
Баянлиг	1306	1324	1371	1443	1358	1360	1428	1441	1465

Баян-Овоо	819	864	944	841	797	654	859	909	932
Баян-Өндөр	877	900	918	942	963	934	975	974	875
Баянцагаан	1156	1187	1251	1264	1200	1166	1296	1273	1176
Богд	1204	1265	1308	1227	1195	1191	1242	1167	1137
Бөмбөгөр	1239	1260	1270	1322	1311	1356	1339	1325	1312
Бууцагаан	1363	1333	1347	1393	1359	1330	1403	1433	1399
Галуут	1463	1406	1692	1563	1546	1678	1762	1758	1715
Гурванбулаг	669	686	716	721	739	782	827	797	776
Жаргалант	1026	939	1034	1148	1037	1108	1068	1166	1107
Жинст	869	882	863	945	930	992	1003	984	921
Заг	740	711	738	789	769	739	776	776	770
Өлзийт	1611	1640	1636	1651	1668	1564	1635	1575	1545
Хүрээмарал	606	611	643	644	620	614	623	645	628
Шинэжинст	754	805	839	855	868	903	983	964	967
Эрдэнэцогт	1601	1609	1689	1745	1709	1728	1827	1811	1757

Баянхонгор аймгийн малчдын тооны өсөлтийг авч үзвэл:

Аймаг, сум	2014-2018 он	2018-2022 он
Баянхонгор	3.92%	3.56%
Баянхонгор	-7.84%	28.91%
Баацагаан	-7.71%	3.84%
Баянбулаг	22.30%	3.14%
Баянговь	15.17%	6.03%
Баянлиг	3.98%	7.88%
Баян-Овоо	-2.69%	16.94%
Баян-Өндөр	9.81%	-9.14%
Баянцагаан	3.81%	-2.00%
Богд	-0.75%	-4.85%
Бөмбөгөр	5.81%	0.08%
Бууцагаан	-0.29%	2.94%
Галуут	5.67%	10.93%
Гурванбулаг	10.46%	5.01%
Жаргалант	1.07%	6.75%
Жинст	7.02%	-0.97%
Заг	3.92%	0.13%
Өлзийт	3.54%	-7.37%
Хүрээмарал	2.31%	1.29%
Шинэжинст	15.12%	11.41%
Эрдэнэцогт	6.75%	2.81%

Баянхонгор аймгийн малчдын өсөлт бууралтыг харвал 2014-2018 онуудад 3.92%-иар өссөн, 2018-2022 онуудад мөн 3.56%-иар өссөн байна. Баянхонгор аймгийн Баянхонгор сум нь 2014-2018 онуудад хамгийн өндөр бууралттай буюу

7.84%-иар буурсан, харин 2018-2022 онуудад хамгийн өндөр өсөлттэй буюу 28.91%-иар өссөн байна.

Баянхонгор аймгийн малчин өрхийн тоо

Аймаг, сум	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
Баянхонгор	10614	10607	11171	11821	11920	12011	12918	13131	13112
Баянхонгор	463	408	440	485	488	470	608	630	654
Баацагаан	712	707	703	751	746	737	801	819	800
Баянбулаг	199	207	213	240	253	258	267	269	283
Баянговь	493	514	524	558	595	606	672	669	677
Баянлиг	653	657	674	734	696	708	778	759	794
Баян-Овоо	461	497	547	514	514	456	536	568	599
Баян-Өндөр	430	439	454	474	480	460	505	521	501
Баянцагаан	583	595	617	676	667	630	732	679	629
Богд	636	652	675	682	669	662	660	650	637
Бөмбөгөр	623	641	652	726	733	762	799	816	829
Бууцагаан	667	635	655	723	758	782	786	803	804
Галуут	734	697	871	839	830	870	943	972	963
Гурванбулаг	318	322	361	379	397	410	458	453	442
Жаргалант	536	468	533	610	591	629	612	687	662
Жинст	430	442	438	480	484	499	513	511	496
Заг	375	366	381	422	419	415	435	445	448
Өлзийт	813	832	840	858	878	879	911	908	912
Хүрээмарал	305	315	317	336	327	349	365	388	390
Шинэжинст	385	411	426	462	477	503	566	596	594
Эрдэнэцогт	798	802	850	872	918	926	971	988	998

1.2. Тухайн асуудал үүссэн шалтгаан нөхцөл

Дэлхийн нийтээр гарч буй цаг уурын өөрчлөлттэй нягт холбогдон Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд байгаль цаг уур, уур амьсгалын нөхцөл хүндэрсэн нь бэлчээрийн даац хэтрэх, үүнээс улбаалан цөлжилт үүсэх явдал тасралтгүй үргэлжилж байгааг олон улсын мэргэжлийн байгууллагаас өгсөн үнэлгээнд тодорхой заажээ. Тухайлбал, Уур амьсгалын өөрчлөлтийн 3-р тайлангийн хүрээнд усны нөөц, ойн нөөц, цэвдэг, зэрлэг амьтан, бэлчээр-хөрс, байгалийн гамшиг зэрэг экосистем, байгалийн бүрэлдэхүүн хэсэг, газар тариалан, мал аж ахуй, хүний эрүүл мэнд зэрэг нийгэм эдийн засгийн гол салбаруудаар уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийн тоон үнэлгээг дэлхийн болон бүс нутгийн уур амьсгалын динамик загварын үр дүнг ашиглан хийсэн (TNC, 2018) байна.

Цаг агаарын эрс тэс уур амьсгал, хэт халалтаас шалтгаалан газрын доройтол, цөлжилт нэмэгджээ. Тодруулбал, Монгол орны газар нутгийн хэмжээ 76,8 хувь нь дунд болон хүчтэй цөлжилтөд өртжээ.⁵

⁵ <https://www.ub.life/p/27688>

Монгол Улсын хэмжээнд салбаруудын өнөөгийн байдал “эмзэг” гэсэн ангилалд багтаж байгаа бөгөөд цаашид 2046-2065 оны үед “их эрсдэлтэй” гэсэн ангилалд орохоор төсөөлөгдөж байна.⁶

Үнэлгээнд ашиглагдсан эмзэг байдал болон эрсдэлийн ангиллын босго утга

№	Доод босго утга	Ангилал Өнөөгийн/ирээдүйн	Дээд босго утга
1	0.81<	Маш их эмзэг/эрсдэлтэй	<1.00
2	0.61<	Их эмзэг/ эрсдэлтэй	<0.80
3	0.41<	Эмзэг/ эрсдэлтэй	<0.60
4	0.21<	Бага эмзэг/ эрсдэлтэй	<0.40
5	0.00<	Эмзэг/ эрсдэлтэй биш	<0.20

Иймд мал аж ахуйн онцлогоос хамаарч малчин өрхүүд айл саахалт нутаглаж хөдөлмөр, хүчээ хорших замаар малаа маллаж, байгаль цаг уурын хүндрэл бэрхшээлийг даван туулж ирсэн уламжлалыг орчин үеийн техник ,технологийн хөгжил, мэдлэгтэй хоршин хөгжүүлэх шаардлага өнөөдөр нэгэнт тулгараад байна.

Малчин өрхүүд үе дамжин нутаглаж ирсэн нутаг усаараа нэгдэж, зах зээлд мал аж ахуйн болон бусад үйлчилгээг тогтвортой нийлүүлэх замаар ашиг орлогоо нэмэгдүүлэх, хамтдаа санхүүгийн болон технологийн хөрөнгө оруулалт хийх зэргээр амьжиргаагаа дээшлүүлэх боломжийг төрөөс олгох шаардлагатай байна. Энэ нь малчин өрхүүд хамтдаа зардал багатайгаар борлуулалт хийх, түүхий эдийн тогтвортой, баталгаатай нийлүүлэгч болох, эрх ашгаа хамгаалах, соёл, уламжлалаа хадгалах, олон талуудтай хамтран ажиллах, хөгжих, тэгш эрх, боломжийг бий болгох, нийгмийн асуудлаа шийдвэрлэх зэрэг олон давуу талуудыг бий болгох юм. Эдгээр эдийн засаг, нийгмийн асуудлаас гадна амьдарч буй нутаг усныхаа бэлчээр, байгалийн нөөцийг тогтвортой хамгаалж, ашигласнаар урт удаан хугацааны тогтвортой амьжиргаа, амьдралын нөхцөлөө сайжруулах боломжийг бүрдүүлэх шаардлага тулгараад байна.

Нутгийн иргэдэд түшиглэсэн байгаль хамгаалал олон улсын сайн туршлагын нэг болох нь гадаад орнуудад батлагдаад байгаа билээ. Энэ нь Беркес болон Фикрет нарын (2007) тодорхойлсноор “нутгийн иргэд зохион байгуулалтад орж, өөрсдийн амьдарч буй хүрээлэн буй орчны байгалийн нөөцийг орон нутгийн түвшинд хамтдаа тогтвортой ашиглах, хамгаалах үйл хэрэг” юм. Малчин өрхийн амьжиргааны эх үүсвэр нь байгалийн нөхөн сэргээгдэх нөөцтэй шууд хамааралтай байдаг учраас малчин өрхийн амьжиргаа, байгалийн нөөц хоёрын харилцан уялдааг хангаж, тогтвортой амьжиргааны эх үүсвэрээ нэмэгдүүлэх боломжийг бий болгох нь зайлшгүй чухал байна.

Монгол Улсын нийт газар нутгийн 70,1 хувийг бэлчээрийн газар эзэлж, энэхүү газар нутаг дээр манай улсын эдийн засаг, нийгэмд томоохон үүрэг гүйцэтгэдэг мал

⁶ <http://climate-service.mn/climateservice/index.php?menuitem=2&product=24>

аж ахуйн салбарын үйлдвэрлэл явагдаж байна. Гэвч сүүлийн 30 орчим жилд газрын харилцаа, тэр дундаа бэлчээрийн газрын ашиглалт, хамгаалалтыг төлөвлөх, хэрэгжилтэд хяналт тавих асуудал хангалтгүй байснаас сэлгэн нүүдэллэж, бэлчээрийг хуваарьтай ашиглаж ирсэн олон мянган жилийн уламжлал алдагдаж байна. Газрын тухай хуулийн бэлчээрийг нийтээр, дундаа ашиглах зохицуулалт нь урт хугацаандаа бэлчээрийг доройтуулж, талхлах муу үр дагаварт хүргэж байна. Малын тоо толгойн татвар бэлчээрийн даацад малын тоог тохируулах, бэлчээрийг хамгаалах механизм болж чадахгүй байгаагаас үнэгүй шахам бэлчээрт малаа өсгөж, ашиг хүртэх сонирхол давамгайлснаас чанарт бус тооны өсөлтөд илүү анхаарч, байгалийн жамаар бэлчээр нөхөн сэргэх боломжийг олгохгүй байна. Түүнчлэн бэлчээрийг нийтээр ашиглах нь бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх ажиллагаанд хөрөнгө оруулалт хийх сонирхолгүй болгож байгаа явдал ажиглагдаж байна.

Үүний уршгаар нийт бэлчээрийн газар нутгийн 65.0 хувь доройтож, 13.0 хувь цөлжилтөд өртөөд байна.⁷ Хязгаарлагдмал нөөцийг хэмжээнээс хэтрүүлэн зохицуулалтгүй ашиглах нь байгаль экологийн тэнцвэрт байдалд аюул учруулахаас гадна малын гаралтай органик бүтээгдэхүүн үйлдвэрлэх, нэмүү өртөг бий болгох, экспортлох боломжийг хязгаарлаж, улмаар монголчуудын нүүдлийн мал аж ахуйт соёл иргэншил, уламжлалт өв соёлоо алдах эрсдлийг дагуулж байна.

Манай улсын бэлчээрийн хэвийн даац хонин толгойд шилжүүлснээр 86 сая мал байхад тохиромжтой гэж үздэг ч энэ үзүүлэлт 2022 оны жилийн эцсийн мал тооллогоор тооцоход 120,7 саяд хүрсэн⁸ ба бэлчээрийн доройтлын түвшин аймаг, сум, баг тус бүрт харилцан адилгүй байгааг судлаачид тогтоосон байна. Бэлчээр ашиглалтын ачааллын өнөөгийн горимыг зохицуулж чадвал нийт доройтсон бэлчээрийн 80 гаруй хувь нь байгалийн аясаар сэргэх боломжтой⁹ гэж судлаачид үздэг.

Бэлчээр ашиглагчид болох малчин, мал бүхий иргэн, малчин өрх, тэдний хамтын зохион байгуулалтын хэлбэр, эрх зүйн статус тодорхойгүй, бэлчээрийн ашиглалт, хамгаалалтын талаар сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгадаггүй, бэлчээрийн газрын ашиглалт, хамгаалалтад төрийн оролцооны чиг үүрэг, хяналт тодорхойгүй, оновчтой бус байна. Бэлчээрийн газар нь мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой эрхлэх суурь асуудал, хөгжлийн үндэс тул түүнийг зүй зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх асуудлыг хариуцах эзэнтэй болгож, хариуцлагажуулах нь нэн чухал байна.

"Төрөөс малчдын талаар баримтлах бодлого"-д малчдад тулгамдаж буй нийгмийн олон асуудлыг шийдвэрлэх бодлогын чиглэлүүд тусгагдсан боловч тэдгээрийг хэрэгжүүлэх, хэрэгжүүлсний дараа хянах, үнэлэхэд хэд хэдэн бэрхшээл тулгарч байна. Судалгаанд хамрагдсан малчдын үзэж байгаагаар тус бодлогын нөлөөгөөр, тэтгэвэр, тэтгэмж нэмэгдсэн, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамрагдалт нэмэгдсэн, мөн малжуулах төсөлд хамрагдсан байна. Гэхдээ ерөнхий үнэлгээгээр тус бодлогын хэрэгжилтийг "муу" гэж үнэлэв.¹⁰

⁷ Газрын нэгдмэл сангийн тайлан, 2021 он

⁸ <https://www.1212.mn>

⁹ С.Цэрэндаш нар, УБ, 2006 он

¹⁰ "Төрөөс малчдын талаар баримтлах бодлого"-ын хэрэгжилтийн хөндлөнгийн үнэлгээний тайлан

Түүнчлэн малчдыг тав, тухтай амьдрах орчныг бүрдүүлэх ажлууд хамгийн өндөр буюу 68%-ийг хэрэгжилттэй байгаа бол үр ашигтай МАА эрхлэх ажлуудын гүйцэтгэл 54% байна гэж уг тайланд дурдсан байна.

Мал аж ахуйн салбарын цаашдын тогтвортой хөгжлийг хангахын тулд цогц арга хэмжээг оновчтой авч хэрэгжүүлэхээр "Монгол мал" үндэсний хөтөлбөрийг 2010 онд УИХ-ын 23-р тогтоолоор баталсан. Энэ хөтөлбөр нь ерөнхийдөө уур амьсгал, байгаль экологийн өөрчлөлтөд дасан зохицсон мал аж ахуйг хөгжүүлж, эдийн засгийн эргэлтийг хурдасгах зорилго тавьсан ч малын тоо бэлчээрийн даацаас хэтэрсэн нь бэлчээрийг улам доройтуулсаар байна.

Өнгөрсөн 30-аад жилийн хугацаанд манай орны хөдөө аж ахуйн салбарт зарим эерэг өөрчлөлт гарсны зэрэгцээ сөрөг хандлагууд ч мэдэгдэхүйц ажиглагдах болсон тухай зарим судлаачид тэмдэглэсэн байна¹¹. Үүнд:

- бэлчээрийн газар зөвхөн тооны хувьд төдийгүй чанарын хувьд ч буурах хандлагатай болсон;
- мал сүргийн тооны хэт өсөлт нь бэлчээрийн даацыг хэтрүүлэхэд хүргэж, улмаар хүрээлэн буй орчны доройтолд сөрөг нөлөө үзүүлэх болсон;
- нэг малаас авах ашиг шимийн хэмжээ үндсэндээ өөрчлөгдөөгүй, зарим талаар буурах хандлагатай болсон;
- мал аж ахуй эрхэлдэг өрхийн аж ахуйнууд хэмжээний хувьд хэт жижиг, өрсөлдөх чадвар нь сул;
- малчин өрхийн аж ахуйн орлогын эх үүсвэр нь үндсэндээ малын тооноос хамаардаг, тэр нь байгаль цаг уурын эрсдэлээс хараат хэвээр байна;
- хөдөө аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэл, нийлүүлэлтийн хуучин тогтолцоо устаж, түүний оронд зүгширсэн оновчтой сүлжээ одоо хүртэл бүрдээгүй байна;
- мал сүргийн халдварт болон гоц халдварт өвчний дэгдэлт буурахгүй байгаа нь мал аж ахуйн бүтээгдэхүүний экспортыг хязгаарлагч хүчин зүйл болж ирсэн;
- дэлхий дахины дулааралтай холбоотой уур амьсгалын өөрчлөлт нь бүх оронд ямар нэг хэмжээгээр илрэн гарч байгаа бөгөөд тэр нь хүрээлэн буй орчинд сөрөг, эерэг байдлаар өөрчлөгдөж, улмаар нийгэм, эдийн засгийн хөгжилд ч нөлөөлөх болно. Монгол Улсын бэлчээрийн мал аж ахуй салбар нь улам бүр тогтворгүй шинжтэй системийн төлөв байдалд шилжиж байгааг дотоод, гадаадын олон эрдэмтэн, судлаачид тэмдэглэн бичсэн байдаг. Үүний гол шалтгаан нь нэг талаар уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөлд зуд зэрэг байгалийн гамшигт нэрвэгдэх эмзэг байдал нь улам нэмэгдэж байгаагаар; нөгөө талаар малчид бэлчээрийн нөөцийг зүй зохисгүй ашиглаж, байгалийн төлөв байдлыг улам доройтуулж байгаагаар тайлбарладаг. Мал аж ахуйн хөгжлийн тогтворгүй байдлыг засаж сайжруулах гол

¹¹ А.Бакей, Мал аж ахуйн хөгжлийн бодлогын өөрчлөлт, шинэчлэлийн чиглэл 2023 он

нөхцөлүүдийн нэг нь малын тоо толгойг бэлчээрийн даацад нийцүүлэн өсгөж, бэлчээрийн доройтлыг бууруулах арга зам мөн.

Мал аж ахуйн бодлого, эрх зүйн шинэчлэлийг дараах гол таван чиглэлээр цогцоор авч үзэж хэрэгжүүлэх шаардлагатай байна¹².

1. Шинэчлэлийн хамгийн эхний гол чиглэл бол тус салбарын хөгжлийн суурь хүчин зүйл болох бэлчээрийг хамгаалах, зохистой ашиглах асуудал мөн. Үүний тулд малын тоог бэлчээрийн даацад нийцүүлэх нь гол шалгуур болно. Иймд бэлчээр ашиглагч - малчдын урт хугацаанд эзэмшин ашиглах өвөлжөө-хаважааны бэлчээрийн хил зааг тодорхой байх нь чухал.
2. Малчдын хандлага, хариуцлагыг дээшлүүлэх нь хоёр дахь тэргүүлэх чиглэл мөн. Үүний тулд мөн хариуцлагатай малчинд тавигдах шалгуурыг тодорхой болгож, малынхаа тоог бэлчээрийн даацад нийцүүлэх, байгалийн гамшиг, зудын бэрхшээлийг даван туулах наад захын бэлтгэлээ өөрөө хангадаг байх, үйлдвэрлэлдээ шинэ арга технологи, инновац нэвтрүүлэх, бүтээмжээ дээшлүүлэх зэрэг шалгуур тавигдана. Эдгээр асуудлыг экстейншний тогтвортой үйлчилгээг бүрдүүлж, түүгээр дамжуулан хэрэгжүүлэх бодлого баримтлах нь зүйд нийцнэ.
3. Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн тогтвортой байдлын шалгуур тогтоож, тодорхой хугацаанд үнэлж бодлогын бусад асуудлыг түүнтэй уялдуулан хэрэгжүүлэх шаардлагатай байна. Тогтвортой байдлын шалгуур нь экологи, эдийн засаг, нийгмийн хариуцлагын бүрэлдэхүүн хэсэгтэй байх бөгөөд тус бүрийг нь хэмжигдэхүйц шалгуур үзүүлэлтээр үнэлнэ.
4. Малчдад төрөөс үзүүлж буй татаас, урамшуулал, татварын хөнгөлөлт зэрэг эдийн засгийн хөшүүргүүдийг боловсронгуй болгож, тодорхой шалгуур хангасан нөхцөлд л олгох зарчимд шилжих нь зүйтэй. Малынхаа тоог бэлчээрийн даацад нийцүүлсэн, малын чанар, ашиг шимийг дээшлүүлсэн, үйлдвэрлэлдээ байгальд ээлтэй арга технологи нэвтрүүлсэн байх гэх мэт тодорхой шалгуурыг хангасан эсэхийг үнэлж байж дэмжлэг үзүүлэх болно.
5. Мал аж ахуйн хөгжлийн бодлогын орчныг шинэчлэх тав дахь гол чиглэл бол мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний эдийн засгийн эргэлтийг хурдасгах замаар нэг талаар бэлчээрийн ачааллыг бууруулах, нөгөө талаар малчдын амьжиргаа, орлогыг дээшлүүлэх асуудал мөн.

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГО

2.1. Гол зорилго, зорилт

УИХ-ын 2009 оны 39 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрөөс малчдын талаар баримтлах бодлого"-ын баримт бичгийн зорилго нь малчин хүнийг өөрийг нь хөгжүүлэх замаар малчин өрхийн ашиг, орлогыг нэмэгдүүлэн амьдралын түвшинг дээшлүүлэхэд оршино гэж тодорхойлсны дагуу тус бодлогод тусгасан.

Тулгарч буй асуудлыг шийдвэрлэхийн тулд малчин, мал, бэлчээрийн харилцан

¹² А.Бакей, Мал аж ахуйн хөгжлийн бодлогын өөрчлөлт, шинэчлэлийн чиглэл 2023 он

шүтэлцээнд тулгуурлан бэлчээрийн мал аж ахуйн уламжлалт соёлыг хадгалах, малчдын хамтын санаачилгыг дэмжин байгалийн нөөц, бэлчээрийг даацад нь тохируулан зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, малын чанар, бүтээмжийг нэмэгдүүлэх замаар малчдын амьжиргааг дээшлүүлэхийг гол зорилго хэмээн үзэж дараахь үйл ажиллагааг авч хэрэгжүүлснээр асуудлыг шийдвэрлэнэ гэж үзэж байна. Үүнд:

1. Малчдыг орон нутагтаа тав тухтай ажиллаж, амьдрах нөхцлийг бүрдүүлэх, ядуурлаас ангид байлгах, тэдэнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын баталгаа бий болгоход чиглэсэн эрх зүй, эдийн засаг, бизнесийн таатай орчин бүрдүүлэх,
2. Малчин өрхийн эдийн засгийн үндэс болсон мал аж ахуйн үйлдвэрлэлийн зохион байгуулалтыг сайжруулж, бүтээмж, чанар, үр ашгийг дээшлүүлэх, бүтээгдэхүүн борлуулах зах зээлийн оновчтой тогтолцоо бий болгох,
3. Малчдын өөрөө өөртөө туслах, өөрөө өөрийгөө удирдах иргэний нийгмийн бүтцийг бий болгон хөгжүүлэхийг дэмжих, боловсрол, мэдлэг чадварыг дээшлүүлэх, тусгай мэргэжил эзэмшүүлэх, малчдад үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах замаар амьдралын дадал, заншилд өөрчлөлт оруулах.

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ БОЛОН СӨРӨГ ТАЛЫН ХАРЬЦУУЛАЛТ

Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын 5.1 дүгээр зүйлд асуудал зохицуулах хувилбаруудыг тогтоож, эерэг болон сөрөг талыг харьцуулан үзэх ажлын хүрээнд дээр тодорхойлсон зорилтуудыг биелүүлэхэд чиглэсэн хувилбаруудыг тогтооно. Дурдсан аргачлалын 5.1.1–5.1.6 дахь хэсгүүдэд заасан хувилбарууд нь энэхүү тайлангийн 2 дугаар хэсэгт тодорхойлсон асуудлыг шийдвэрлэх зорилтод хүрэх хувилбар болохгүй байна. Учир нь мэдээллийн технологийн салбарт тулгамдаж буй асуудлыг үүсгэсэн шалтгаан, нөхцөл нь салбарын хуульгүй, тус салбарт төрөөс баримтлах бодлого, үзүүлэх дэмжлэг хуульчлагдаагүй явж ирсэнтэй холбоотой байна.

Тиймээс зөвхөн “хууль тогтоомжийн төсөл боловсруулах” буюу Аргачлалын 5.1.7-д заасан хувилбараар зорилтод хүрэх боломжтой гэж үзэж байна. Энэхүү дүгнэлтэд хүрэхдээ хувилбаруудыг сонгосноор зорилгод хүрэх байдал, хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал, үр өгөөжийн харьцаа зэрэг үзүүлэлтээр харьцуулан судалж дүгнэсэн болно.

“Тэг” хувилбар: Энэ хувилбарыг сонгож өнөөгийн эрх зүйн зохицуулалтыг хэвээр үлдээж болно. Гэвч ингэснээр зорилгод хүрэх боломжгүй. Зардал, үр өгөөжийн харьцааны хувьд нэмэлт зардал гарахгүй ч, тулгамдсан асуудал хэвээр сөрөг үр дагавар улам бүр нэмэгдэнэ.

Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх: Нийтэд чиглэсэн ухуулга, сурталчилгааг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр явуулах, сонсгол, хэлэлцүүлэг зохион байгуулах, олон нийтийн цахим сүлжээ ашиглах, гарын авлага, мэдээллийн хуудас гаргах зэрэг нь малчдын талаар авч буй арга хэмжээ, энэ харилцааг зохицуулж буй хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах, таниулахад чухал ч энэ аргаар асуудлыг

цогцоор нь шийдвэрлэж чадахгүй нь өнөөгийн түвшинд хүрсэн байдлаас илт байна. Зардал, үр өгөөжийн харьцааны хувьд нэмэлт зардал гарч асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгах талаар тодорхой үр дүнд хүрэх боломжтой боловч сөрөг үр дагаврыг бүрэн бууруулж чадахааргүй байна.

Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх хувилбар: Малчдын амьжиргааг дээшлүүлэх, бэлчээрийн мал аж ахуйн уламжлалт соёлыг хадгалах, малчдын хамтын санаачилгыг дэмжин байгалийн нөөц, бэлчээрийг даацад нь тохируулан зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, малын чанар, бүтээмжийг нэмэгдүүлэх талаар сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлжсэн ч энэ нь дорвитой үр нөлөө үзүүлсэнгүй. Зардал, үр өгөөжийн харьцааны хувьд тодорхой хэмжээний зардал гарах боловч асуудлыг үүсгэж байгаа гол шалтгаан, нөхцлийг арилгах хууль, эрх зүйн орчныг бий болгохгүйгээр үр дүнд хүрэхгүй.

Төрөөс санхүүгийн интервенц хийх хувилбар: Төрөөс санхүүгийн интервенц хийх хувилбараар асуудлыг шийдвэрлэх зорилгод хүрэх боломжгүй.

Захиргааны шийдвэр гаргах хувилбар: Одоогийн эрх зүйн зохицуулалтын хүрээд захиргааны байгууллага шийдвэр гаргаж, зохицуулалт хийж, тодорхой үр дүнд хүрэх боломжтой хэдий ч энэ нь цогц шийдэл болж асуудлыг үүсгэж байгаа шалтгааныг арилгахад цогцоор нөлөөлж, сөрөг үр дагаврыг бүрэн бууруулж чадахааргүй байна.

Хууль тогтоомжийн төсөл боловсруулах: Малчдын амьжиргааг дээшлүүлэх талаар одоогийн байгаа эрх зүйн зохицуулалт дутуу дулимаг байгаа тул тусгайлсан зохицуулалт бүхий хуулийн төслийг батлах замаар асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна. Зардал, үр өгөөжийн харьцааны хувьд нэмэлт зардал гарах боловч энэ хувилбар нь асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг шийдвэрлэхэд чухал нөлөө үзүүлэх боломжтой.

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа болон өмнө үйлчилж байсан тухайлсан салбарын хөгжлийг дэмжих хуулиуд байх ч өмнө дурдсаг харилцааг зохицуулсан суурь хууль байхгүй. Иймээс салбарын онцлогийг агуулсан, салбарын оролцогчдын тодорхойлсон тулгамдсан асуудлыг шийдвэрлэсэн бие даасан хуулийн төсөл байх нь хамгийн оновчтой хувилбар байна.

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨНИЙ ТАЛААР

Хүний эрх, эдийн засагт, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө, хууль тогтоомжгой нийцэж буй эсэх гэсэн шалгуураар тандан судалж дараах дүгнэлтэд хүрлээ.

4.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
		Тийм	Үгүй	
	1.1.Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх:			
Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм		
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх		Үгүй	
	1.1.3.Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх	Тийм		
	1.2,Оролцоог хангах:			
	1.2.1 .Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн	Тийм		
	1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон	Тийм		
	1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал,хариуцлага:			

1.3.1 .Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхүүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм		
1 3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмын талаар НҮБ-аас өгсөн	Тийм		
1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм		

2.Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх	Тийм		
	2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм		
3.Эрх агуулагч	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм		
	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм		
	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд ниглэсэн	Тийм		
	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр	Тийм		
4.Үүрэг хүлээгч	4.1 Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм		
5.Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1 .Жендерийн үзэл баримтлалыг тусгасан эсэх		Үгүй	хамааралгүй

	5.2-Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх		Үгүй	хамааралгүй
--	---	--	------	-------------

4.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
		Тийм	Үгүй	
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)		Үгүй	
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх		Үгүй	
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх		Үгүй	
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөргөдлийг бий болгох эсэх		Үгүй	
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх		Үгүй	
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх		Үгүй	
3.Аж ахуйн нэгжийн	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх		Үгүй	

үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	3.3. Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх		Үгүй	
	3.4.Караа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх		Үгүй	
	3.6.Ажахуйн нэгжийгүл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх		Үгүй	
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсэж байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх		Үгүй	
6.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх		Үгүй	
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх		Үгүй	
	6.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх		Үгүй	Хамааралгүй
6.Инновац болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм		
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм		

7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1 .Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм		
	7.2,Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм		
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм		
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм		
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм		
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм		
9.Төрийн захиргааны байгууллага	9.1 Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх		Үгүй	
	Э.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх		Үгүй	

10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм		
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм		
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх		Үгүй	
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм		

4.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
		Тийм	Үгүй	
1 .Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1 .Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм		
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх		Үгүй	
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм		
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм		
2.Ажлын стандарт, Хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм		ээрэг
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	хамааралгүй
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм		
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм		Эерэг

	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм		Цахим орчны хүрээнд хүүхдийг аюулгүй байдлыг хангах
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1 .Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх		Үгүй	
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт		Үгүй	
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх		Үгүй	
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх		Үгүй	
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм		
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм		
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх		Үгүй	
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх		Үгүй	хамааралгүй

5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1 .Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм		Малчдад үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирч
	5.2. Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	хамааралгүй
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх		Үгүй	хамааралгүй
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм		Эерэг
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм		Эерэг
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх		Үгүй	
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм		Эерэг

	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх		Үгүй	
	7-3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Эерэг
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	хамааралгүй
	8.2 Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	хамааралгүй
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм		Эерэг

4.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
		Тийм	Үгүй	
1 .Агаар	1.1 Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	Хамааралгүй
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх		Үгүй	Хамааралгүй
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	Хамааралгүй
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Хамааралгүй
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	Хамааралгүй
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1 .Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх		Үгүй	Хамааралгүй

	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сэргээр нөлөөлөх эсэх		Үгүй	Хамааралгүй
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сэргээр нөлөөлөх эсэх		Үгүй	Хамааралгүй
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сэргээр нөлөөлөх эсэх		Үгүй	Хамааралгүй
4.Усны нөөц	4.1 .Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сэргээр нөлөөлөх эсэх		Үгүй	Хамааралгүй
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	Хамааралгүй
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх		Үгүй	Хамааралгүй
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Хамааралгүй
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	Хамааралгүй
6.Газрын ашиглалт	6.1 .Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх		Үгүй	Хамааралгүй
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх		Үгүй	Хамааралгүй
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх		Үгүй	Хамааралгүй
7.Нөхөн сэргээгдэх /нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхыг нь алдагдуулахгүйгээр зохистой		Үгүй	Хамааралгүй
	7.2-Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх		Үгүй	Хамааралгүй

4.5. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжид нийцсэн байдал

Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцнэ.

ТАВ.ЗӨВЛӨМЖ

Хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандах судалгаагаар зохицуулалтын хувилбарыг харьцуулж судалсны үндсэн дээр малчин, мал, бэлчээрийн харилцан шүтэлцээнд тулгуурлан бэлчээрийн мал аж ахуйн уламжлалт соёлыг хадгалах, малчдын хамтын менежментийг төлөвшүүлж малчдын нийтлэг эрх ашгийг хамгаалах, байгалийн нөөц, бэлчээрийг даацад нь тохируулан зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, малын чанар, бүтээмжийг нэмэгдүүлэх замаар малчдын амьжиргааг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилго бүхий хуулийг шинээр боловсруулж, батлах нь хамгийн оновчтой хувилбар гэж дүгнэв.

МАЛЧИН ӨРХИЙН ХОЛБООНЫ ЭРХ ЗҮЙН
БАЙДЛЫН ТУХАЙ, ГАЗРЫН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ
(Бэлчээний зохицуулалт)

2023

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот

АГУУЛГА

УДИРТГАЛ 3

I. ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХҮРЭЭ	3
1.1. Нийтийн нөөц: бэлчээрийн газрыг хамгаалах, үр ашигтай ашиглахад хамаарах онолын ойлголт	3
1.2. Бэлчээрийн газрыг хамгаалах, нөхөн сэргээх уламжлал ба шинэчлэл	7
II. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ	9
2.1. Бэлчээрийн газрыг гэрээгээр ашиглуулах тухай.....	9
2.1.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал	9
2.1.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал	12
2.1.3. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал	17
2.2. Бэлчээрийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулахтай холбоотой зохицуулалт	19
2.2.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал	19
2.2.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал	
2.2.3. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал	27
2.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал	29
2.4. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал	32
III. НЭГДСЭН ДҮГНЭЛТ	34
IV. ЭХ СУРВАЛЖ	36

УДИРТГАЛ

Энэхүү судалгаа нь нэгдүгээрт, Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай, Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн “бэлчээр”-ийн газрын харилцаанд холбогдох зохицуулалтын давхардал, хийдэл, зөрчлийг тодорхойлох, хоёрдугаарт, хууль хэрэглээний явцад ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулахад хууль санаачлагчид дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн болно.

Дээрх агуулгын хүрээнд Засгийн газрын 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын дагуу хуулийн төслийн үр нөлөөг:

1. Зорилгод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих боломж
3. Харилцан уялдаа
4. Хүлээн зөвшөөрөгдсөн байдал
5. Ойлгомжтой байдал
6. Хүлээн зөвшөөрөгдөх байдал гэсэн шалгуурыг тус тус үнэллээ.

I. ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХҮРЭЭ

1.1. Нийтийн нөөц: бэлчээрийн газрыг хамгаалах, үр ашигтай ашиглахад хамаарах онолын ойлголт

Газар бол улс оршин тогтнох суурь хүчин зүйл бөгөөд Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-д “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад бай”-хаар зохицуулсан. Энэ ч утгаараа, газрыг өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах талаар тодорхой эрх зүйн зохицуулалтыг хийж, түүний урт хугацааны эдэлгээ, үр шимт байдлыг хамгаалах зайлшгүй шаардлагатай байдаг.

Ялангуяа, бэлчээрийн газрын талаар Үндсэн хуульд “Бэлчээр, нийтийн эдэлбэрийн ба улсын тусгай хэрэгцээнийхээс бусад газрыг зөвхөн Монгол Улсын иргэнд өмчлүүлж болно. Энэ нь газрын хэвлийг өмчлөхөд хамаарахгүй” хэмээн заах замаар бэлчээр, нийтийн эдэлбэр газар, улсын тусгай хэрэгцээний газрыг улсын нийтлэг эрх ашгийн төлөө ард түмнийг төлөөлөх төрийн хамгаалалтад байхыг бататгасан байна.¹ Энэ нь бэлчээрийн газрыг хамгаалах Үндсэн хуулийн үндэс юм.

Монгол Улсын нийт 156,411,6 км газар нутгийн 109,584,6 км буюу 70,1 хувийг бэлчээрийн газар эзэлдэг². Гэсэн хэдий ч, сүүлийн жилүүдэд

¹ Г.Жаргал, Д.Солонго, М.Уянга, Газар: Баялгаас өмч үүсэх арга, Арилдал ХХК, 2014, 11 дэх тал.

² Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, Газрын нэгдмэл сангийн 2021 оны улсын нэгдсэн тайлан, 120 дахь тал.

бэлчээрийн газрын талхагдал эрс нэмэгдэж байгаа бөгөөд нийт бэлчээрийн газрын 65 хувь нь доройтсон байна.³ Энэхүү бэлчээрийн газрын доройтлыг "нийтийн эзэмшлийн эмгэнэл (Tragedy of the commons)" гэсэн ойлголтын үүднээс тайлбарлах хандлага давамгайлж байна⁴. Энэхүү ойлголт нь нийтийн нөөц (commons) буюу нийтээр ашиглаж буй бэлчээрийн газарт бүгд хувийн эрх ашгийн үүднээс мал аж ахуй эрхэлж, бэлчээрийн газрыг доройтуулах тул бэлчээрийг эзэнтэй болгох замаар хамгаалах, нөхөн сэргээх боломжтой хэмээн үздэг.⁵

Уг ойлголтыг 1833 онд Британийн судлаач Уильям Форстер Ллойд дэвшүүлсэн ба 1968 онд Шинжлэх ухааны сэтгүүлд Гаррет Хардин "нийтийн эзэмшлийн эмгэнэл" гэсэн нэр томъёог хэрэглэснээр онолын суурь тавигдсан байна. Үүнийг орчин цагт **"Хардины онол"** хэмээн нэрлэх болсон бөгөөд уг онолоор нийтийн нөөц /common resources/ нь бүх хүн хэрэглэж болохоор нийтэд нээлттэй /open access/, хэрэглээний төлбөргүй, тодорхой эзэмшигч байхгүй тул хязгааргүй хэрэглээ /overuse/ үүсдэг бөгөөд энэ нь "нийтийн эзэмшлийн эмгэнэл"-г бий болгодог хэмээн тайлбарладаг.⁶ Өөрөөр хэлбэл, "бусдад болон байгаль орчинд үүсэх сөрөг үр дагавраас үл хамааран зөвхөн ашиг сонирхлын үүднээс өөрийн үйлдлийг зөвтгөх хандлага"-аар тайлбарлагдана.⁷

"Хардины онол"-ын үүднээс бэлчээрийн газрыг авч үзвэл нийтэд нээлттэй, төлбөргүй, тодорхой хариуцсан эзэнгүй, нийтээр ашиглаж болох иргэний эрх зүйн объект юм. Иймд бэлчээр ашиглагч нь зөвхөн өөрийн ашиг сонирхлын төлөө бэлчээрийг ашиглах төдийгүй, эзэмшлийн хандлага сул байх нь бий. Энэ нь нийтийн нөөц болох бэлчээрийг доройтолд оруулах шалтгаан болдог тул бэлчээрийг **өмчлүүлэх замаар хариуцсан эзэнтэй болгох**, хохирол учирсан тохиолдолд нөхөн төлбөрийг төлүүлэх, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх нь оновчтой гэж үздэг. Тодруулбал, малчин, мал бүхий этгээд нь нийтийн нөөц болох бэлчээрийг ашиглах нь өөрсдийн эдийн засгийн хэрэгцээгээ хангаж буй хэдий ч бэлчээрийг хариуцлагагүй ашигласнаар тухайн бэлчээрийг сүйтгэх ба эргээд өөрсдөө хохирох нөхцөл байдлыг "Нийтийн эзэмшлийн эмгэнэл" буюу "бэлчээрийн доройтол"-той холбон тайлбарлаж болно.

³ Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, 2 дахь тал.

⁴ М.Сувд, Бэлчээрийн харилцааны эрх зүйн зохицуулалт: Төлөв байдал, тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам /Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл/, 2016 он, 15 дахь тал.

⁵ И.Бямбабаатар, "Хөгжлийн эрэлд: Мал аж ахуй, байгаль хамгаалах салбар дахь хөгжлийн байгууллагын хөндлөнгийн оролцоо", МУИС хэвлэлийн газар, 2021, нэр томъёоны тайлбар хэсгээс.

⁶ 이승길, 공유지의 비극과 관광공유재의 함수관계, 한국관광연구학회, 관광연구저널, 2017, 76면.

⁷ 김윤상, 공유지의 비극과 사유화의 비극, 국가정책연구 제24권 제3호, 90면.

Нөгөө талд, Хардины онол нь нийтийн өмчийн эмгэнэл үүсэж буй бүх нөхцөл байдалд үр дүнтэй хэрэгжих боломжгүй бөгөөд нийгмийн тодорхой бүлгүүдийн нөөцийг ашиглах эрхийг хязгаарлах эрсдэлтэй хэмээн шүүмжлэх судлаачид бий. Өөрөөр хэлбэл, судлаачид нийгмийн тэгш бус байдлыг улам хурцатгаж, нөөцийг ашиглахтай холбоотой зөрчилдөөнийг үүсгэж болзошгүй хэмээн үздэг. Тухайлбал, Елеанор Остром нь Хардины онолын шийдлийг хэтэрхий энгийн бөгөөд орон нутгийн иргэд нөөцийг удирдах өөрийн дүрэм, хэм хэмжээг өөрсдөө зохион байгуулж, хөгжүүлэх боломжийг тооцоогүй гэж шүүмжлэн "Тогтолцооны шинжилгээ ба хөгжил" /Institutional Analysis and Development (IAD)/ онолыг дэвшүүлсэн байдаг.⁸

Уг **"Остромын онол"**-оор байгалийн нөөц дэх төрийн үүрэг оролцоог багасгах, либерал онол сэтгэлгээний хүрээнд малчдын дунд шинээр институци байгуулах буюу нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн менежмент хэрэгжүүлэх бүлэг байгуулж, нийтийн нөөцийг эзэнтэй болгох замаар "нийтийн эзэмшлийн эмгэнэл"-ийг давах боломжтой гэж тайлбарладаг.⁹ Байгалийн нөөцийг зохицуулах үүднээс бэлчээр ашиглагчдын бүлгийг байгуулснаар нийтийн нөөцийн /бэлчээр г.м/ үр ашиггүй хэрэглээг шийдвэрлэх боломжтой гэсэн таамгийг дэвшүүлдэг.¹⁰

Энэ хүрээнд Монгол Улсын бэлчээрийн доройтлыг багасгахын тулд **"Остромын онол"**-ын дагуу бэлчээрийн менежментийн тогтолцоог бий болгож, "нийтийн өмчийн сэтгэлгээ"-г төлөвшүүлэн, "Нийтийн өмчийн тогтолцоо"-г бэхжүүлэх нь "Нийтийн эзэмшлийн эмгэнэл"-ийн асуудлыг шийдвэрлэх шийдэл байж болно гэж үздэг.

Нийтийн өмчийн менежментийн хүрээнд "Бүлэг"-ийг байгуулахдаа нийтийн эзэмшлийг зүй зохистой ашиглах дараах 8 зарчмыг мөрдлөг болгодог. Үүнд:

1. Нийтийн эзэмшлийн хил хязгаарыг тогтоох
 - а. хууль ёсны ашиглагч болон ашиглагчийг тодорхойлох
 - б. нийтийн эзэмшлийн тусгай нөөцийг илүү том социо-экологийн системээс ялгах
2. Үр ашиг нь зарцуулсан зардлаас өндөр байх
 - а. нийтийн эзэмшлийг ашиглах журам нь орон нутгийн нөхцөл байдалд нийцсэн байх
 - б. бүлгийн гишүүд зарцуулсан зардлаас илүү ашиг хүртэх
3. Нийтийн эзэмшлийг ашиглах журмыг өөрчлөх, боловсронгуй болгоход нийтийн оролцоог хангах
4. Нийтийн эзэмшилд хяналт тавих, хариуцлага хүлээлгэх

⁸ E Ostrom, T Dietz, P Stern, The struggle to govern the commons, Science, 2003, 302 (5652).

⁹ И.Бямбабаатар, "Хөгжлийн эрэлд: Мал аж ахуй, байгаль хамгаалах салбар дахь хөгжлийн байгууллагын хөндлөнгийн оролцоо", МУИС хэвлэлийн газар, 2021, 85 дахь тал.

¹⁰ И.Бямбабаатар, "Хөгжлийн эрэлд: Мал аж ахуй, байгаль хамгаалах салбар дахь хөгжлийн байгууллагын хөндлөнгийн оролцоо", МУИС хэвлэлийн газар, 2021, 85 дахь тал.

- a. ашиглагчдыг хянах
 - b. нөөцийг хянах
5. Ашиглалтын журмыг зөрчсөн тохиолдолд тодорхой хариуцлага хүлээдэг байх
 6. Ашиглагчдын хооронд эсвэл эрх бүхий этгээдүүд оролцсоноос үүдсэн зөрчилдөөнийг шийдвэрлэдэг байх
 7. Нийтийн хөрөнгийг ашиглах дотооддоо гаргасан дүрэм, журмыг тухайн орон нутгийн засаг захиргаа, төр засаг нь хүлээн зөвшөөрөх
 8. Нийтийн хөрөнгийг ашиглагчид бусадтай хамтран ажилладаг байх зэрэг оржээ.¹¹

Монгол Улсын хувьд 1999 оноос хойш Олон улсын хөгжлийн байгууллагууд (цаашид, ОУХБд)-ын оролцоотойгоор “**Остромын онол**”-ын дагуу хүнд суурилсан буюу “ашиг сонирхол”-д тулгуурласан малчдын бүлэг, бэлчээр ашиглагчдын механизмыг бүрдүүлэх замаар “нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн менежмент”-ийн шинэ институциудыг байгуулж ирсэн. Энэ нь ОУХБд институцийг байгуулснаар малчдын дунд итгэлцлийг бий болгож, байгалийн нөөцийн ашиглалтын тэнцвэртэй байдлыг ханган, хамтын ажиллагааны дүнд байгалийн гамшигт үзэгдэл /ган, зуд г.м/-ийг даван туулах боломж бүрдэнэ гэсэн үзэл санаад суурилж байв.

Дээрх үзэл санаанд тулгуурлан ОУХБд-аас олон төслийг хэрэгжүүлсэн боловч үр дүнгийн хувьд харилцан адилгүй байсан. Амжилтгүй болсон төслийн олонход “ашиг сонирхол”-д үндэслэсэн буюу “хүнд суурилсан” малчдын бүлгүүд тогтвортой бус, үйл ажиллагааны чиглэлийн дагуу ажиллаж чаддаггүй гэсэн нийтлэг шинж илэрсэн байдаг.¹² Тухайлбал, малчдын бүлгүүд нь түр зуурын шинжтэй үйл ажиллагаа явуулж, удаан тогтвортой байж чаддаггүй, нэр нь л үргэлжлэн хэрэглэгдсээр тохиромжтой нөхцөл бүрдэхэд (төслийн санхүүжилт дахин авах зэрэг) дахин идэвхжих хандлагатай байдаг байна¹³.

Дүгнэхэд, өнөөгийн Монгол Улс дахь бэлчээрийн газрын тогтолцоо нь нийтийн нөөц болох бэлчээрийг бүх нийтэд нээлттэй, төлбөргүй ашиглуулах тохиолдолд бэлчээр эзэнгүйдэж бэлчээрийн зохистой ашиглалт алдагдаж, бэлчээрийн доройтлыг үүсгэж байгааг харж болно. Шийдлийн хувьд Хардины онолын дагуу нийтийн нөөц болох бэлчээрийг ашиглагчдад өмчлүүлэх нь Монгол Улсын малчдын бэлчээрт хандах хандлага, уламжлалтай нийцэхгүй төдийгүй нийгэм, эдийн засгийн тэгш бус байдлыг үүсгэх магадлалтай.

¹¹ Herzberg, Roberta Q, “Elinor Ostrom’s Governing the Commons: Institutional Diversity, Self-Governance, and Tragedy Diverted.” The Independent Review, vol. 24, no. 4, 2020, pp. 631–32.

¹² И.Бямбабаатар, “Хөгжлийн эрэлд: Мал аж ахуй, байгаль хамгаалах салбар дахь хөгжлийн байгууллагын хөндлөнгийн оролцоо”, МУИС хэвлэлийн газар, 2021, 90 дэх тал.

¹³ Мөн тэнд 88 дахь тал.

Харин уг хуулийн төслийн баримталсан хэмээн үзэж болох **“Остро́мын онол”**-ыг хэрэгжүүлэх нь өнөөгийн Монгол Улсад бэлчээрийн газрыг хамгаалах, үр ашигтай ашиглах хүрээнд зохистой байж болохоор байна. Өөрөөр хэлбэл, бэлчээр ашиглагч бүрийг тэгш боломжоор хангах, үр бүтээлийг дээшлүүлэхийн тулд бэлчээр ашиглагчдын оролцоог хангасан **“бүлэг”** байгуулан тогтворжуулах нь нийтийн нөөцийн зохистой хэрэглээг хангах боломжтой.

Гэхдээ, **“Остро́мын онол”**-д тулгуурлах замаар ОУХБд-аас хэрэгжүүлсэн төслүүдийн туршлагаас үзэхэд уг онолын нутагшуулахдаа **“ашиг сонирхол”** буюу хүмүүст үндэслэсэн бүлгээс зайлсхийж, **“капитал”** буюу нийтийн хөрөнгөд суурилсан бүлгийн хэлбэрээр эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх нь зохистой байна. Мөн малчид орон зайд баригддаггүй, оролцоо хязгаарлагдмал, айл, саахалт байх эсэхийг малын тоо, бэлчээрийн хэмжээгээр шийддэг¹⁴ гэх мэт онцлогийг харгалзан малчдад **“малчин өрхийн холбоо”**-ны хандлагыг хэрхэн идэвхжүүлэх, хэрхэн тогтвортой байлгах асуудалд анхаарал хандуулах шаардлага байна.

1.2. Бэлчээрийн газрыг хамгаалах, нөхөн сэргээх уламжлал ба шинэчлэл

Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлд бэлчээрийн ашиглалт, хамгаалалттай холбоотой харилцааг зохицуулсан нь нүүдлийн мал ахуйг эрхлэх зан заншил, уламжлалт сэтгэлгээнд тулгуурласан байна. Уг хуульд зааснаар бэлчээр гэдэгт Монгол Улсын газрын нэгдмэл сангийн нэг төрөл буюу хөдөө аж ахуйн газрын бүрэлдэхүүн хэсэг бөгөөд өвс ургамлын тодорхой сан агуулсан, мал сүрэг адгуулан бэлчээрлүүлэх зориулалт бүхий газрын гадаргуун хэсгийг ойлгоно.¹⁵ Өөрөөр хэлбэл, бэлчээр нь зөвхөн мал, амьтан бэлчээх зориулалттай байгалийн болон таримал ургамлын нөмрөг бүхий хөдөө аж ахуйн газарт хамааруулсан газрыг” хэлэх бус, харин ус, ургамал, хужир мараа, уур амьсгал, газрын хотгор, гүдгэр зэрэг малын ашиг шимд нөлөөлөгч байгалийн хүчин зүйлсийн нийлбэр, зэрлэг амьтан, бичил биетний амьдрах орчин бөгөөд үүнийг цогцоор нь илэрхийлдэг **“нутаг орон”** хэмээх ойлголттой дүйнэ.¹⁶

Уламжлалт заншлын хэм хэмжээний хүрээнд малчид нь шинэ бэлчээр тахлах, тогтоосон бэлчээрийн **“хил”** зөрчихийг цээрлэх, нэг газрын цараа¹⁷

¹⁴ Мөн тэнд 79 дэх тал.

¹⁵ Н.Лүндэндорж, Монгол Улсын Үндсэн хуулийн шинжлэх ухааны тайлбар, Адмон Принт, 2022, 86 дахь тал.

¹⁶ Монгол орны бэлчээрийн тулгамдсан асуудал: Гарц ба шийдэл, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Байгаль орчин аялал жуулчлалын яам хамтран хэрэгжүүлдэг **“Биологийн олон янз байдлын санхүүжилтийн санаачилга”** БИОФИН төслийн хүрээнд Монгол Улсын Хөдөө аж ахуйн Их сургуулийн Хөдөө аж ахуйн эдийн засаг, инновацийн хөгжлийн төв бэлтгэсэн, 2014, 65 дахь тал

¹⁷ Цараа гэж нэгэнт мал бэлчсэн газрыг ойлгоно.

нүнжгээ барахаас нааш солихгүй байх, “бүтэн”¹⁸ бэлчээрийг гол нөөц гэж үздэг уламжлалтай байжээ.¹⁹ Бэлчээрийн хил хатуу тогтоогдсон хуваарьтай байсан бөгөөд малын хээл томроогүй үед уулын орой хавийн бэлчээрийг, малын хээл томорсон буюу мал төллөсөн үед уулын оройгоос доош болон бэл, өвөлжөөний ойрын аргамжааны болон чөдрийн морь, төлөг, борлон, бяруунд зориулан нөөц бэлчээр болон үлдээдэг гэх зэрэг малын нас, хүйс, ашиглах зориулалтаас хамаарч бэлчээрийг тохируулан ашигладаг уламжлалтай. Эдгээр нь бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах заншлын хэм хэмжээний хүрээнд мөрдөгдөж ирсэн байна.

Газрын тухай хуулийн 52 дугаар зүйл дэх “Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн нутгийн онцлог, бэлчээрийг ашиглаж ирсэн уламжлал, зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх шаардлагыг харгалзан өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржаа, отрын нөөц нутаг гэсэн ерөнхий хуваарийн дагуу газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган батална” гэх, “Зуслан, намаржаа болон отрын бэлчээрийг баг, хот айлаар хуваарилж нийтээр ашиглана” гэх, “Тухайн жилийн бэлчээрийн гарц, иргэдийн саналыг харгалзан өвөлжөө, хаваржааны бэлчээрийг малаас чөлөөлөх, оруулах хугацааг сум, дүүргийн Засаг дарга тогтоож, баг, хорооны Засаг дарга, иргэд мөрдөж хэрэгжүүлнэ” гэх заалт нь дээрх уламжлалаас үүдэлтэйгээр 1924 оноос хойш газрын эрх зүйн актад тусгагдсаар иржээ.²⁰

Сүүлийн жилүүдэд малын тоо хурдацтай нэмэгдэж, нүүдлийн мал ахуйг эрхлэх явцад хүрээлэн буй орчин, бэлчээр хамгаалах, нөхөн сэргээх асуудал орхигдож нүүдлийн мал аж ахуйн уламжлал, заншлын хэм хэмжээний нөлөө буурч байна. Иймд бэлчээрийг ашиглах, хамгаалах уламжлалт сайн туршлагад тулгуурлах, нийтийн өмчийг үр ашигтай ашиглахад чиглэсэн орчин үеийн арга хэрэгслийг хослуулсан эрх зүйн зохицуулалтыг бэхжүүлэх шаардлага үүссэн.²¹

Бэлчээрийн доройтлын үндсэн шалтгааны нэг нь бэлчээрийг тодорхой нэгэн хариуцлага хүлээхгүй нийтээр, дундаа ашиглах болсноор бэлчээр эзэнгүйдэж байгаатай холбоотой. Үүнийг шийдвэрлэх хүрээнд бэлчээрийг эзэнжүүлэх, бэлчээр ашиглалттай холбогдох хариуцлага хүлээлгэх тогтолцоог бүрдүүлэх гэх мэтээр бэлчээрийн менежментийг нэвтрүүлж тухайн нутаг дэвсгэрийн засаг захиргааны нэгжийн удирдлагаас харьяа нутаг дэвсгэрийн байгалийн баялаг, түүний дотор бэлчээрийг хомсдол, доройтолд оруулахгүй байх цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

¹⁸ Бүтэн гэж малын хөл хүрээгүй хэсгийг ойлгоно.

¹⁹ Хилийн доторх дархан хил, Нэрт эрдэмтэн, чацаргана судлаач Б. Лааганы тухай “Дарь үнэрлэж чацаргана нүүлгэсэн жилүүд” дуртатгалын номноос авав, <https://www.greenmongolia.mn/post/42924>.

²⁰ М.Сувд, Бэлчээрийн харилцааны эрх зүйн зохицуулалт: Төлөв байдал, тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам /Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл/, 2016 он, 30-38 дахь тал.

²¹ Мөн тэнд.

Иймд уг хуулийн төслөөр Бэлчээрийн газрыг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх асуудлыг энэ хуульд заасан сумын газар зохион байгуулалтын ерөнхий болон тухайн жилийн төлөвлөгөөнд үе шаттай төлөвлөж, хэрэгжүүлэх, Отрын бэлчээр, бэлчээр дэх уст цэг, хужир мараа бүхий газрыг нийтээр ашиглана. Бэлчээрийг талхлагдахаас хамгаалах, нөхөн сэргээх зорилгоор тухайн бүс нутгийн онцлог, бэлчээрийн даацыг харгалзан, сумын иргэдийн Хурлын шийдвэрийг үндэслэн сумын Засаг дарга малчин өрхийн анхдагч холбоонд бэлчээрийн газрыг гэрээний дагуу ашиглуулж болно” гэж заажээ.

II. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

2.1. Бэлчээрийн газрыг гэрээгээр ашиглуулах тухай

Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд бэлчээрийн газрыг гэрээгээр ашиглуулахтай холбоотой хэд хэдэн зохицуулалт тусгасан бөгөөд үүнийг “Зорилгод хүрэх байдал”, “Практикт хэрэгжих байдал”, “Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтээр үнэллээ.

2.1.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтээр хууль тогтоомжийн төслийн зохицуулалтыг шалгаж, үр нөлөөг нь үнэлэх бол тухайн төслөөр тавьсан зорилгод хүрэхэд чиглэгдсэн эсхүл түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц зүйл, заалтыг сонгоно. Ингэхдээ хуулийн үзэл баримтлалд тусгагдсан хуулийн төсөл боловсруулах болсон хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэх, хуулийг батлан хэрэгжүүлснээр хүрэхээр тавьсан зорилгод хүрэх боломжтой байдлаар томьёологдож чадсан эсэхэд дараах агуулгын дагуу дүн шинжилгээ хийнэ.

Малчин өрхийн анхдагч холбоонд бэлчээрийг гэрээгээр ашиглуулах талаар

3.1. Малчин өрхийн анхдагч холбоонд бэлчээрийг гэрээгээр ашиглуулах, гэрээт бэлчээрийн газар дахь байгалийн нөөцийг хууль тогтоомжид заасны дагуу ашиглах, хамгаалах, нөхөн сэргээхэд малчдын оролцоог хангах, малчин өрхийн холбооны тогтолцоог өөрөө удирдах ёсны зарчимд нийцүүлэн зохион байгуулахтай холбоотой харилцааг энэ хуулиар зохицуулна.

Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль боловсруулах болсон үндэслэл нь “Монгол Улсын үндэсний аюулгүй

байдлын үзэл баримтлал"-д тусгагдсан "Бэлчээр эзэмшүүлэх, хамгаалах болон нөхөн сэргээх, хариуцлага хүлээлгэх чиглэлээр эрх зүйн орчныг бүрдүүлнэ" гэсэн үндэсний аюулгүй байдлыг хангах арга зам, "Алсын хараа 2050"-д тусгасан "Бэлчээрийн газрыг ашиглах, сайжруулах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулсан эрх зүйн орчныг тодорхой болгож, бэлчээрийн менежментийн нэгдсэн системийг бий болгож, бэлчээрийн доройтол, цөлжилтийг бууруулна" гэсэн тогтвортой хөдөө аж ахуйн зорилт, мөн Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан "Бэлчээрийн ашиглалт, хамгаалалт, сайжруулалтын хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, бэлчээрийн доройтол, цөлжилтийг бууруулна" гэсэн зорилтууд юм. Ийнхүү зорилт дэвшүүлэх болсон практик шаардлага нь бэлчээрийн даац хэтрэх, бэлчээр доройтож буйтай холбоотой.

Уг хуулийн төслийн үзэл баримтлалд бэлчээрийн газрыг ашиглах, сайжруулах, хамгаалахтай холбоотой харилцааг гэрээнд тулгуурлан хэрэгжүүлэхээр тусгасан байна. Бэлчээрийг гэрээний үндсэн дээр тодорхой болзол нөхцөлтэйгөөр ашиглуулах нь нийтийн баялаг болох бэлчээрийн газрыг эзэнжүүлж бэлчээрийг хамгаалах, нөхөн сэргээх гэх мэт менежмент хийх суурь болох давуу талтай.

Бэлчээр ашиглалтын гэрээ нь Иргэний хуулийн 406 дугаар зүйлд заасан "Хөрөнгө итгэмжлэх гэрээ" эсхүл түүнтэй төстэй нэрлэгдээгүй гэрээнд хамаарахаар байна. Өөрөөр хэлбэл, итгэмжлэгч буюу төрөөс өөрийн өмчлөлийн бэлчээрийг итгэмжлэгдсэн бэлчээр ашиглагчдын бүлэгт шилжүүлж, итгэмжлэгч буюу төрийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглах агуулгыг илэрхийлж байна.

Одоо хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа Газрын тухай хуульд бэлчээрийн газрыг гэрээгээр ашиглуулах тухай "императив" хэм хэмжээ байхгүй тул бэлчээрийн газар эзэнгүйдэх, улмаар доройтох нэг шалтгаан болж байна. Энэхүү бэлчээрийн доройтол, бэлчээрийн даацыг тэнцвэржүүлэх үүднээс хуулийн төслийн 6.5-д улирлын бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах, сэргээн сайжруулах зориулалтаар улирлын бэлчээрийн газрыг гэрээгээр ашиглуулдаг байхаар шинээр тусгаж өгсөн нь хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, бэлчээрийн газрыг зүй зохистой ашиглах, хамгаалах, бэлчээрийн менежментийн нэгдсэн системийг бий болгох зорилтод нийцсэн байна гэж үзлээ.

Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл дэх гэрээгээр бэлчээр ашиглах субъект

Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Сумын Засаг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг үндэслэн бэлчээрийн газрыг малчин өрхийн анхдагч холбоонд ашиглуулах гэрээ байгуулах бөгөөд гэрээг бүртгэх, гэрээт бэлчээрийн газрын ашиглалт, төлөв

байдлын үнэлгээг үндэслэн сумын бэлчээр хариуцсан мэргэжилтэнтэй хамтран бэлчээр ашиглалтын гэрээний биелэлтэд тогтмол хяналт тавих, дүгнэх.

Малчин өрхийн өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 10 дугаар зүйлд “малчин өрхийн анхдагч холбоо”-д бэлчээрийг гэрээгээр хууваарьтай ашиглуулж болохоор тусгасан байна. Өөрөөр хэлбэл, Анхдагч холбоо нь гэрээт бэлчээрийн газар, байгалийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр дараах үйл ажиллагаанд Засаг даргатай байгуулсан гэрээний дагуу гишүүдийг зохион байгуулж, байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, доройтсон бэлчээрийг нөхөн сэргээх, хөрсний үржил шимийг сайжруулах ажлыг зохион байгуулах, малын тоог бэлчээрийн даацад тохируулах, гэрээт бэлчээрийн газар, байгалийн нөөцийг зүй зохистой ашиглахад хяналт тавихаар тусгасан нь бэлчээрийн газрыг ашиглах, хамгаалах зорилгодоо нийцсэн гэж үзлээ.

Бэлчээр ашиглах субъекттэй холбогдох зохицуулалтын хүрээнд 1. хуулийн төсөлд тусгасан “малчин өрхийн анхдагч холбоо” нь Иргэний хуулийн 33 дугаар зүйлд заасны дагуу ашгийн төлөө бус хуулийн этгээд байна.

Төрөөс бэлчээр ашиглах гэрээ байгуулах зорилго нь бэлчээр ашиглагчдад бэлчээрийн газрыг үр ашигтайгаар ашиглуулах, хамгаалуулах явдал юм. Малчин өрхийн анхдагч холбоо нь гэрээний үндсэн дээр төрийн өмчийн газрыг ашиглан үр ашгийг хүртэх тул гэрээнд заасан үүргийг биелүүлэх, тодруулбал бэлчээрийг хамгаалах, нөхөн сэргээх үүрэг хүлээх учиртай.

Иймд гэрээнд заавал тусгах зүйлс буюу минимум стандартыг хуулиар тогтоож, бусад тохиролцоог нээлттэй үлдээх боломжийг бүрдүүлсэн “**гэрээний стандарт**”-ыг батлан мөрдүүлэх нь оновчтой. Энэ нь бэлчээр ашиглагчдын тэгш байдлыг хангах боломжийг бүрдүүлж байна.

Бэлчээрийн гэрээ байгуулах хүсэлтийг шийдвэрлэх субъект

21.4.4.сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг үндэслэн бэлчээрийн газрыг малчин өрхийн анхдагч холбоонд ашиглуулах гэрээ байгуулах;

Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд малчин өрхийн анхдагч холбоонд бэлчээрийн газрыг ашиглах гэрээг Засаг даргатай байгуулахаар тусгасан байна. Бэлчээр ашиглалтын гэрээг байгуулсан хэд хэдэн аймагт, Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.2-т заасны дагуу бэлчээрийг урт хугацаагаар гэрээгээр ашиглуулах, гэрээний

хэрэгжилтийг дүгнэж, хариуцлага үр дүнг тооцож ажиллах чиг үүргийг сум, дүүргийн Засаг дарга гүйцэтгэдэг байна.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Газрын тухай хуулийн 21.4.3-т зааснаар сумын Засаг дарга нь тус хуулийн 21.3.2²²-т зааснаас бусад газрыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу сумын хэмжээнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ашиглуулах асуудлыг шийдвэрлэж, зохион байгуулах эрхтэй.

2.1.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийг “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр дүгнэсэн дараах агуулгын дагуу үнэллээ.

Нэг. Бэлчээрийг гэрээгээр ашиглуулах

Практик дээр, сум, багийн Засаг дарга Газрын тухай хуулийн 52.2²³, 54.4²⁴, 52.5²⁵ болон Иргэний хуулийн 195–199 дүгээр заалтыг үндэслэн бэлчээр ашиглалтын гэрээг байгуулж байна. Бэлчээрийг гэрээний үндсэн дээр малчдад ашиглуулах эрх зүйн үндэслэл тодорхойгүй байгаа энэ үед уг хуулийн төсөл батлагдсанаар эрх зүйн орчин бий болно гэж үзэж байна.

Бэлчээрийн ашиглалтын эрх зүйн шинэлэг зохицуулалтыг бий болгохдоо бэлчээр ашиглагчдын эрхийг хамгаалах тал дээр илүү анхаарах хэрэгтэй. Бэлчээрийг урт хугацааны гэрээгээр ашиглуулах нь оновчтой бөгөөд ингэснээр бэлчээр өмчлөгч төр, бэлчээр ашиглагчийн хооронд харилцан үүрэг хүлээж, эрх эдлэх боломжийг баталгаажуулна. Бэлчээрийг гэрээгээр ашиглуулах туршилтыг анх Мянганы сорилтын сангийн “Хот орчмын бэлчээрийн төсөл”-ийн хүрээнд Төв, Сэлэнгэ, Булган, Орхон, Дархан-Уул, Өвөрхангай, Архангай, Дорнод аймгийн 50 сумын нутагт 400 орчим малчдын бүлэгт тус бүр нь 500-2000 орчим га бэлчээрийг гэрээгээр ашиглуулсан байна. Бэлчээрийн доройтол үүсэж, хүрэлцээ багасаж буй

²² Газрын тухай хууль, 21.3.2. аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний дагуу аймгийн төвийн инженерийн шугам, сүлжээ бүхий газруудад газар эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг шийдвэрлэнэ. Уг асуудлыг шийдвэрлэхэд тухайн сумын Засаг даргын саналыг авсан байна.

²³ 52.2. “Зуслан, намаржаа болон отрын бэлчээрийг баг, хот айлаар хуваарилж нийтээр ашиглана. ...Өвөлжөө, хаваржааны тодорхой нутаг бэлчээрийг ... багийн Иргэдийн Нийтийн хурлын саналыг үндэслэн сумын Засаг дарга малчдад болзол, гэрээний дагуу хэсэг бүлгээр ашиглуулж болно”.

²⁴ 52.4. “Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ нь ... нутаг дэвсгэртээ бэлчээрийн суурин маллагааны бүс нутгийг тогтоож болно”.

²⁵ 52.5. “Эрчимжсэн суурин мал аж ахуй эрхлэх болон тэжээвэр амьтан өсгөн үржүүлэх зорилгоор хашсан бэлчээрийг ... улирал харгалзахгүй тодорхой болзол, гэрээний дагуу ашиглуулж болно”.

өнөөгийн нөхцөлд бэлчээрийг гэрээгээр ашиглах явдал нь бэлчээр ашиглах эрхээ баталгаажуулах арга болно.

2018 оны байдлаар 11 аймагт бэлчээр ашиглагчдын 830 хэсэг (БАХ) 16 сая га талбай бүхий бэлчээрийг сумын Засаг даргатай бэлчээр ашиглалтын гэрээ байгуулан ашиглаж байна. Малын тоо толгойг бэлчээрийн даацад тохируулах шаардлага бий боловч үүнийг хэрэгжүүлэх тодорхой тогтолцоо бүрдээгүй байна.

Иймд хуулийн төсөлд тусгагдсан бэлчээрийн гэрээтэй холбоотой зохицуулалт нь одоо практик дээр үүсээд байгаа Засаг дарга бэлчээрийг гэрээгээр ашиглуулах эрх хэмжээтэй эсэх хуулийн маргаантай асуудлыг шийдвэрлэх, бэлчээр ашиглагчдын эрхийг баталгаажуулах, цаашлаад одоо хэрэгжиж буй практикийг тогтворжуулахад чухал нөлөө үзүүлэх бөгөөд практикт хэрэгжих боломжтой гэж үзлээ.

Хоёр. Гэрээгээр бэлчээр ашиглах субъект

ОУХБд байгалийн нөөц баялгийг ашиглах, зохицуулахад төрийн үүрэг, оролцоог багасгах либерал онол сэтгэлгээний хүрээнд малчдын дунд шинээр институци байгуулах буюу нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн менежмент хэрэгжүүлэх, малчдын бүлэг байгуулах замаар малчдын "нийтийн эзэмшлийн нөөцийн доройтол"-г давж, "нийтийн өмчийн систем"-н институци байгуулах тухай онол сэтгэлгээг хөгжүүлэх төсөл, хөтөлбөрийг удаа дараа хэрэгжүүлсэн туршлага байна.²⁶

Мал аж ахуйн салбарт хэрэгжүүлсэн дээрх төсөл хөтөлбөр бүрийн хүрээнд чиг үүргийн хувьд ялгаатай малчдын бүлэг (herder group)-г үүсгэж байсан бол "Ногоон алт" төслийн хүрээнд бэлчээр ашиглагчдын бүлэг /pasture-user group/-г үүсгэж байжээ. Өөрөөр хэлбэл, бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд хамтын үйл ажиллагаа явуулах чиг үүрэгтэй бэлчээр ашиглагчдын бүлгийг эдийн засгийн ашиг сонирхлын дагуу нэгдэх жижиг бүлгээс ялгаатай авч үзсэн байна. Бэлчээр ашиглагчдын бүлэг /pasture user group/ нь тодорхой хязгаар бүхий нутаг дэвсгэрт үндэслэгдэж байгуулах, заавал нэгдэн орох шинжтэй зохион байгуулалтын нэг төрөл юм. Өөрөөр хэлбэл, энэ бүлэг нь гишүүдийнхээ эдийн засгийн нийтлэг ашиг сонирхол, танилын хүрээ зэрэгт суурилаагүй том хэмжээний бүлэг юм.²⁷ Малчдын хот айл, хоршоо, холбоо нь дээр дурдсан бэлчээр ашиглагчдын бүлэгт нэгдэх боломжтой бөгөөд ийнхүү бэлчээр ашиглагчдын бүлэгт нэгдсэн нь ашиг сонирхлын дагуу нэгдэн нийлсэн жижиг бүлгийн гишүүн (хоршоо

²⁶ И.Бямбабаатар, "Хөгжлийн эрэлд: Мал аж ахуй, байгаль хамгаалах салбар дахь хөгжлийн байгууллагын хөндлөнгийн оролцоо", 2021, 85 дахь тал.

²⁷ Batsaikhan Usukh, Hans P. Binswanger-Mkhize, Raffael Himmelsbach and Karl Schuler, *Fostering the sustainable livelihoods of herders in Mongolia via collective action*, 2010, 18 дахь тал.

гэх.м) байх малчны эрхэд нөлөөлөхгүй.²⁸ Бэлчээр ашиглагчдын бүлгийн үйл ажиллагаа тогтвортой байхын тулд бүлгийг төлөөлөх этгээд буюу удирдагчийг сонгох асуудал чухлаар хөндөгдөх ёстой.²⁹ Тухайлбал, бүлгийн удирдагч нь төр, орон нутгийн байгууллагатай хамтран ажиллах чадвартай байх нь зүйтэй.

Гурав. Бэлчээрийн гэрээний нөхцөл

Газрын тухай хуулийн 52.2, 52.4, 52.5 дахь заалт, Иргэний хуулийн 195-199 дүгээр заалт нь бэлчээрийг малчдад гэрээгээр ашиглуулах эрх зүйн үндэслэлийг бүрдүүлдэг. Малчдыг бэлчээр ашиглагчдын бүлгийн зохион байгуулалтад оруулан, бэлчээр ашиглалтын гэрээ байгуулснаар харилцан хүлээх эрх, үүргүүд тодорхой болж малчид болон орон нутгийн удирдлагын үйл ажиллагаа идэвхэжсэн зэрэг эерэг үр дүнгүүд гарч байна.³⁰ Бэлчээрийн гэрээ буюу "community-based natural resource management" (CBNRM)-г хэрэгжүүлдэг мал аж ахуй уламжлан эрхэлж ирсэн хэд хэдэн орнууд байдаг ч энэхүү гэрээг тухайн хэрэгжүүлэгч орон өөрийн орны онцлогт тохируулан хэрэглэх боломжтой байх тул гэрээний нөхцөлийг хатуу тогтоодоггүй.

Одоогоор бэлчээр ашиглалтын гэрээний нөхцөлийг аймаг, сумын бэлчээр ашиглах журмаар зохицуулж байна. Гэрээгээр бэлчээр ашиглаж буй Монгол Улс дахь практикийг авч үзэхийн тулд 2018-2020 онд батлагдсан 8 аймгийн 20 сумын бэлчээр ашиглах журмыг судлав. Харьцуулан авч үзэхэд, эдгээр аймаг, сумдын дийлэнх нь холбогдох журамдаа гэрээний нийтлэг нөхцөлийг тусгаагүй байсныг онцлох нь зүйтэй. Харин Баян-Өлгий аймгийн Алтай, Толбо, Ховд аймгийн Эрдэнэбүрэн, Ховд сумын ИТХ-аас баталсан тогтоолд Бэлчээр ашиглах гэрээнд заавал тусгах нөхцөлийг тусгасан байна.

Баян-Өлгий аймгийн хуваьд нийтлэг байдлаар авч үзвэл бэлчээрийн хил, зааг болон бэлчээрийн даацыг тооцож, түүнд тохирсон малын тоог хамтын гэрээндээ тусгахаар зохицуулжээ. Харин тус аймгийн Толбо сум дээрх зохицуулалтаас гадна:

- 1) Бэлчээр, хадлангийн талбайг малаас чөлөөлөх мал оруулах хугацаа
- 2) Мал тууварлан өнгөрөх зурвас, түр саатах хугацаа /2 хоногоос илүүгүй байна/-г гэрээнд заавал тусгахаар заасан байна.

Мал тууварлан өнгөрөх зурвас, түр саатах хугацааг гэрээнд тусгахаар заасан ч тухайн газар нутгийн байршил, тогтоц, уламжлал, онцлог зэрэг бусад холбогдох шалтгааны улмаас нутаг бүрд харилцан адилгүй байх тул хугацааг хуулиар нарийвчлан тогтоох нь зохимжгүй юм.

²⁸ Мөн тэнд.

²⁹ Мөн тэнд.

³⁰ Н.Гагхуяг, Ц.Энх-Амгалан, Т.Эрдэнэчулуун, Ш.Гэрлээ, Малчдын хамтын зохион байгуулалт, бэлчээр ашиглалтын гэрээний зохицуулалт ба хэрэгжилт, Mongolian Journal of Agricultural Sciences, 2022, Vol.15, No.35, 8 дахь тал. <https://doi.org/10.5564/mjas.v15i35.2442>.

Ховд аймгийн Эрдэнэбүрэн сум “Бэлчээр, хадлангийн талбайг зүй зохистой ашиглах, хамгаалах журам”-д тусгасан хэд хэдэн онцлог зохицуулалтыг дурдвал:

- ▣ тухайн БАХ-ийн бэлчээрээс нөөц бэлчээрт ашиглах хэмжээ;
- ▣ гэрээгээр бэлчээр ашиглагч, ашиглуулагч талуудаас хийх хөрөнгө оруулалтын талаар гэрээнд тусгахаар заасан байна.

Бэлчээр ашиглалтын гэрээ нь улирлын болон нөөц бэлчээрийг хуваарьтай ашиглах уламжлалыг сэргээн бэхжүүлэхэд чиглэх ёстой. Ингэхдээ, бүс нутгийн онцлог, ган, зуд, цаг уурын байдлыг харгалзан бэлчээрээс орох, гарахтай холбогдох харилцааг уян хатан байдлаар гэрээнд тусгавал зохино.³¹ Өөрөөр хэлбэл, гэнэтийн буюу байгалийн давагдашгүй хүчин зүйл үүссэн үед бэлчээрийн хязгаарлалт үйлчлэхгүй байхаар тусгах нь зүйтэй. Хуулийн төслийн 52.8.8-д заасны дагуу гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас бусдын гэрээт бэлчээрийг ашиглаж болохоор зохицуулсан нь зайлшгүй зохицуулалт хэдий ч үндсэн гэрээнээс татгалзах, цуцлах, шинээр дахин гэрээ байгуулах гол эрхийг баталгаажуулах хэрэгтэй.

Мөн бэлчээр ашиглагчдын бүлэг нийтээр ашиглах бэлчээр буюу хужир, мараа, худаг, гол, горхи мэтийг хэрхэн ашиглах, хамгаалах талаарх зохицуулалтыг гэрээнд тусгаснаар бүлэг хооронд үүсэж болзошгүй маргаан, эрсдэлээс урьдчилан сэргийлнэ.

Бэлчээрийн хил, заагийг тогтоох субъект

Бэлчээрийн хил, заагийг тогтоохдоо сум бүр харилцан адилгүй байдлаар зохицуулж байна. Жишээлбэл, Баян-Өлгий аймгийн Алтай суманд Бэлчээр ашиглагчдын хэсэг, малчдын бүлгийн өвөлжөө, хаваржааны тусгайлан ашиглах, нийтээр ашиглах бэлчээрийн хилийг *тухайн хэсэг бүлгийн бүх гишүүдийн хурлаар болон Багийн Иргэдийн Нийтийн Хурлаар* хэлэлцүүлэн тогтоож, газрын зураг үйлдэн, хамтын ажиллагааны гэрээнд тусгадаг³² бол мөн аймгийн Толбо сум, Ховд аймгийн Эрдэнэбүрэн суманд зөвхөн *тухайн хэсэг бүлгийн нийт гишүүдийн хурлаар шийдэж байна*.³³

Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Харин хуулийн төсөлд Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн орон нутгийн онцлогт тохируулж, бэлчээрийн газрыг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх журмыг батлах, аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө болон сумын тухайн жилийн

³¹ Бодлого судлалын төв, Бэлчээрийн газрыг гэрээгээр ашиглах боломж, 2014, 9 дэх тал.

³² Баян-Өлгий аймгийн Алтай сумын иргэдээс хадлан, бэлчээр ашиглах, эзэмших, хамгаалах журам, 2020, 6.2. дахь заалт.

³³ Баян-Өлгий аймгийн Толбо сумын иргэдээс хадлан бэлчээр ашиглах, эзэмших журам, 2019, 2.7 дахь заалт, Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын бэлчээр ашиглах журам, 3.7 дахь тал.

төлөвлөгөөнд нийцүүлэн багийн Нийтийн Хурлын шийдвэрийг үндэслэн малчин өрхийн анхдагч холбоонд гэрээгээр ашиглуулах бэлчээрийн газрын зааг, хэмжээ, байршлыг тогтоохоор заасан байгаа нь нэгдсэн зохицуулалтыг бий болгосон байна.

Бэлчээрийн газрыг малчид бүлгээр ашиглахад тулгамдаж буй асуудлын нэг нь ган, зудын үеэр малчид нэг сум, аймгаас зэргэлдээх аймаг, сумын нутаг руу нүүдэллэх явдал юм. Практикт эдгээр нүүдэллэн ирж буй малчдын хүлээн авагч талд тухайн бэлчээрийн хэт ашиглалтаас үүдэлтэй сөрөг нөлөө илүү учирч, бэлчээрийг улам доройтуулж байна.

Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 21.4.5-д гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас өөр аймаг, сумын малчин өрхийн малыг бэлчээрийн даацад тохируулан малчин өрхийн анхдагч холбооны гэрээт бэлчээрийн газарт түр хугацаагаар оруулах, гаргах асуудлыг холбогдох аймаг, сумын Засаг даргатай хамтран шийдвэрлэх тусгажээ.

Бэлчээр ашиглалтын гэрээний хэрэгжилтийн талаар

Бэлчээр ашиглалтын гэрээний хэрэгжилт, түүний тогтвортой байдлыг хангах үүднээс гэрээг газрын кадастрын мэдээллийн сангийн цахим системд оруулж, цахимжсан цогц мэдээлэл үүсгэж гэрээний эрхийг баталгаажуулна. Уг системд сумын Засаг даргын гэрээ байгуулах захирамж, бэлчээрийн төлөв байдал, бэлчээр ашиглагчдын хэсгийн хил зааг, улирлын бэлчээрийн хуваарь, экологийн чадавхын зураглал, бэлчээр ашиглалтын нөлөөг хянах жил бүрийн фото мониторингийн тайлан зэрэг мэдээллүүд багтана.

Үүнээс гадна бэлчээр ашиглалтын гэрээний хэрэгжилтийг хангахын тулд дараах ажлуудыг гүйцэтгэвэл зохилтой.

- Бэлчээр ашиглагчийн хэсгийн гишүүдэд сургалт зохион байгуулах;
- Бэлчээрийн менежментийн жилийн болон дунд хугацааны төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх.

Эдгээрээс дүгнэвэл, бэлчээрийн гэрээний нөхцөлүүд нь орон нутаг бүрт харилцан адилгүй тусгагдах боломжтой тул гэрээний нарийвчилсан нөхцөлийг хатуу жагсаах боломжгүй. Одоогоор малчид сайн дурын үндсэн дээр хүлээн зөвшөөрч, бэлчээр ашиглалтын гэрээг байгуулдаг. Судалгаанд хамруулсан 20 сумын бэлчээр ашиглах, хамгаалах журамд бэлчээрийн хил, зааг, бэлчээрийн даац, гэрээний хугацаа зэргийг нийтлэг байдлаар гэрээнд тусгахаар зохицуулсан байна.

Иймд хуулийн төслийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт заасан байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, доройтсон бэлчээрийг нөхөн сэргээх, хөрсний үржил шимийг сайжруулах ажлыг зохион байгуулах,

бэлчээрийн ургамлын ургалт, нөхөн сэргэлтэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байдлаар гэрээт бэлчээрийн газрыг гишүүн малчин өрхөд хуваарьтай ашиглуулах, малын тоог бэлчээрийн даацад тохируулах, байгалийн гамшгаас хамгаалах нөөц бүрдүүлэх, хадлан, тэжээл бэлтгэх, гэрээт бэлчээрийн газар, байгалийн нөөцийг зүй зохистой ашиглах, гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас өөр аймаг, сумын малчдын малыг сумын засаг даргын шийдвэрийн дагуу бэлчээрийн даацад тохируулан гэрээт бэлчээрийн газрыг түр ашиглуулахад хяналт тавих, хорио цээртэй өвчин гарах, хөнөөлт шавж, мэрэгч амьтан тархахаас урьдчилан сэргийлэх, гарсан тохиолдолд холбогдох арга хэмжээг авах, бэлчээрийн усан хангамжийг сайжруулах, хөв цөөрөм байгуулах, мал, амьтны сэг зэм устгал, орчны халдваргүйтгэлийн арга хэмжээг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах гэх мэт гэрээний нөхцөлүүд нь практикт хэрэгжих боломжтой гэж дүгнэж байна.

2.1.3. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Аргачлалд заасан асуулт	Хуулийн төслийг үнэлсэн байдал ³⁴
Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх	4.1.1.“малчин” гэж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн³⁵ 3.1.9-д заасныг; 4.1.2.“малчин өрх” гэж мал аж ахуй эрхэлж, мал, түүний ашиг шимээр үндсэн орлогоо олдог өрхийг; 4.1.3.“Малчин өрхийн анхдагч холбоо” гэж сайн дурын үндсэн дээр, малчдын нийтлэг эрх ашгийн төлөө өөрөө удирдах зарчимд үндэслэн энэ хуулийн дагуу байгуулагдсан хуулийн этгээдийг. 4.1.4.“гэрээт бэлчээрийн газар” гэж Газрын тухай хуулийн 3.1.11-д заасныг; 4.1.5.“байгалийн нөөц” гэж гэрээт бэлчээрийн газар дахь байгалийн ургамал, ой, ойн дагалт баялаг, уст цэг, булаг шанд, ан амьтан зэргийг; Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.9-д заасны дагуу "малчин" гэж мал аж ахуй эрхэлж үндсэн орлогоо олдог иргэнийг хэлдэг.

³⁴ Судалгааны “харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн давхацсан заалттай холбогдох хэсгийг энэ хэсэгт үнэлээгүй болно. Тусгагдаагүй асуудлыг судалгааны дараагийн хэсгээс үзнэ үү.

³⁵ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2011 оны 40 дугаарт нийтлэгдсэн.

	Төслийн 4.1.4-т "гэрээт бэлчээрийн газар" гэж Газрын тухай хуулийн 3.1.13-д заасныг; гэж, Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3.1.13-т "гэрээт бэлчээрийн газар" гэж малчин өрхийн анхдагч холбоонд гэрээний дагуу ашиглуулж байгаа улирлын бэлчээрийг;" гэж тусгасан байна. Төслийн 4.1.5-д заасан "байгалийн нөөц" гэсэн нэр томъёоны тайлбарыг энэ хуулиар зохицуулах асуудал мөн эсэхийг анхаарах.
Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх	Боловсролын ерөнхий хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалтын "хамтран ажиллах, арга хэмжээ авах" гэснийг "Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуульд заасан Анхдагч холбоотой хамтран ажиллах, малчин өрхийн гишүүнийг насан туршийн суралцахуйн сургалтад хамруулах" гэж өөрчлөхөөр тусгасан нь нь Боловсролын ерөнхий хуулийн 3.1.7."насан туршийн суралцахуй" гэж хүн хэрэгцээ, сонирхол, боломж, нөхцөлдөө нийцүүлэн орон зай, цаг хугацаанаас үл хамааран мэргэжил, боловсрол, мэдлэг, чадвараа албан, албан бус сургалтаар болон амьдралын орчинд суралцах замаар тасралтгүй хөгжүүлэх, дээшлүүлэх үйл ажиллагааг;" гэж 30.1.3-д Аймаг, нийслэлийн Засаг дарга "харьяа нутаг дэвсгэртээ насан туршийн суралцахуйн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;" гэж, 30.1.10-д "орон нутаг дахь насан туршийн суралцахуйн төвийн үйл ажиллагааны болон тогтмол зардлыг санхүүжүүлэх, хамтран ажиллах;"-аар заасан. Мөн Сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрхэд "насан туршийн суралцахуйн төвийн бүтэц, орон тоонд нийцүүлэн төсвийг баталж, санхүүжүүлэх, хамтран ажиллах, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэх"-ээр заасантай нийцэж байгаа эсэхийг тодруулах.
Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан байна
Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг тусгасан байна

Явцын дүгнэлт 1

Нэгтгэн дүгнэхэд, бэлчээрийн газрыг зохистой ашиглах, хамгаалах, сэргээн сайжруулах зориулалтаар бэлчээрийн газрыг Малчин өрхийн анхдагч холбоонд гэрээгээр ашиглуулах зохицуулалт нь хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлагатай зорилгын хувьд нийцэх бөгөөд зарим орон нутагт үүсээд байгаа маргаантай асуудлыг шийдвэрлэх, бэлчээр ашиглагчдын эрхийг баталгаажуулах, одоо хэрэгжиж буй практикийг тогтворжуулах чухал ач холбогдолтой.

Малчин өрхийн анхдагч холбоо болон түүний гишүүний эрх, үүргийг тусад нь тодорхойлж, гэрээ шийдвэрлэх эрх бүхий субъектийн (Засаг дарга) шийдвэр гаргах хугацааг тодорхой заах, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байхтай холбогдсон харилцааг зохицуулах нь хуулийн төслийн практик хэрэгжих байдлыг сайжруулна.

“Гэрээний үндсэн нөхцөл” буюу минимум стандартыг хуульд тусгах нь бэлчээр ашиглагчдын тэгш байдлыг хангах тул зорилгод нийцэхээс гадна практикт хэрэгжих боломжтой.

2.2.Бэлчээрийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулахтай холбоотой зохицуулалт

Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд бэлчээрийн газрын ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлтийг сайжруулахтай холбоотой зохицуулалт оруулахаар тусгасныг нэг, бэлчээрийн газарт учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, хоёр, бэлчээр ашиглагчид гэрээний дагуу хүлээх нийтлэг үүрэг болон Засаг захиргааны нэгжийн даргын үүрэг, гурав, бэлчээрийн газрын зохистой хэрэглээг хангах гэсэн үндсэн хэсэгт хуваан түүний “Зорилгод хүрэх байдал”, “Практикт хэрэгжих байдал”, “Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтээр үнэллээ.

2.2.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Хуулийн төслийн дагуу Малчин өрхийн анхдагч холбоо хүсэлт гаргаж, бэлчээрийн газрыг ашиглахаар Засаг даргатай гэрээ байгуулна. Ийнхүү гэрээ байгуулах нь нэг, бэлчээр ашиглагчдын эрхийг баталгаажуулах, хоёр, бэлчээрийн зүй зохистой ашиглалт, менежментийг хариуцах төрийн бус “институци”-г бий болгох, гурав, төр бэлчээр хамгаалах үүргээ бэлчээр ашиглагчид шилжүүлэх зорилготой.

Бэлчээрийн мал аж ахуй нь газрыг үр ашигтайгаар ашиглах, хувьдаа захиран зарцуулахыг зорилгоо болгодоггүй харин газрыг хамгаалах үзлийг

баримталдаг³⁶ тул дээр дурдсанаар бэлчээр хамгаалах үүргийг бэлчээр ашиглагчдад шилжүүлж, хариуцлагыг бэхжүүлэх нь малчдын бэлчээрт хандах хандлага буюу малчид байгаль орчин, бэлчээрийг хамгаалдаг уламжлалд нийцнэ. Ийнхүү бэлчээр ашиглагч нь гэрээгээр ашиглаж байгаа бэлчээрийг бусад этгээд зөвшөөрөлгүй, дур мэдэн ашигласан тохиолдолд уг үйлдлийг зогсоохыг шаардах (injunction), цаашлаад эрх бүхий этгээдэд хохирлыг барагдуулахаар нэхэмжлэл гаргах эрхийг олгох нь бэлчээр ашиглуулах гэрээ байгуулах болсон шалтгаан, нөхцөлтэй нийцнэ. Өөрөөр хэлбэл, анхдагч холбоо өөрсдийн бэлчээр ашиглах эрхийг хэрэгжүүлэх үүднээс бусад этгээдийн хууль бус үйлдлийг таслах зогсоохыг шаардах, өөрийн үйл ажиллагаа, амьжиргааны үндсэн хэрэгсэл болсон "бэлчээр"-т учирсан хохирлыг арилгуулахаар шаардах эрхтэй гэсэн үг юм. Хэдийгээр "бэлчээр"-т учирсан хохирол нь түүний өмчлөгч болох "төр"-д учирсан хохирол боловч дам байдлаар тухайн бэлчээрийг ашиглах эрхтэй малчдын аж амьдралд нөлөөлөх тул нөлөөлөлд өртсөн анхдагч холбоо төрийн өмнөөс хохирлыг нөхөн төлүүлэхээр нэхэмжлэл гаргах замаар 1. хууль бус үйлдлийг таслан зогсоох 2. хохирол учирсан бэлчээрийг нөхөн сэргээх зорилгоор нөхөн төлбөрийг шаардаж болно. Гэвч хохиролд олгосон нөхөн төлбөр нь аль нэг малчин эсхүл анхдагч холбоонд бус тухайн засаг захиргааны нэгж дэх бэлчээрийн хохирлын нөхөн төлбөрийн сан руу шилжиж, гагцхүү тус бэлчээрийг нөхөн сэргээхэд зарцуулагдах нь зүйтэй. Үүнтэй холбоотойгоор бэлчээр ашиглагчдын бүлэгт дээрх бэлчээрийн сангийн зарцуулалтад саналын эрхтэй оролцох, зарцуулалтыг хянах чиг үүргийг оногдуулж болох юм.

Нүүдлийн мал ахуй нь харьцангуй хөдөлгөөнт шинжтэй бөгөөд малыг эзэнгүй бэлчээх тохиолдол элбэг тул мал амьтан бусдын бэлчээр лүү орох явдал цөөнгүй байдаг. Ийнхүү санамсаргүйгээр буюу мал, амьтан тогтоосон бэлчээрийн хуваарийг зөрчсөн тохиолдолд бэлчээр ашиглагч хариуцлага хүлээх талаар асуудал хөндөгдөнө. Энэ тохиолдолд Иргэний хуулийн 501 дэх хэсэгт³⁷ заасан гэм хорын зарчим үйлчлэх эсэхийг тодруулах нь зүйтэй. Шүүхийн практикийг судалж үзвэл³⁸, адуу автомашинд хохирол учруулсантай холбоотойгоор түүний өмчлөгчид гэм хорыг арилгахыг үүрэг хүлээлгэх эсэх маргааныг шийдвэрлэхдээ Иргэний хуулийн 501.1³⁹ дэх хэсгийг хэрэглэнэ

³⁶ А.Түвшинтөгс, Эд юмсын эрх нь газар болох тухай, Хууль дээдлэх ёс сэтгүүл, 2020, №4 (79), 206 дахь тал.

³⁷ 501 дүгээр зүйл. Амьтны учруулсан гэм хорыг хариуцах

501.1. Амьтны үйлдлээс хүний амь нас, эрүүл мэндэд учирсан гэм хорыг тухайн амьтныг өмчлөгч буюу эзэмшигч хариуцна.

501.2. Гэрийн тэжээвэр амьтан, эсхүл мэргэжлийн үйл ажиллагааны зүйл болдог бусад амьтны үйлдлээс бусдад гэм хор учирсан нь тухайн амьтныг өмчлөгч буюу эзэмшигчийн санаатай буюу илт болгоомжгүй үйлдэлтэй холбоогүй бол тэрээр гэм хорыг хариуцахгүй.

³⁸ Улсын дээд шүүхийн тогтоол, Дугаар 001/ХТ2017/00681, 2018 оны 05 сарын 01 өдөр, https://shuukh.mn/single_case/4278?start_date=&end_date=&id=3&court_cat=1&bb=1.

³⁹ Иргэний хуулийн 501.1 дэх хэсэгт Амьтны үйлдлээс хүний амь нас, эрүүл мэндэд учирсан гэм хорыг тухайн амьтныг өмчлөгч буюу эзэмшигч хариуцна гэж заасан.

гэж үзжээ. Эндээс практик дээр Иргэний хуулийн 501.1-т заасан “амьтан” гэхэд “мал” хамаарч байгааг харж болно. Гэвч мал сүрэг бусдын бэлчээрт нэвтрэх, бэлчих тохиолдол нь нүүдлийн мал аж ахуйн онцлог болохыг анхаарах нь зүйтэй байна. Иймд мал сүргийг Иргэний хуулийн 501.1-т заасан амьтнаас ялгамжтай авч үзэн эзэмшигч эсвэл өмчлөгч нь түүний мал, амьтан бусдын бэлчээр, отрын бүсэд нэвтэрсэнд холбогдуулан хариуцлага хүлээхгүй байх эсхүл түүний өмчлөлийн мал сүрэг бусдын эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулах боломжтой эсхүл учруулж буйг мэдсэн боловч таслан зогсоох үйлдэл хийгээгүй тохиолдолд хариуцлага хүлээлгэхээр зохицуулах нь зохистой.

Үүнээс гадна, малчин өрхийн анхдагч холбоо нь өөрөө бэлчээрийг зүй бусаар ашигласан, бэлчээрийн газрыг доройтуулсан, хохирол учруулсан тохиолдолд бэлчээрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэх механизм ажиллах боломжгүй болох тул түүний эсрэг шаардлага гаргах зохицуулалтыг тодорхой тусгах шаардлага байна. Энэ тохиолдолд Байгаль орчныг хамгаалах тухай хуулиар тогтоосон хохирол төлүүлэх механизмаас гадна төрийг төлөөлж Засаг дарга эсхүл эрх ашиг нь хөндөгдсөн анхдагч холбооны бусад гишүүд шаардлага гаргаж болох юм. Энэ хүрээнд Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн зохицуулалтаас эш татан нарийвчилсан зохицуулалт оруулж болох юм.

Бэлчээрийн газрыг хамгаалахтай холбоотой бэлчээр ашиглагчийн үүрэг

10.1.Анхдагч холбоо нь гэрээт бэлчээрийн газар, байгалийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр дараах үйл ажиллагаанд Засаг даргатай байгуулсан гэрээний дагуу гишүүдийг зохион байгуулж, дэмжлэг үзүүлнэ:

10.1.1.байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, доройтсон бэлчээрийг нөхөн сэргээх, хөрсний үржил шимийг сайжруулах ажлыг зохион байгуулах;

10.1.2.бэлчээрийн ургамлын ургалт, нөхөн сэргэлтэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байдлаар гэрээт бэлчээрийн газрыг гишүүн малчин өрхөд хуваарьтай ашиглуулах;

10.1.3.малын тоог бэлчээрийн даацад тохируулах;

10.1.4.байгалийн гамшгаас хамгаалах нөөц бүрдүүлэх, хадлан, тэжээл бэлтгэх;

10.1.5.гэрээт бэлчээрийн газар, байгалийн нөөцийг зүй зохистой ашиглахад хяналт тавих;

10.1.6.гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас өөр аймаг, сумын малчдын малыг сумын засаг даргын шийдвэрийн дагуу бэлчээрийн даацад тохируулан гэрээт бэлчээрийн газрыг түр ашиглуулахад хяналт тавих;

10.1.7.гэрээт бэлчээрийн газарт хорио цээртэй өвчин гарах, хөнөөлт шавж, мэрэгч амьтан тархахаас урьдчилан сэргийлэх, гарсан тохиолдолд холбогдох арга хэмжээг авах;

10.1.8.бэлчээрийн усан хангамжийг сайжруулах, хөв цөөрөм байгуулах;

10.1.9.мал, амьтны сэг зэм устгал, орчны халдваргүйтгэлийн арга хэмжээг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах;

10.1.10.газрын нэгдмэл сангийн ангилалд бүртгэгдсэн хадлан, тариалангийн талбайг ашиглах;

10.1.11.гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, эргүүл хийх, баримтжуулах, таслан зогсоох, мэдээлэх зэргээр эрх бүхий байгууллагатай хамтран ажиллах;

10.1.12.байгалийн нөөцийг хамгаалахтай холбогдсон хуульд заасан бусад үүрэг.


Бэлчээрийн даацын талаар

“Бэлчээрийн даац” гэж бэлчээрийн ургамлын өсөлт, хөгжилт, нөхөн сэргэлтэд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр тодорхой хугацааны туршид тухайн газарт бэлчээж болох мал, амьтны тоог ойлгоно.⁴⁰ Бэлчээрийн даацыг хэтрүүлэн ашиглана гэдэг нь хөрснөөс дээш цухуйсан ургамлын навч найлзуурыг нөхөн төлжих чадваргүй болгож улмаар ургамлын үндэс нь үхжиж, бүрмөсөн устгахыг хэлнэ.

Энэхүү бэлчээрийн харилцааг зохицуулах нэг үндэслэл нь бэлчээрийн даац хэтрэлт юм. Ус цаг уур, байгаль орчны хүрээлэнгээс 2020-2021 оны өвөл, хаврын бэлчээрийн даацын тухай гаргасан мэдээлэлд Монгол Улсын нийт бэлчээр нутгийн 40 гаруй хувьд бэлчээрийн даац 1-3 дахин хэтэрсэн, 25 орчим хувьд нь 3-5 дахин хэтэрсэн, 20 орчимд хувьд нь олон дахин хэтэрсэн байгаа тухай онцлон мэдээлжээ.

⁴⁰ Малын бэлчээрийн даац тооцох нэгдсэн аргачлал, Үндэсний статистикийн хорооны дарга, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 8 сарын 05-ны өдрийн тушаалын хавсралт.

2020-2021 оны өвөл, хаврын бэлчээрийн даац, %
(багийн нутгаар)



Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 23.4.7-д “малын тоог бэлчээрийн даацад тохируулах;” үүргийг бэлчээр ашиглагчид хүлээлгэжээ.

Бэлчээрийн даацыг тогтоохдоо “Малын бэлчээрийн даац тооцох нэгдсэн аргачлал”-ыг баримталдаг. Бэлчээрийн төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх ажлыг зохион байгуулж, бэлчээрийн төлөв байдлыг тогтоох чиг үүргийг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, улсын хэмжээний бэлчээрийн мониторинг хийх, Монгол Улсын бэлчээрийн даацын мэдээлэл гаргах чиг үүргийг Цаг уур, орчны шинжилгээний газар тус тус гүйцэтгэж байна.⁴¹ Бэлчээрийн даацыг тооцох харилцаа харьцангуй сайн зохицуулагдсан гэж үзэж, даацыг тогтоох асуудлыг хөндөөгүй болно.

Сүүлийн 5 жилийн дунджаар тооцоход, Монгол Улсын оны эхний малын тоог 100% гэж үзвэл жил бүр төлөөрөө 35% өсөж, 22% нь зарлагадаж, 13%-р өсөөд байна. Энэ нь мал, малын түүхий эд эдийн засгийн эргэлтэд орохгүй байгааг харуулж байна.⁴²

Түүнчлэн, бэлчээрийн даацад тавих хяналтыг сайжруулах шаардлага үүссэн. Малын бэлчээрийг хамгаалах гол үзүүлэлт нь “бэлчээрийн даац” тул даацад тулгуурлан бэлчээр ашиглалтыг бодлогын түвшинд хянах,

⁴¹ Малын бэлчээрийн даац тооцох нэгдсэн аргачлал, Үндэсний статистикийн хорооны дарга, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 8 сарын 05-ны өдрийн тушаалын хавсралт.

⁴² Монгол орны бэлчээрийн тулгамдсан асуудал: Гарц ба шийдэл, 2019, 42 дахь тал, https://www.undp.org/sites/g/files/zskgke326/files/migration/mn/Pastureland_Mongolia_Report.pdf.

зохицуулах, бэлчээр хамгаалал, нөхөн сэргээлтэд зориулсан төсвийн болон бусад санхүүжилтийг зохистой зарцуулах нөхцөлийг бүрдүүлэх хэрэгтэй.⁴³

Бэлчээрийн доройтлыг үүсгэж буй олон шалтгаан, нөхцөл байгааг өмнө өгүүлсэн. Хэдийгээр бэлчээрийн даац хэтрэлт нь бэлчээрийн доройтлыг үүсгэж буй үндсэн шалтгаан биш ч түүнийг багасгах нь бэлчээрийн доройтлыг удаашруулахад үр нөлөөтэй тул бэлчээрийг хамгаалах зорилгод нийцэж байна.

Бэлчээрийг нөхөн сэргээх талаар

Монголчууд бэлчээрийг сэлгэн ашигладаг уламжлалтай боловч сүүлийн жилүүдэд нүүдлийн мал ахуйг эрхлэх явцад хүрээлэн буй орчноо хамгаалах асуудал орхигдож, хүрээлэн буй орчноо хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой уламжлалт арга барил алдагдаад байгаа юм. Иймд бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах уламжлалд суурилан орчин үеийн эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлага үүсэж байна.

Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 10.1.1-т Анхдагч холбоо нь "байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, доройтсон бэлчээрийг нөхөн сэргээх, хөрсний үржил шимийг сайжруулах ажлыг зохион байгуулах;", 10.1.2-т бэлчээрийн ургамлын ургалт, нөхөн сэргээлтэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байдлаар гэрээт бэлчээрийн газрыг гишүүн малчин өрхөд хуваарьтай ашиглуулах" хэмээн бэлчээрийн харилцаанд оролцогчдыг үүрэг хүлээлгэсэн байна.

Бэлчээрийн нөхөн сэргээлт нь бэлчээрийн тухайн нөхцөл дэх төлөв байдал, сэргэхэд шаардагдах хугацаа, цаг уурын нөхцөл, малчдын оролцоо хэр байхаас шууд хамааралтай. Иймд бэлчээрийн менежмент зайлшгүй шаардлагатай бөгөөд үүний нэг арга нь бэлчээр төлөвлөлт байж болно. Мал бэлчээрлэлтийг хязгаарлах, бэлчээр ашиглалтыг даацад тохируулснаар бэлчээр сайжрах уу гэдэг асуудал малчид, судлаачдын хувьд зарчмын гол асуулт болж байна. Одоогоор, бэлчээр ашиглалтын үр нөлөөг хянах фотомониторингийн мэдээ харьцангуй богино хугацааг хамрах хэдий ч бэлчээрээ зөв ашигласнаар доройтсон бэлчээр нөхөн сэргээгдэж буй жишээ байна.⁴⁴ Үүнд:

Архангай аймгийн Цахир сумын Баян-Уул БАХ-ийн туршлага

Баян-Уул БАХ-ийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор багийн ИНХ-ын 2018 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдаанаас БАХ-ийн бэлчээрийн тодорхой хэсгүүдийг 5 дугаар сарын 15-

⁴³ Малын бэлчээрийн даац тооцох нэгдсэн аргачлал, 2019, 4 дэх тал.

⁴⁴ Монгол орны бэлчээрийн төлөв байдлын үндэсний тайлан, 2018, 24 дэх тал.

наас 8 дугаар сарын 20 хүртэл малын хөлөөс чөлөөлж амрах шийдвэр гаргасан. Нийт 44550 га бэлчээр нутгийнхаа 8400 га-д нь Баян-Уул БАХ-ийнхан зусаж намаржих бөгөөд үлдсэн 36400 га бэлчээртээ өвөлжиж, хаварждаг ажээ. Бусад сумтай адилаар Хужиртын давааны өвөл-хаврын бэлчээрт хөрш малчид орж ашиглалтын бус улиралд малаа бэлчээдэг учраас үндсэндээ ургалтын хугацаанд ээлжгүй, амраалгүй ашиглагддаг газар юм. Сумаас тэдгээр малчидтай хийсэн зөвлөлдөх уулзалтаар тохиролцсоны дагуу 8573 (23,189 хонин толгой) малыг өөр нутагт, түүний дотор Загастайн эх, Нуурын эх, Бүүргийн баруун эх рүү нүүлгэжээ. Өвөлжөө/хаваржааны бэлчээрийг өнжөөж амрааснаар олон наст үетэн ургамал болон идэмж сайтай алаг өвсний бүрхэц нэг жилийн нэмэгдсэн байна.

Увс аймгийн Зүүнговь сумын Тохой БАХ-ийн туршлага

Тохой БАХ-ийн малчид 12,210 га өвөл-хаврын бэлчээрээ 2016-2017 онуудад хоёр жилийн хугацаагаар амраажээ. Үүний үр дүнд ургамлын нийт бүрхэц 10.6 хувиар, хялганын бүрхэц 18.8 хувиар тус тус нэмэгдэн бэлчээрийн ургац 264 кг/га-аас 412 болон өсөж тэжээлийн нөөц 35.9 хувиар буюу 3199.7 тонн/га байснаас 4993.47 тонн/га-д хүрсэн байна.

Говь-Алтай аймгийн Халиун сумын Хантайшир БАХ-ийн туршлага

Хантайшир БАХ-ийн малчид өвөл-хаврын 16700 га бэлчээрээ 2016-2017 онд хоёр жил амрааснаар ургамлын нийт бүрхэц нь 8.9, хялганын бүрхэц 4.9 хувиар тус тус нэмэгдэн ургацын хэмжээ 115 кг/га байсан бол 236 кг/га болон өсжээ. Ингэснээр тэжээлийн нийт нөөц нь 1923.1 тонн/га-аас 3946.6 тонн/га-д хүрч 51.2 хувь нэмэгдсэн байна.

Эндээс дүгнэвэл, бэлчээрийн газрыг сэлгэх, өнжөөх, улирлаар нүүх хуваарийг мөрдөх, тогтоосон хугацаанд мал оруулах, гаргахыг үүрэг хүлээлгэх нь бэлчээрийн газрыг нөхөн сэргээх, доройтлоос хамгаалахад үр нөлөө үзүүлж байна. Иймд дээрх зохицуулалт нь бэлчээрийг хамгаалах зорилгод нийцнэ гэж дүгнэлээ.

Мөн төслийн 10.3-т “Гэрээт бэлчээрийн газарт энэ хуулийн тэжээлийн ургамлаас бусад малын тэжээл, тариалангийн ургамал тариалах-ийг хориглож, 10.4-т “Гэрээт бэлчээрийн газраас бусад газарт тэжээлийн болон бусад таримал ургамал тариалах асуудлыг Тариалангийн тухай хуулиар⁴⁵ зохицуулах”-аар тусгажээ.

Байгалийн ургамлын тухай хуульд зааснаар ургамлыг түүний нөөц, нөхөн сэргэх чадварыг нь харгалзан нэн ховор, ховор, элбэг гэж ангилна. Юун түрүүнд “ургамал түүх” болон “ургамал ашиглах” зэрэг нэр томъёог

⁴⁵ Тариалангийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2016 оны 08 дугаарт нийтлэгдсэн.

ялгамжтай ашиглаж, хэрэглэж байгааг анхаарах нь зүйтэй. Ургамал ашиглах эрхтэй этгээд ургамлыг журмын дагуу түүж болно. Ургамал ашиглах талаар дэлгэрэнгүй авч үзвэл, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нэн ховор ургамлыг зөвхөн судалгаа, шинжилгээний, ховор ургамлыг ахуйн болон судалгаа, шинжилгээний, элбэг ургамлыг судалгаа, шинжилгээний, ахуйн үйлдвэрлэлийн зориулалтаар тус тус ашиглана. Элбэг ургамлыг ашиглахад зөвшөөрөл шаардахгүй ч ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах бол түүний тархац газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлтийг үндэслэн тодорхой хугацаатайгаар Газрын тухай хуульд заасан журмын дагуу Сум, дүүргийн Засаг даргатай гэрээ байгуулан эзэмшүүлдэг.

2.2.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Бэлчээрийн газрыг хамгаалахтай холбоотой Засаг даргын үүрэг

Нэг сумд олон тооны анхдагч холбоо бэлчээр ашиглах тул тэдгээрт хяналт тавих, бэлчээрийн хуваарийг мөрдүүлэх чиг үүргийг сумын Засаг дарга хариуцах нь цаг хугацаа, хүний нөөц хүрэлцэхгүй, хяналт тавихад хүндрэлтэй.

Иймд бэлчээрийн хуваарийг мөрдүүлэх, бэлчээрийг хамгаалах чиг үүргийг Сумын Засаг дарга бус Багийн Засаг даргад хүлээлгэх нь оновчтой байж болох юм.

Засаг захиргааны нэгж дэх Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, хэлтсээс сумын нөөц бэлчээрийн хэмжээ, байршлыг газрын нэгдмэл сангийн бусад ангиллын газартай давхцуулахгүйгээр зураглан мэдээллийн санд оруулах чиг үүргийг хэрэгжүүлдэг байна.

Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд бэлчээрийн газрыг хамгаалах талаар сумын газрын даамал, дүүргийн газрын алба дараах эрхтэй байхаар тусгасан. Үүнд:

1. Бэлчээрийн даацыг сумын бэлчээр хариуцсан мэргэжилтэнтэй хамтран жил бүр тогтоох;
2. Малчин өрхийн анхдагч холбоонд ашиглуулах бэлчээрийн газрын зааг, хэмжээ, байршлын зургийг үйлдэх, газрын мэдээллийн санд бүртгэх;

Сумын Засаг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг үндэслэн бэлчээрийн газрыг малчин өрхийн анхдагч холбоонд ашиглуулах гэрээ байгуулах бөгөөд гэрээг бүртгэх, гэрээт бэлчээрийн газрын ашиглалт, төлөв байдлын үнэлгээг үндэслэн сумын бэлчээр

хариуцсан мэргэжилтэнтэй хамтран бэлчээр ашиглалтын гэрээний биелэлтэд тогтмол хяналт тавих, дүгнэх.

3.1.3. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Аргачлалд заасан асуулт	Хуулийн төслийг үнэлсэн байдал
Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	Судалгааны тайлангийн 3.1.1 дэх хэсэгт зааснаар хуулийн төслийн холбогдох зохицуулалтууд бэлчээрийг хамгаалах зорилгод нийцжээ.
Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх	Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн болно.
Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх;	4.1.Энэ хуульд заасан дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно: 4.1.1.“малчин” гэж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн⁴⁶ 3.1.9-д заасныг; 4.1.2.“малчин өрх” гэж мал аж ахуй эрхэлж, мал, түүний ашиг шимээр үндсэн орлогоо олдог өрхийг; 4.1.3.“Малчин өрхийн анхдагч холбоо” гэж сайн дурын үндсэн дээр, малчдын нийтлэг эрх ашгийн төлөө өөрөө удирдах зарчимд үндэслэн энэ хуулийн дагуу байгуулагдсан хуулийн этгээдийг. 4.1.4.“гэрээт бэлчээрийн газар” гэж Газрын тухай хуулийн 3.1.11-д заасныг; 4.1.5.“байгалийн нөөц” гэж гэрээт бэлчээрийн газар дахь байгалийн ургамал, ой, ойн дагалт баялаг, уст цэг, булаг шанд, ан амьтан зэргийг; Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа

⁴⁶ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2011 оны 40 дугаарт нийтлэгдсэн.

Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа
Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардаагүй.
Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан
Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулаагүй
Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгаагүй.
Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх	Сум, дүүргийн Засаг дарга хуульд заасан дараах үүргийг гуравдагч этгээд, мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх боломжтой гэж үзлээ. Үүнд: 1. Газрыг цөлжилтөөс сэргийлэх, бэлчээрт мод, бут сөөг, олон наст ургамал тарих, бууцаар бордох, хаших зэрэг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, хамгаалах ажлыг зохион байгуулах; 2. Бэлчээр, хадлангийн газар болон байгалийн нөөцийн хамтын менежментийг хэрэгжүүлэх, биологийн төрөл, зүйлийг хамгаалах, нөхөн сэргээх зорилгоор зам, даваа засах, гүүр, инженерийн хийцтэй худаг, хөв цөөрөм барьж байгуулах, булаг шандын эхийг хамгаалах зэрэг хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх.
Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх	Хуулийн төсөлд бэлчээр ашиглах гэрээний дагуу төлбөр авах зохицуулалт байхгүй.

Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх	Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалт байхгүй.
Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгаагүй
Хуулийн төслийн зүйл, заалт жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	Хуулийн төслийн зүйл, заалт жендерийн эрх тэгш байдалтай зөрчилдөөгүй.
Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдаагүй,
Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдаагүй.
Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх	Зөрчлийн тухай хуулиар хариуцлага тооцож байна.

2.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулахдаа Хууль тогтоомжийн тухай хуулийн 4 дүгээр бүлэгт болон Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасны дагуу хуулийн төсөл боловсруулахад тавигдах шаардлагуудыг хангасан эсэх, түүнчлэн хэрэглэх, хэрэгжүүлэх этгээд хуулийг ойлгож хэрэгжүүлэх боломжтой байдлаар боловсруулагдсан эсэхийг шалгаж үзэхийн тулд хуулийн төслийг бүхэлд нь сонгон авлаа.

Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь 5 зүйлийн холбогдох заалтуудад нэмэлт, өөрчлөлт оруулахаар тусгасан байна.

Засгийн газрын 59 дүгээр аргачлалын дагуу, “Ойлгомжтой байдал” гэсэн шалгуурын хүрээнд хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийг хэрэгжүүлэх, хэрэглэх этгээдэд ойлгомжтой томъёологдсон эсэхийг шалгаж тогтооно. Үүнд:

1. Хууль тогтоомжийн төсөлд хэрэглэсэн нэр томъёо, хэл зүйн найруулга, үг сонголтын хувьд ойлгомжтой байгаа эсэх, иргэд, байгууллагууд буюу хуулийн төсөлд хамаарах этгээдүүд тухайн зохицуулалтыг шууд ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэх боломжтой байгаа эсэхийг шалгаж үнэлье.

Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн ойлгомжтой байдлыг үнэлэхэд тухайн төсөлд заасан нэр томъёонуудын ойлгомжтой байдал чухал ач холбогдолтой. Хуулийн төсөлд “малчин”, “малчин өрх”, “Малчин өрхийн анхдагч холбоо” “гэрээт бэлчээрийн газар”, “байгалийн нөөц” гэсэн нэр томъёоны тодорхойлолт “ойлгомжтой” байдлаар зохицуулагдсан гэж үзэж байна.

Гэхдээ хуулийн төслийн 4.1.5-д заасан “байгалийн нөөц” гэсэн нэр томъёоны тодорхойлолтыг энэ хуульд тусгах нь зохистой эсэхийг тодорхой болгох нь зүйтэй юм.

2. Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай болон дагалдах бусад хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн холбогдох зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэх

29 дүгээр зүйл.Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага	Хуулийн төсөл холбогдох шаардлагыг хангасан эсэх
29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай харшлаагүй бөгөөд “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Алсын хараа 2050”, “Шинэ сэргэлтийн бодлого” зэрэг бодлогын баримт бичгүүдтэй нийцсэн байна.
29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Холбогдох хуулийн төслөөр Бэлчээрийг гэрээгээр ашиглах болон бэлчээрийн газрыг зүй зохистой ашиглах, хамгаалах харилцааг хамруулахаар зохицуулсан.
29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгаагүй байна.

29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах заалтыг тусгаагүй байна.
29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Судалгааны харилцан уялдаа бүлэгт дурдагдсан зарим зүйл, заалтыг тодруулах шаардлагатай.
29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгаагүй байна.
29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Хуулийн төсөлд бусад хуулиас эш татсан зохицуулалтуудыг тусгасан, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байна.
29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	Уг хуулийн төслөөр бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хуулийн үйлчлэх хүрээ нь тодорхой байна.
29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;	Эдгээр зохицуулалтыг энэхүү хуулийн төслөөр зохицуулах шаардлага байхгүй.
29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Байхгүй.
29.1.11.хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.	Уг хуулийн төсөл нь “Хуулийн зорилго, зорилт” гэсэн зүйлтэй, зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгасан байна. Харин Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд “зорилго”-г тусгайлан

2.4. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Уг хуулийн төсөлд тодорхой этгээдэд үүрэг хүлээлгэсэн, хуулийн этгээдэд ачаалал, хүндрэл үүсгэх, эсхүл төрийн байгууллагад шинэ бүтэц бий болгох, чиг үүрэг нэмэх зэрэг зохицуулалт тусгасан бол “Хүлээн зөвшөөрөгдөх байдлын судалгаа хийх” гэсэн шалгах хэрэгслийн хүрээнд шалгадаг. Уг шалгуурын хүрээнд хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээд, төрийн бус байгууллагаас санал авах, санал асуулга явуулах, холбогдох байгууллага, этгээдийн хүрээнд ярилцлага, хэлэлцүүлэг явуулах зэргээр хуулийн төслийн зохицуулалтыг хүлээн зөвшөөрч байгаа эсэхийг судална.

Хуулийн төсөл батлагдсанаар тодорхой бэлчээрийн газрыг хамтран ашиглаж буй малчид нэгдэн, холбооны зохион байгуулалтад орж, Засаг даргатай бэлчээр ашиглалтын гэрээ байгуулснаар тухайн бэлчээрийн газартаа бэлчээрийн менежментийг хэрэгжүүлэх, бэлчээрийн даацыг хэтрүүлэхгүй байх, бэлчээрийг сэлгэх, өнжөөх зэрэг үүрэг хүлээнэ. Иймд хуулийн төсөлд тусгагдсан дээрх тогтолцоог малчид хүлээн зөвшөөрөх эсэхийг дүгнэх шаардлагатай тул бэлчээрийн зүй зохистой ашиглах, хамгаалахтай холбоотой малчдын төлөөллийн нийтлэг байр суурийг авч үзэх нь зүйтэй.

Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос “Бэлчээрийн доройтлыг бууруулахад чиглэсэн хууль, эрх зүйн орчныг сайжруулах нь” сэдэвт хэлэлцүүлгийг Төрийн ордны “Их Эзэн Чингис хаан” танхимд 2023 оны 3 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулсан.⁴⁷ Тус хэлэлцүүлэгт оролцсон салбарын мэргэжилтнүүд нийт газар нутгийн 70 гаруй хувийг эзэлдэг бэлчээрийн 65 хувь доройтсон, бэлчээр ашиглалтын ачааллын өнөөгийн горимыг өөрчлөн тохируулбаас нийт доройтсон бэлчээрийн 80 гаруй хувь нь байгалийн аясаараа сэргэх боломжтойг тэмдэглэн, малын тоо толгойг даацад тохируулан зохицуулах шаардлагатай тухай ихэнх малчид санал бодлоо илэрхийлж буй ч юунаас эхлэх, даацаас хэтрээд байгаа малаа хэрхэх талаар тодорхой шийдэлгүй байгаа талаар дурджээ.⁴⁸

Одоогоор хэд хэдэн аймагт бэлчээрийг гэрээгээр ашиглах практик хэрэгжиж байна. Энэхүү практик нь ихэнхдээ гадны байгууллагын төслийн санхүүжилтээр хэрэгждэг бөгөөд төсөлд хамрагдсан малчид бэлчээрийн

⁴⁷ “Бэлчээрийн доройтлыг бууруулахад чиглэсэн хууль, эрх зүйн орчныг сайжруулах нь” сэдэвт хэлэлцүүлэг боллоо, Parliament.mn, 2023.03.22, <https://www.parliament.mn/nn/29742/>

⁴⁸ Бэлчээрийн доройтлыг бууруулах чиглэлээр хэлэлцлээ, MNB, 2023.03.22, <https://www.mnb.mn/i/288326>.

доройтлоос хамгаалах, урьдчилан сэргийлэх бэлчээрийн менежментийн ач холбогдлыг хүлээн зөвшөөрч⁴⁹ байгаа тул хуулийн төсөл батлагдсанаар бэлчээрийн менежментийг улсын хэмжээнд тогтвортой хөгжүүлэх үндэслэл бүрдэнэ.

Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл дэх малчин өрхийн анхдагч холбоог хүлээн зөвшөөрөх үндэслэлийг дараах байдлаар тодорхойлов. Үүнд:

1. Хуулийн төсөл нь Үндсэн хууль дахь газрын зохицуулалтын үзэл санаанд нийцэж байна. Үндсэн хуулийн 6.1.-д “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна.” хэмээн, 6.2.-д “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн. 6.3.Бэлчээр, нийтийн эдэлбэрийн ба улсын тусгай хэрэгцээнийхээс бусад газрыг зөвхөн Монгол Улсын иргэнд өмчлүүлж болно” хэмээн тус тус заасан нь бэлчээрийн газрыг төр хамгаалах, бэлчээрийн газрыг өмчлүүлэхгүй байх үзэл санааг агуулж байна. Өөрөөр хэлбэл, уг хуулийн төсөл нь бэлчээрийн газрыг малчдад өмчлүүлэхгүйгээр, үр ашигтай ашиглуулах замаар хамгаалахад чиглэсэн хэмээн дүгнэж болно.
2. Хуулийн төсөл нь Монголчуудын бэлчээрийн газрыг хамгаалах, үр ашигтай ашиглахад чиглэсэн уламжлалт сэтгэлгээнд үндэслэсэн байна. Өөрөөр хэлбэл, Монголчууд бэлчээрийн мал аж ахуй нь газрыг үр ашигтайгаар ашиглах, хувьдаа захиран зарцуулахыг зорилгоо болгодоггүй харин газрыг хамгаалах үзлийг баримталдаг⁵⁰ тул дээр дурдсанаар бэлчээр хамгаалах үүргийг бэлчээр ашиглагчдын бүлэгт шилжүүлж, хариуцлагыг бэхжүүлэх нь малчдын бэлчээрт хандах хандлага, байгаль орчныг хамгаалах уламжлалыг сэргээн хамгаална.
3. Хуулийн төсөл дэх бэлчээр ашиглалтын гэрээг иргэний эрх зүйн суурь зарчим болон хамгаалалтын аргын үүднээс авч үзвэл бүрэн хүлээн зөвшөөрөгдөхөөр байна. Нэгдүгээрт, төрийн зүгээс бэлчээрийн газрын өмчлөгчийн хувьд өөрийн өмчлөлийн газрыг малчдад ашиглуулах асуудал нь гэрээний чөлөөт байдлын зарчимд нийцнэ. Хоёрдугаарт, бэлчээр ашиглуулах гэрээ нь бэлчээр ашиглагчдын бэлчээрийг ашиглах анхдагч эрх болон гэрээгээр ашиглах бэлчээрт бусад этгээд хохирол учруулсан тохиолдолд үйлдлийг зогсоохыг шаардах, хохирол нөхөн төлүүлэх эрхийг баталгаажуулсан байгаа нь иргэний эрх зүйн хамгаалалтын аргыг дэмжихээр байна.

⁴⁹ Swiss Agency for Development and Cooperation, Collective Action in the Pastoral Economy of Mongolia: Cooperation, Herd and Pasture Management, Economic Decisions, and Livestock Health, 2015, p39.

⁵⁰ А.Түвшинтөгс, Эд юмсын эрх нь газар болох тухай, Хууль дээдлэх ёс сэтгүүл, 2020, №4 (79), 206 дахь тал.

4. Ийнхүү, хуулийн төслийн зохицуулалт нь Үндсэн хууль дахь газрын эрх зүйн суурь үзэл баримтлал, Иргэний хуульд нийцсэн байхаас гадна бэлчээрийн газрыг хамгаалах, ашиглахад чиглэсэн малчдын уламжлалт сэтгэлгээнд тулгуурласан байна.

III. НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Хуулийн төсөл нь бэлчээрийн менежментийн тогтолцоог нэвтрүүлэх замаар “Нийтийн эзэмшлийн эмгэнэл”-ийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн **“Остро́мын онол”**-д тулгуурласан байна. Ингэхдээ, **“Остро́мын онол”**-ыг Монгол Улсад хэрэгжүүлсэн ОУХБд-ын төслийн туршлагад тулгуурлаж, бэлчээр газар буюу хөрөнгөд суурилсан менежментийн зохион байгуулалтыг хуульчлахыг зорьсон байна. Энэ нь Монгол Улсын Үндсэн хууль дахь газрын эрх зүйн суурь үзэл баримтлалд, Иргэний хууль, малчдын уламжлалт сэтгэлгээнд нийцсэн болохыг дурдах нь зүйтэй.

Хуулийн төсөлд хуульд нэмж хэрэглэгдэх нэр томьёог тодорхойлж, бэлчээрийн зориулалт, ангилал, төрөл, заагийг тогтоон, бэлчээрийг ашиглуулах, бэлчээрийг сайжруулах, хамгаалах, эдгээр үйл ажиллагааг төлөвлөх, удирдан зохион байгуулах, оролцогч талуудын эрх, үүргийг тогтоох зэрэг харилцааг зохицуулжээ.

Засгийн газрын 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”-г баримтлан Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл дэх бэлчээрт холбогдох зохицуулалтын үр нөлөөг дараах байдлаар үнэлэв.

Нэг. Бэлчээрийг гэрээгээр ашиглуулах талаар

Хуулийн төсөлд тусгагдсан бэлчээрийн гэрээтэй холбоотой зохицуулалт нь одоо практик дээр хэрэгжиж байгаа Засаг дарга улирлын бэлчээрийг гэрээгээр ашиглуулах эрх хэмжээтэй эсэх хуулийн маргаантай асуудлыг шийдвэрлэх, цаашлаад нэгэнт хэрэгжиж байгаа практикийг үр дүнтэй хувилбар руу шилжүүлэх чухал нөлөө үзүүлэхээр байна. Энэ хүрээнд бэлчээрийн газрыг хамгаалах, үр ашигтай байдлыг хангах үүднээс бэлчээрийн газрыг гэрээгээр ашиглуулах нь оновчтой хувилбар байж болно.

Хуулийн төслийн үр нөлөө нь эерэг байх боловч, зохицуулалтыг сайжруулах үүднээс дараах саналыг дэвшүүлэв.

- **Малчин өрхийн холбооны эрх зүйн байдал:** Малчин өрхийн анхдагч холбооны статусыг тодруулж, гишүүдийн “ашиг сонирхол”-д суурилсан бус, бэлчээрийн газар буюу капиталд суурилсан хамтын нэгдэл гэдгийг тодруулах нь хуулийн төслийн хэрэгжилтийг хүрээнд хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахад чухал ач

холбогдолтой байна. Энэ нь Иргэний хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.-д заасан суурь зарчмын хүрээнд хүлээн зөвшөөрөгдөнө.

- **Малчин өрхийн анхдагч холбооны эрх, үүрэг:** Малчин өрхийн анхдагч холбоо нь Иргэний хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэгт заасан Нэгдмэл, тодорхой зорилго тавьсан хэд хэдэн этгээд сайн дурын үндсэн дээр нэгдэж байгуулсан, гишүүнчлэл бүхий хуулийн этгээд байна
- **Гэрээнд заавал тусгах нөхцөлийг хуульд тусгах эсхүл стандарт гэрээ:** бэлчээрийн менежментийг улсын хэмжээнд тэнцвэртэй хөгжүүлэх үүднээс гэрээнд зайлшгүй тусгах агуулгыг хуулиар тогтоох эсхүл төрийн эрх бүхий байгууллагаас гэрээний ерөнхий стандартыг батлах асуудлыг харгалзаж болно. Гэсэн хэдий ч, гэрээний тусгай нөхцөлийг хэт хатуу тогтоохоос зайлсхийж, орон нутгийн онцлог, гэрээний чөлөөт байдлын зарчимд нийцүүлэн харилцан тохиролцох боломжийг талуудад үлдээх нь зүйтэй.
- **Бусад хууль тогтоомжтой уялдуулах:** Газрын тухай хууль нь нийтийн болон хувийн эрх зүйн хууль тогтоомжтой холбогдож, цогц байдлаар хэрэглэгдэх тул нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд тусгаж бус нэр томьёог “харилцан уялдаа” хэсэгт заасны дагуу жигдлэх нь зүйтэй.

Хоёр. Бэлчээрийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах талаар

Бэлчээрийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулахад чиглэсэн зохицуулалтууд нь бэлчээрийн доройтлыг арилгах, бэлчээрийн газрыг нөхөн сэргээхэд чухал ач холбогдолтой ч хуулийн төсөл дэх зарим зохицуулалтыг сайжруулах шаардлага байна. Гэвч бэлчээрийг даацыг хэтрүүлэхгүй байхад чиглэсэн арга хэмжээ авах нь бэлчээрийн доройтлыг үндсээр нь шийдвэрлэхгүй.

Бэлчээр ашиглагч гэрээгээр ашиглаж буй газартаа өөрөө хохирол учруулсан эсхүл бусад этгээд түүний гэрээт бэлчээрт хохирол учруулсан тохиолдлыг ялгамжтай авч үзэн, тус бүрд баримтлах зарчим, аргачлал, процессыг тодорхой заах шаардлагатай хэдий ч бэлчээрийг хамгаалах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ, үүрэг нь зорилгодоо нийцсэн байна.

Ийнхүү, хуулийн төсөл нь Засгийн газрын 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”-ын хүрээнд тавигдсан “зорилгод хүрэх байдал”, “практик хэрэгжих боломж”, “харилцан уялдаа”, “ойлгомжтой байдал”, “хүлээн зөвшөөрөгдөх байдал”-ын шалгуурыг хангасан байна.

Мөн уг үр нөлөөний судалгааны хүрээнд дэвшүүлсэн дээрх саналууд нь хуулийн төслийн үр нөлөөг сайжруулахад чиглэсэн хараат бус

судалгааны байр суурь бөгөөд одоогийн хуулийн төслийг үнэ цэн, ач холбогдлыг бууруулахгүй болохыг дурдах нь зүйтэй.

IV. ЭХ СУРВАЛЖ

Монгол хэл дээрх

Хууль тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн хууль.
2. Газрын тухай хууль.
3. Иргэний хууль.
4. Байгаль орчныг хамгаалах тухай хууль.
5. Ойн тухай хууль.
6. Байгалийн ургамлын тухай хууль.
7. Зөрчлийн тухай хууль.
8. Малын бэлчээрийн даац тооцох нэгдсэн аргачлал, 2019.
9. 20 сумын Бэлчээр хамгаалах /хариуцлагыг бэхжүүлэх/ журам, http://fodder.mofa.gov.mn/category/belcheer_ashiglah/.

Ном, өгүүлэл, судалгааны тайлан

1. Г.Жаргал, Д.Солонго, М.Уянга, Газар: Баялгаас өмч үүсэх арга, Арилдал ХХК, 2014.
2. И.Бямбабаатар, Хөгжлийн эрэлд: Мал аж ахуй, байгаль хамгаалах салбар дахь хөгжлийн байгууллагын хөндлөнгийн оролцоо, МУИС хэвлэлийн газар, 2021.
3. Н.Лүндэндорж, Монгол Улсын Үндсэн хуулийн шинжлэх ухааны тайлбар, Адмон Принт, 2022.
4. Н.Лүндэндорж, Монголчуудын өмчлөх эрхийн үзэл сэтгэлгээний уламжлал, шинэчлэл, УБ, 2004.
5. Монгол орны бэлчээрийн тулгамдсан асуудал: Гарц ба шийдэл, 2014.
6. М.Сувд, Бэлчээрийн харилцааны эрх зүйн зохицуулалт: Төлөв байдал, тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам /Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл/, 2016.
7. Олон улсын хөдөлмөрийн байгууллага, ХХI зууны малчин, Модуль 8. Ганц мод гал болдоггүй, 2013.
8. Н.Баярмаа, Монгол Улсын Үндсэн хууль дахь эдийн баялгийн эрх: Өмчийн нэгдмэл тогтолцоог бүтээх нь, Үндсэн хуулийн болон захиргааны эрх зүйн үндсэн асуудал: Хямралын үеийн тулгамдсан асуудал хурлын эмхэтгэл, 2023.
9. А.Түвшинтөгс, Эд юмсын эрх нь газар болох тухай, Хууль дээдлэх ёс сэтгүүл, 2020.
10. Монгол орны бэлчээрийн төлөв байдлын үндэсний тайлан, 2018.
11. Г.Сурахбаяр, Ч.Болормаа нар, Монгол Улсын эрдэс баялгийн эрх зүйн хөгжил дэх тулгамдсан асуудал: Иргэний оролцоо буюу нийтийн лиценз, Хууль дээдлэх ёс сэтгүүл 2023 (1), №92.

Цахим эх сурвалж

1. https://shuukh.mn/single_case/14780?start_date=&end_date=&id=2&court_cat=1&bb=1.
2. http://fodder.mofa.gov.mn/category/belcheer_ashiglah/.

Гадаад хэл дээрх

Ном, өгүүлэл, судалгааны тайлан

1. Herzberg, Roberta Q, "Elinor Ostrom's Governing the Commons: Institutional Diversity, Self-Governance, and Tragedy Diverted." The Independent Review, vol. 24, no. 4, 2020, pp. 631–32, JSTOR, <https://www.jstor.org/stable/48583528>. Accessed 27 Mar. 2023.
2. R.Mearns, Sustaining livelihoods on Mongolia's pastoral commons: Insights from a participatory poverty assessment, Development and Change, 35(1), 107-139.
3. C.Upton, "Custom and Contestation: Land Reform in Post-Socialist Mongolia", World development, 37(8), 1400-1410.
4. E Ostrom, T Dietz, P Stern, The struggle to govern the commons, Science, 2003, 302 (5652).
5. 이승길, 공유지의 비극과 관광공유재의 함수관계, 한국관광연구학회, 관광연구저널, 2017.
6. 김윤상, 공유지의 비극과 사유화의 비극, 국가정책연구 제24권 제3호.
7. Batsaikhan Usukh, Hans P. Binswanger-Mkhize, Raffael Himmelsbach and Karl Schuler, Fostering the sustainable livelihoods of herders in Mongolia via collective action, 2010.
8. Gerard Dannemann & Reiner Schulze, Article by Article Commentary on German Civil Code, 2020.
9. Conflicts over pasture resources in the Kyrgyz Republic Research report - June 2013, <https://hal.science/hal-01901568/file/Conflicts%20over%20pastures%20ACTED%20CAMP%20ALATOO%20ENG.pdf>

“МАЛЧИН ӨРХИЙН ХОЛБООНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ” ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООЛОЛ

2024.01.18

Улаанбаатар хот

УДИРТГАЛ

Энэхүү зардлын тайлангийн зорилго нь Малчин өрхийн холбооны эрхзүйн байдлын тухай хуулийн төслийг хэрэгжүүлэх хүрээнд хуулийн этгээд, иргэн, төрийн байгууллагын үйл ажиллагаатай холбогдуулан зайлшгүй гаргах зардлыг тооцож, тэдгээрт ногдох зардал, үйл ажиллагааны ачааллыг багасгаж, зохицуулалтын боломжит хувилбарыг боловсруулахад оршино.

Хуулийн төсөлд малчин өрхийн холбооны зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулахаар дараах үндсэн заалтуудыг тусгасан. Үүнд:

1. Нэр томъёоны тодорхойлолт хэсэгт шинээр тусгагдсан нэр томъёонууд болох “Малчин өрхийн анхдагч холбоо”, “гэрээт бэлчээрийн газар” гэх зэрэг нэр томъёонуудын тайлбарыг тусгасан;
2. Малчин өрхийн анхдагч холбоо нь бэлчээрийн газрыг сумын Засаг даргатай байгуулсан гэрээний үндсэн дээр бэлчээрийн газрыг зохистой ашиглаж, доройтлоос сэргийлэх, сайжруулах, хамгаалах асуудлыг хариуцах, малчин өрхийн гишүүнийг боловсрол, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамруулах, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, тэдгээрт төрийн мэдээллийг хүргэх, малын эрүүл мэнд, үржил, чанар, ашиг шимийг дээшлүүлэх, мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэх, борлуулахад дэмжлэг үзүүлэх гэсэн үйл ажиллагааны чиглэлүүдийн хүрээнд малчин өрхүүдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалж, зохион байгуулж оролцохоор байна;
3. Малчин өрхийн холбоо нь гишүүддээ үйлчилдэг, ашгийн төлөө бус хуулийн этгээд болохыг заасны зэрэгцээ малчин өрхийн анхдагч холбоо, сумын, аймгийн, нэгдсэн холбооны зохион байгуулалттай байх ба төрийн зарим чиг үүргийг малчин өрхийн холбоогоор хуульд заасны дагуу, эсхүл гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болохоор байна.

Хуулийн төслийн хэрэгжилтийн явцад гарах зардлын тооцоог Монгол Улсын Хууль тогтоомжийн тухай хуулийн 18.1 дэх хэсэг, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-д тусгасны дагуу хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардал, эрх зүйн зохицуулалтад хамаарах хуулийн этгээд, төрийн байгууллага, иргэн гэсэн ангиллуудаар тооцон боловсрууллаа.

Түүнчлэн одоогийн мөрдөгдөж буй хууль, тогтоомжид хэвээр үлдсэн зохицуулалтууд нь хуулийн этгээд, иргэн, төрийн байгууллагад нэмэлтээр зардлын нөлөөлөл үзүүлэхгүй гэж үзэв.

НЭГ. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЗАРДЛЫГ ТООЦОХ

Хуулийн этгээдийн зардлыг тооцох ажлыг хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох, зардлыг тооцох, нийт зардлын дүнг тооцож гаргах гэсэн дарааллаар гүйцэтгэв.

Малчин өрхийн холбооны чиг үүрэг

Холбооны гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээг тодорхойлоход дараах зарчмыг баримталсан. Үүнд:

1.Тухайн хууль тогтоомжид хамаарах анхдагч болон сум, аймгийн, улсын нэгдсэн холбоо, тэдгээрийн гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээг тодорхойлох;

2.Байгууллагыг сонгохдоо тухайн ажил, үйлчилгээнд хамааралтай бүх байгууллагыг биш голлон үүрэг гүйцэтгэх байгууллагыг сонгох;

3.Ажил, үйлчилгээнд хэрэгжүүлэх, хэмжих боломжтой ажлыг хамааруулах.

Хуулийн төсөлд тусгагдсан малчин өрхийн холбооны үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүргийг дараах байгууллагууд гүйцэтгэхээр байна.

1. Малчин өрхийн анхдагч холбоо
2. Малчин өрхийн сумын холбоо
3. Малчин өрхийн аймгийн холбоо
4. Малчин өрхийн нэгдсэн холбоо

Хүснэгт 1. Хуулийн төсөлд тусгагдсан хуулийн этгээдийн зардал, төгрөгөөр

№	Холбоо	Хуралдах тоо	Чиг үүрэг	Гарах зардал/төг/	Нийт зардал/төг/
1	Анхдагч холбоо	2	Анхдагч холбооны бүх гишүүдийн хурлыг зохион байгуулах Өдөр тутмын үйл ажиллагааны зохион байгуулалтыг хариуцан хэрэгжүүлэх	Хурал зохион байгуулах зардал-300,000.0/ нэг удаагийн зардал-150,000.0/ Ахлагчийн урамшуулал-3000,000.0/нэг сард 250,000.0/ Гэрээт нягтлан бодогчийн цалин/2 удаа тайлан гаргана. Нэг удаа тайлан гаргахад 100,000.0 төгрөгийн хөлс олгоно./	3,500,000.0
2	Сумын малчин өрхийн холбоо	1	Гишүүдийн мал, малын гаралтай түүхий эд бэлтгэх, борлуулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;	Хурал зохион байгуулах зардал-150,000.0 ХХААХҮЯ, Аймгийн малчин өрхийн холбоотой хамтран ажиллах, түүхий эдийн явуулын болон түр цэг байгуулах /жинлүүр түрээслэх-жилд 300,000.0, байр түрээслэх-жилд 1200,000.0, сард 100,000.0/	1650,000.0
			Гишүүдийн саналд тулгуурлан гадаад, дотоодын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх;	Төсөл, хөтөлбөрийн судалгаа явуулах, төсөл, хөтөлбөрийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл авах, малчдыг санхүүжүүлэгч байгууллагуудтай холбох/судалгаа-жилд	600,000.0

				100,000.0, мэдээлэл зөвлөгөө авах-жилд 2 удаа, нэг удаагийн зардал 250,000.0/	
			Энэ хуулийн 8.2-т заасан үйл ажиллагааны хүрээнд гишүүд, бусад аймаг, сумын холбооны сайн туршлага, үйлдвэрлэлийн шинэ арга технологийг зөвлөн нэвтрүүлэх үйлчилгээг зохион байгуулах.	Сургалт зохион байгуулах, шинэ технологийн талаар танилцуулга, мэдээлэл хийх, энэ чиглэлээр хөндлөнгийн оролцогч талуудтай хамтран уулзалт зохион байгуулах/сургалт, уулзалт зохион байгуулах-1 удаа/	500,000.0
3	Аймгийн малчин өрхийн холбоо	1	Холбогдох баримт бичгүүдэд санал гаргах	Хурал зохион байгуулах зардал-150,000.0 Санал гаргахтай холбоотой судалгаа, тооцоолол хийх, уулзалт зохион байгуулах-100,000.0	250,000.0
4	Нэгдсэн холбоо	1	Нүүдлийн мал аж ахуйн уламжлалт өв соёл, заншил, мал маллах арга ухааныг сурталчлах;	Хурал зохион байгуулах зардал-150,000.0 Үзэсгэлэн худалдаа, соёлын өдөрлөг зохион байгуулах, танин мэдэхүйн чиглэлийн мэдээлэл, контент бэлтгэж, мэдээллийн технологийн хэрэгслүүдээр дамжуулан түгээх, энэ чиглэлээр Аймгийн малчин өрхийн холбоо, ХХААХҮ-тай хамтран ажиллах/1,000,000.0/	1,150,000.0
			мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэх нэгдсэн сүлжээ бий болгох талаар эрх бүхий байгууллагад санал гаргах;	Санал гаргахтай холбоотой судалгаа, тооцоолол хийх, уулзалт зохион байгуулах	100,000.0
			холбооны мэдээллийн нэгдсэн цахим санг бүрдүүлэх, эрхлэн хөтлөх.	Мал аж ахуйн үйлдвэрлэл, борлуулалт, байршил, кластер зэргийг тусгасан Мэдээллийн нэгдсэн сангийн программ хангамжийг нэвтрүүлэх	10,000,000.0
	Нийт				17,750,000.0

Хүснэгт 2.Хуулийн төсөлд тусгагдсан хуулийн этгээдийн зардал/ улсын хэмжээнд, жилд, төгрөгөөр/

№	Малчин өрхийн холбоо	Тоо	Жилд гарах зардал/төг/	Нийт зардал/төг/
1	Анхдагч холбоо	3300	3,500,000.0	11,550,000,000.0
2	Сумын малчин өрхийн холбоо	330	2,750,000.0	907,500,000.0
3	Аймгийн малчин өрхийн холбоо	21	250,000.0	5,250,000.0
4	Нэгдсэн холбоо	1	11,250,000.0	11,250,000.0
Нийт				12,474,000,000.0

Түүнчлэн Малчин өрхийн холбооны эрхзүйн байдлын хуулийн төсөлд тусгагдсан төрийн захиргааны үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүргийг дараах байгууллагууд гүйцэтгэхээр байна.

- 1.Засгийн газар
- 2.Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
- 3.Сумын газрын даамал, дүүргийн газрын алба
- 4.Аймаг, сум иргэдийн төлөөлөгчдийн хурал
- 5.Аймаг, сум, багийн засаг дарга

Дээрх хуулийн төслийн хүрээнд төрийн байгууллагуудад хүний нөөцийн, материаллаг болон бусад зардлыг нэмэгдүүлэх шаардлагагүй гэж тооцсон болно. Учир нь Малчин өрхийн холбооны дараах чиг үүргүүд нь Газрын тухай хуульд заасны дагуу төрийн байгууллагуудын үйл ажиллагааны хүрээнд хийгдэх үйл ажиллагаанууд байна. Чиг үүргүүдийг дурдвал дараах байдалтай байна.

- Малчин өрхийн гишүүнийг боловсрол, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамруулах, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, тэдгээрт төрийн мэдээллийг хүргэх;
- Гэрээт бэлчээрийн газар, байгалийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх;
- Малын эрүүл мэнд, үржил, чанар, ашиг шимийг дээшлүүлэх, мал, малын гаралтай
- Түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэх, борлуулахад дэмжлэг үзүүлэх.
- Малчин өрхийн гишүүдийн нарийн мэргэжлийн болон эрүүл мэндийн бусад тусламж, үйлчилгээ авах хүсэлтийг сумын эрүүл мэндийн төвд уламжилж, хамтран ажиллах;
- Малчин өрхийн гишүүдийг албан болон албан бус сургалтад хамруулах;
- Холбогдох байгууллагаас зохион байгуулах мал аж ахуйн үйлдвэрлэлийн арга, технологи, бизнесийн үйл ажиллагааны талаар мэдлэг түгээх, малчдын ур чадварыг сайжруулахад чиглэсэн мэргэжил, арга зүйн зөвлөн нэвтрүүлэх үйлчилгээнд гишүүдийг хамруулах;
- Байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, доройтсон бэлчээрийг нөхөн сэргээх, хөрсний үржил шимийг сайжруулах ажлыг зохион байгуулах;
- Бэлчээрийн ургамлын ургалт, нөхөн сэргэлтэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байдлаар гэрээт бэлчээрийн газрыг гишүүн малчин өрхөд хуваарьтай ашиглуулах;
- Байгалийн гамшгаас хамгаалах нөөц бүрдүүлэх, хадлан, тэжээл бэлтгэх;

- Гэрээт бэлчээрийн газарт хорио цээртэй өвчин гарах, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамал тархахаас урьдчилан сэргийлэх, гарсан тохиолдолд холбогдох арга хэмжээг авах;
- Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах, хөв цөөрөм байгуулах;
- Мал, амьтны сэг зэм устгал, орчны халдваргүйтгэлийн арга хэмжээг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах;
- Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, мал, амьтны өвчинтэй тэмцэх, малыг эрүүлжүүлэх;
- Бүс нутгийн онцлог, уур амьсгалд дасан зохицсон ашиг шим сайтай малыг сонгож, өсгөн үржүүлэх.

ХОЁР. ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

Хуулийн төсөлд тусгагдсан малчин өрх буюу анхдагч холбоонд шинээр элсэх иргэнд үүсэх зардлыг тухайн хэсэгт тооцооллоо.

Иргэнд үүсэх зардлын тооцоог дараах алхмын хүрээнд хийсэн. Үүнд:

1. Иргэнд үүрэг хүлээлгэсэн заалтуудыг тодорхойлох
2. Зардал тооцох
3. Зардлын дүнг тооцож гаргах

2.1. Гишүүний хураамжийн зардал

Малчин өрхийн анхдагч холбооны гишүүний хураамжийг анхдагч холбооны бүх гишүүдийн хурлаар тогтооно гэж хуулийн төсөлд заасан. Холбооны гишүүний хураамжийг нэг малчин өрх сард 50.0 мянган төгрөг байхаар тооцоолов. Малчин өрхийн анхдагч холбоо 20 гишүүнтэй байна гэж заасан тул сард анхдагч холбоо 1,000.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны зардалд ашиглах боломжтой гэж үзсэн.

Хүснэгт 3.Холбооны гишүүний хураамжийн зардал

№	Холбоо	Малчин өрхийн холбооны тоо	Гишүүдийн нийт тоо /Улсын хэмжээнд/
1	Нэг суманд байгуулагдах Анхдагч холбоо	10	$330^1 \times 10 \times 20 = 66000$
2	Нэг аймагт байгуулагдах Сумын малчин өрхийн холбоо	Сумын тоогоор	$3300 = 330 \times 10$ /21 аймгийн хувьд/ Хуулийн төслийн 22.2-т "Сумын малчин өрхийн холбоо /цаашид "Сумын холбоо" гэх/ нь гишүүн Анхдагч холбоо бүрийн Ахлагч нараас бүрдэнэ." гэж заасан.
3	Монгол Улсад байгуулагдах Аймгийн малчин өрхийн холбоо	21	$660 / 330$ сум тус бүрээс 2 гишүүн хамрагдана гэж үзсэн./
4	Нэгдсэн холбоо	1	21

Иргэнд ногдох зардлын задаргаа:

Гишүүний хураамжтай холбоотой иргэнээс гарах нийт зардал = $50000 \text{ төг} \times 12 \times (66000 + 3300 + 660 + 21) = 41,988,600,000.0 \text{ төг}$

2.2 Бэлчээр ашиглахтай холбоотой гарах зардал

¹ Монгол Улсад нийт 330 сум байгаа гэж үзэв.

Энэ хэсэгт хуулийн төсөлд тусгасан үүргийг хэрэгжүүлснээр иргэнд үүсэх зардлын хэмжээг мөнгөн дүнгээр урьдчилан тооцож гаргасан. Дээрх үйл ажиллагаанд зарцуулах цаг хугацаа тухайн үүргийг хэрэгжүүлэхэд гарах мөнгөн зардлыг тус тус тооцно.

Тухайн үүргийн дагуу хэчнээн төрлийн үйл ажиллагаа хийх ёстойг тодорхойлж агуулгаар нь нэгтгэж үүрэг бүрийг хэрэгжүүлэхэд гүйцэтгэх үйл ажиллагаа, түүний гүйцэтгэлийн хугацааг тогтоох нь харилцан адилгүй боловч тухайн хуулийн үйлчлэлд хамаарах иргэдийн хувьд амьдарч буй газар нутаг, нийгмийн байдал зэргээс хамааран цаг хугацааг баримжаалан тооцдог. Малчин өрхийн гишүүд бэлчээр ашиглах гэрээ байгуулах үйл ажиллагаа, түүнд зарцуулах хугацааг дараах байдлаар тогтоов.

Хүснэгт 4. Иргэний гүйцэтгэх стандарт үйлчилгээ буюу үйл ажиллагаанд зарцуулах мөнгөн зардал

Үүргийн агуулга	Гүйцэтгэх үйл ажиллагаа	Мөнгөн зардал /төгрөг/	
Малчин өрхийн холбоо бэлчээрийг гэрээгээр ашиглах /улирлаар/	-Холбоо байгуулахаар санаачлан хоорондоо зөвшилцөх	25,860.0 ²	Нийт: 142,323.0
	-Зөвшилцөлд хүрсэн малчин өрхийн холбоог үүсгэн байгуулах хурал хийж, үүсгэн байгуулсан баримт бичгээ баталгаажуулах		
	-Холбооны ахлагчаа сонгож хамтран ажиллах гэрээ, дүрмээ батлах		
	-Гэрээгээр ашиглах бэлчээрийг тоймлон гар зураг гаргаж, ашиглах хуваарь хийж баталгаажуулах		
	-Бэлчээрийн хил заагийг тогтоон зөвшилцөх хөршөө тодорхойлж, тэдгээртэй хэлцэл хийх		
	-Хэлэлцэн зөвшилцсөн хил заагийн талаар тэмдэглэл үйлдэж баталгаажуулах		
	-Сумын Засаг даргад бэлчээр ашиглах болон малчдын бүлэг байгуулах хүсэлт гаргах /Малчдын холбооны ахлагч, бусад малчин өрх, тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн талаарх мэдээлэл, оршин суугаа хаяг иргэний үнэмлэхийн хуулбар / малчин өрх бүрийн нэр дээр тоологдсон малын төрөл, тоог заасан жагсаалт; газрын зураг/		
	-Сум, дүүргийн Засаг даргаас шийдвэр гаргаж гэрээ байгуулахаар шийдвэрлэх		
	-Гэрээ байгуулах		
	-Бэлчээрийн газрын төлөв байдал, чанарын үзүүлэлт, даацын хэмжээг тогтоож ашиглуулах бэлчээрийг хүлээлгэн өгөх		
	-Гэрээ сунгуулах хүсэлт		
	-Гэрээгээр ашиглахаар хүсэж буй бэлчээрийн газрын зураг гаргуулах	116,463.0 ³	

Тоон үзүүлэлтийг тооцсон талаар:

Тоон үзүүлэлт нь хуулийн төсөлд тусгасан үүрэг хэчнээн хуулийн этгээдэд, нэг жилд хэдэн удаагийн давтамжтайгаар үүрэг хүлээлгэж байгааг илэрхийлнэ. Тоон

² Бусад үйл ажиллагаатай холбоотой бичиг хэргийн зардлыг ийнхүү тооцлоо.

³ Засгийн газрын 2009 оны 175 дугаар тогтоолд зааснаар нэг цэгт кадастрын хэмжилт зураглал хийх дундаж үнэ 14,577.0 төгрөг бөгөөд бэлчээрийн газар хэмжээ их учир дунджаар 8 цэг байхаар тооцлоо.

үзүүлэлтийг тооцохдоо тохиолдлын тоог давтамжийн тоогоор үржүүлнэ. Тоон үзүүлэлтийг тооцохдоо дараах хүчин зүйлийг харгалзав. Үүнд:

1. Тухайн үүргийг хүлээх иргэний тоо (Тохиолдлын тоо);
2. Тухайн үүргийг жилд хэдэн удаа гүйцэтгэх тоо (Давтамжийн тоо).

Энэ үе шатанд иргэний гүйцэтгэх үүргийг тухайн харилцаанд оролцогч хэчнээн иргэн жилд хэдэн удаа хэрэгжүүлэхийг хуанлийн нэг жилээр тооцож гаргадаг.

Хүснэгт 5. Иргэний гүйцэтгэх стандарт үйлчилгээ буюу үйл ажиллагааны тоон үзүүлэлт

Үүргийн агуулга	Тохиолдлын тоо	Давтамж	Тоон үзүүлэлт
Малчин өрхийн холбоо бэлчээрийг гэрээгээр ашиглах чиг үүргүүд	30.788 ⁴	4 ⁵	123,152

Зардлын дүнг тооцсон тухай:

Энэ хэсэгт өмнөх шатанд тооцож гаргасан стандарт үйл ажиллагаа тус бүрийг гүйцэтгэхтэй холбогдон гарах зардлын тооцоо болон тоон үзүүлэлтийг хооронд нь үржүүлж нийт захиргааны зардлын дүнг гаргасан.

Хүснэгт 6. Иргэний гүйцэтгэх стандарт үйлчилгээ буюу үйл ажиллагаанд зарцуулах нийт мөнгөн зардал

Үүргийн агуулга	Гүйцэтгэх үйл ажиллагаа	Мөнгөн зардал /төгрөг/	Тоон үзүүлэлт	Нийт зардал
Малчин өрхийн холбоо бэлчээрийг гэрээгээр ашиглах	Холбоо байгуулахаар санаачлан хоорондоо зөвшилцөх	142,323.0	123,152	17,527,362,096.0
	Зөвшилцөлд хүрсэн малчин өрхүүд холбоо үүсгэн байгуулах хурал хийж, үүсгэн байгуулсан баримт бичгээ баталгаажуулах			
	Холбооны ахлагчаа сонгож хамтран ажиллах гэрээ, дүрмээ батлах			
	Гэрээгээр ашиглах бэлчээрийг тоймлон гар зураг гаргаж, ашиглах хуваарь хийж баталгаажуулах			
	Бэлчээрийн хил заагийг тогтоон зөвшилцөх хөршөө тодорхойлж, тэдгээртэй хэлцэл хийх			
	Хэлэлцэн зөвшилцсөн хил заагийн талаар тэмдэглэл үйлдэж баталгаажуулах			
	Сумын Засаг даргад бэлчээр ашиглах болон малчдын холбоо байгуулах хүсэлт гаргах /Малчдын холбооны ахлагч, бусад малчин өрх, тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн талаарх мэдээлэл, оршин суугаа хаяг иргэний үнэмлэхийн хуулбар / малчин өрх бүрийн нэр дээр тоологдсон			

⁴ Манай Улсын хувьд бэлчээр ашиглагч холбооны тоо тодорхой гаргасан тооцоо судалгаа байхгүй. Практикт бэлчээр ашиглагч бүлэгт 5-15 малчин өрх байна. Өөрөөр хэлбэл, дунджаар 8 өрх юм. Үүнийг Үндэсний статистикийн хорооноос гаргасан 2021 оны нийт малчин өрхийн тоо болох 246,302 -д хуваан үзвэл 30788 малчин өрх болж байна.

⁵ Мөн хуулийн төсөлд малчин өрх 4 улиралд өөр өөр бэлчээр ашиглалтын бүлэгт багтах боломжтой учраас давтагдах үзүүлэлтийг 4 удаа байна гэж үзлээ.

	малын төрөл, тоог заасан жагсаалт; газрын зураг/			
	-Сум, дүүргийн Засаг даргаас шийдвэр гаргаж гэрээ байгуулахаар шийдвэрлэх			
	-Гэрээ байгуулах			
	-Бэлчээрийн газрын төлөв байдал, чанарын үзүүлэлт, даацын хэмжээг тогтоож ашиглуулах бэлчээрийг хүлээлгэн өгөх			
	-Гэрээ сунгуулах хүсэлт			
	-Гэрээгээр ашиглахаар хүсэж буй бэлчээрийн газрын зураг гаргуулах			

Эндээс харахад нэг жилийн хугацаанд улсын хэмжээнд малчин өрхийн холбоогоор дамжуулан бэлчээрийн газрыг гэрээгээр ашиглах гэрээ байгуулахад 17,527,362,096.0 төгрөгийн, гишүүний хураамжтай холбоотойгоор 41,988,600,000.0 төгрөгийн, нийт 59,515,962,096.0 буюу 59.5 тэрбум төгрөг иргэнээс гарахаар байна.

ДҮГНЭЛТ, САНАЛ

Энэхүү хуулийн төслийн зардлын тооцооны судалгаагаар хууль тогтоомжийн зохицуулалтын улмаас хуулийн этгээд, иргэн, төрийн байгууллагад хэдий хэмжээний зардал, ачаалал үүсгэхийг урьдчилан тооцоолов.

Судалгааны хүрээнд Малчин өрхийн холбооны эрхзүйн байдлын тухай хуулийн төслийн хэрэгжилттэй холбогдон гарах хуулийн этгээд, иргэн, төрийн байгууллагаас гарах зардлыг хуулийн төслийн зүйл заалт тус бүрээр тооцон боловсруулсан болно.

Хуулийн этгээд, төрийн байгууллага, иргэнээс гарах зардлын тооцоог дараах байдлаар дүгнэж болохоор байна.

Нэгдүгээрт, Хуулийн этгээдээс гарах зардал:

Анхдагч холбоо, Сумын малчин өрхийн холбоо, Аймгийн малчин өрхийн холбоо, Нэгдсэн холбооны хэрэгжүүлэх чиг үүрэгтэй холбоотойгоор 12,474,000,000.0 буюу 12.5 тэрбум төгрөгийн зардал Хуулийн этгээдээс гарахаар байна.

Хоёрдугаарт, Төрийн байгууллагаас гарах зардал:

Боловсруулсан хуулийн төслийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн байгууллагаас нэмэлт зардал гарахгүй гэж тооцсон. Учир нь Газрын тухай хууль, холбогдох бусад эрх зүйн зохицуулалтын дагуу сумын газрын даамал, сум, аймгийн ИТХ, аймгийн хүнс, хөдөө аж ахуйн газрын чиг үүргийг Малчин өрхийн холбооны үйл ажиллагаатай уялдуулан зохион байгуулах боломжтой тул нэмэлт зардал шаардлагагүй юм.

Гуравдугаарт, Иргэнд үүсэх зардал:

Тоон давтамж бүрд 142,323.0 төгрөгийн мөнгөн зардал бэлчээр ашиглагч субьектээс гарахаар байна. Тоон үзүүлэлтийн хувьд бэлчээр ашиглагчдын холбооны тоон үзүүлэлт 123,152 байна. Нийт дүнгээрээ 1 жилийн хугацаанд нийт бэлчээр ашиглагчдын бүлэг бэлчээрийн газрыг гэрээгээр ашиглах гэрээ байгуулахад 17,527,362,096.0 төгрөгийн зардлыг зарцуулахаар байна⁶.

Дөрөвдүгээрт, нийт зардал: Нийт зардал 71,989,962,096.0 төгрөг гарахаар тооцогдож байгаа хэдий боловч иргэнээс гарах гишүүний хураамжийн зардал нь

⁶ Энэхүү нийт зардлыг тооцоолохдоо нэг бэлчээр ашиглагчаас гарах мөнгөн зардлыг тоон үзүүлэлт буюу тохиолдлын тоо болон давтамжийн тоогоор үржүүлж гаргасан.

Хуулийн этгээдийн зардлын санхүүжилт болох учраас тус хууль хэрэгжсэнээр ойролцоогоор 59,515,962,096.0 төгрөгийн зардал шинээр гарахаар харагдаж байна.

Хийсэн тооцооллоос иргэнээс гарах зардал буюу гишүүний хураамж Хуулийн этгээдийн зардлаас хавьгүй өндөр байгаа нь малчид нэгдсэн зохион байгуулалтад орон үйл ажиллагаа явуулж, хуримтлалтай болох аль эсвэл гишүүдийн хураамжийн хүрээнд Малчдын холбооны зардлыг нэмэгдүүлэх боломжтойг харуулж байна.

Ингэснээр шууд агуулгаараа эдийн засагт шинээр гарах нийт зардлын дүнд төдийлөн өөрчлөлт орохгүй хэдий боловч дам нөлөө нь ялгаатай. Бодлогын сонголтын өөр нэг хувилбар нь гишүүний хураамжийг тооцоололд авагдсанаас багаар тогтоож, Малчдын холбооны үйл ажиллагааг санхүүжүүлэх явдал юм. Түүнчлэн холбооны мэдээллийн нэгдсэн цахим санг бүрдүүлэх, эрхлэн хөтлөх үйл ажиллагааны зардал жил бүр өндөр дүнтэй гарахгүй тул дараагийн нэгж хугацаануудад түүний оронд өөр төрлийн зардлыг санхүүжүүлэх боломжтой.

МАЛЧИН ӨРХИЙН ХОЛБООНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААР ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

"Мөнх-Шинэ хөдөө сэргэлт" сэдэвт хэлэлцүүлэг 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр Төрийн ордны "Жанжин Д.Сүхбаатар" танхимд зохион байгуулсан. Хэлэлцүүлгээр Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг боловсруулан танилцуулахаас гадна эрдэмтэн, судлаачид оролцож, бэлчээрийн мал аж ахуйн хөгжлийн бодлогын шинэчлэл, бэлчээрийн тулгамдсан асуудал, улсын бэлтгэлийн тогтолцоо, мал аж ахуйн бүтээгдэхүүний өртгийн сүлжээг боловсронгуй болгох, сумын хөгжлийн системийн шинжилгээ зэрэг олон асуудлаар илтгэл тавьж, хэлэлцэв.

Хуулийн төслийг Улсын Их Хурлын даргын ахлах зөвлөх Д.Лүндээжанцан танилцуулсан, мөн Хөдөө аж ахуйн эдийн засаг, хөгжлийн судалгааны төвийн захирал А.Бакей "Монгол Улсын бэлчээрийн мал аж ахуйн хөгжлийн бодлогын шинэчлэх асуудал", Бодлого, судалгааны төвийн захирал А.Энх-Амгалан "Бэлчээрийн тулгамдсан асуудал, шийдэл", ХААИС-ийн захирал Б.Баасансүх, тус сургуулийн Эдийн засаг, бизнесийн ухааны сургуулийн захирал Т.Эрдэнэчулуун нар "Мал аж ахуйн бүтээгдэхүүний өртгийн сүлжээг боловсронгуй болгох нь", ШУТИС-ийн Хэрэглээний шинжлэх ухааны сургуулийн Математикийн танхимын дэд профессор Б.Ууганбаяр, ШУА-ийн Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн Нийгэм, эдийн засгийн газарзүйн салбарын эрхлэгч М.Алтанбагана, МУИС-ийн Шинжлэх ухааны Их сургуулийн Түүхийн судалгааны хүрээлэнгийн захирал П.Дэлгэржаргал, Де Нэйче Консерванси /TNC/-PEP төслийн захирал Ц.Мөнхбаяр "Байгаль хамгааллын байнгын санхүүжилтийн хөтөлбөрийн тухай" илтгэлүүдийг тус тус тавьсан.

Хэлэлцүүлэгт Монгол Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын гишүүд болон Шинжлэх ухааны хүрээлэн, Их дээд сургууль, Төрийн болон төрийн бус байгууллага, эрдэмтэн, судлаачдын төлөөллийг оролцуулсан 100 орчим хүний бүрэлдэхүүнтэй хэлэлцүүлэг хийж хуулийн төслийг танилцуулсан.





Don't forget to call us!

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НЭЙТЛЭГ ҮНЭЭСЭЛ

1996

3. 0.75M NaOH 200ml

А.Д.ГОЗРЗОВ

5,7,7-TRIMETHYLBUT-3-YN-2-OL

6:10 TAP 3Y:11

ХОЁРНУГААР БҮЛЭГ

ΑΠΙΧΤΑΨΟΧΟΛΕΟΟ,

ABQUT-ATA

7 MAY 3:20

6. 2. 1. 2. 3. 4. 5. 6. 7. 8. 9. 10. 11. 12. 13. 14. 15. 16. 17. 18. 19. 20. 21. 22. 23. 24. 25. 26. 27. 28. 29. 30. 31. 32. 33. 34. 35. 36. 37. 38. 39. 40. 41. 42. 43. 44. 45. 46. 47. 48. 49. 50. 51. 52. 53. 54. 55. 56. 57. 58. 59. 60. 61. 62. 63. 64. 65. 66. 67. 68. 69. 70. 71. 72. 73. 74. 75. 76. 77. 78. 79. 80. 81. 82. 83. 84. 85. 86. 87. 88. 89. 90. 91. 92. 93. 94. 95. 96. 97. 98. 99. 100. 101. 102. 103. 104. 105. 106. 107. 108. 109. 110. 111. 112. 113. 114. 115. 116. 117. 118. 119. 120. 121. 122. 123. 124. 125. 126. 127. 128. 129. 130. 131. 132. 133. 134. 135. 136. 137. 138. 139. 140. 141. 142. 143. 144. 145. 146. 147. 148. 149. 150. 151. 152. 153. 154. 155. 156. 157. 158. 159. 160. 161. 162. 163. 164. 165. 166. 167. 168. 169. 170. 171. 172. 173. 174. 175. 176. 177. 178. 179. 180. 181. 182. 183. 184. 185. 186. 187. 188. 189. 190. 191. 192. 193. 194. 195. 196. 197. 198. 199. 200. 201. 202. 203. 204. 205. 206. 207. 208. 209. 210. 211. 212. 213. 214. 215. 216. 217. 218. 219. 220. 221. 222. 223. 224. 225. 226. 227. 228. 229. 230. 231. 232. 233. 234. 235. 236. 237. 238. 239. 240. 241. 242. 243. 244. 245. 246. 247. 248. 249. 250. 251. 252. 253. 254. 255. 256. 257. 258. 259. 260. 261. 262. 263. 264. 265. 266. 267. 268. 269. 270. 271. 272. 273. 274. 275. 276. 277. 278. 279. 280. 281. 282. 283. 284. 285. 286. 287. 288. 289. 290. 291. 292. 293. 294. 295. 296. 297. 298. 299. 300. 301. 302. 303. 304. 305. 306. 307. 308. 309. 310. 311. 312. 313. 314. 315. 316. 317. 318. 319. 320. 321. 322. 323. 324. 325. 326. 327. 328. 329. 330. 331. 332. 333. 334. 335. 336. 337. 338. 339. 340. 341. 342. 343. 344. 345. 346. 347. 348. 349. 350. 351. 352. 353. 354. 355. 356. 357. 358. 359. 360. 361. 362. 363. 364. 365. 366. 367. 368. 369. 370. 371. 372. 373. 374. 375. 376. 377. 378. 379. 380. 381. 382. 383. 384. 385. 386. 387. 388. 389. 390. 391. 392. 393. 394. 395. 396. 397. 398. 399. 400. 401. 402. 403. 404. 405. 406. 407. 408. 409. 410. 411. 412. 413. 414. 415. 416. 417. 418. 419. 420. 421. 422. 423. 424. 425. 426. 427. 428. 429. 430. 431. 432. 433. 434. 435. 436. 437. 438. 439. 440. 441. 442. 443. 444. 445. 446. 447. 448. 449. 450. 451. 452. 453. 454. 455. 456. 457. 458. 459. 460. 461. 462. 463. 464. 465. 466. 467. 468. 469. 470. 471. 472. 473. 474. 475. 476. 477. 478. 479. 480. 481. 482. 483. 484. 485. 486. 487. 488. 489. 490. 491. 492. 493. 494. 495. 496. 497. 498. 499. 500. 501. 502. 503. 504. 505. 506. 507. 508. 509. 510. 511. 512. 513. 514. 515. 516. 517. 518. 519. 520. 521. 522. 523. 524. 525. 526. 527. 528. 529. 530. 531. 532. 533. 534. 535. 536. 537. 538. 539. 540. 541. 542. 543. 544. 545. 546. 547. 548. 549. 550. 551. 552. 553. 554. 555. 556. 557. 558. 559. 560. 561. 562. 563. 564. 565. 566. 567. 568. 569. 570. 571. 572. 573. 574. 575. 576. 577. 578. 579. 580. 581. 582. 583. 584. 585. 586. 587. 588. 589. 590. 591. 592. 593. 594. 595. 596. 597. 598. 599. 600. 601. 602. 603. 604. 605. 606. 607. 608. 609. 610. 611. 612. 613. 614. 615. 616. 617. 618. 619. 620. 621. 622. 623. 624. 625. 626. 627. 628. 629. 630. 631. 632. 633. 634. 635. 636. 637. 638. 639. 640. 641. 642. 643. 644. 645. 646. 647. 648. 649. 650. 651. 652. 653. 654. 655. 656. 657. 658. 659. 660. 661. 662. 663. 664. 665. 666. 667. 668. 669. 670. 671. 672. 673. 674. 675. 676. 677. 678. 679. 680. 681. 682. 683. 684. 685. 686. 687. 688. 689. 690. 691. 692. 693. 694. 695. 696. 697. 698. 699. 700. 701. 702. 703. 704. 705. 706. 707. 708. 709. 710. 711. 712. 713. 714. 715. 716. 717. 718. 719. 720. 721. 722. 723. 724. 725. 726. 727. 728. 729. 730. 731. 732. 733. 734. 735. 736. 737. 738. 739. 740. 741. 742. 743. 744. 745. 746. 747. 748. 749. 750. 751. 752. 753. 754. 755. 756. 757. 758. 759. 760. 761. 762. 763. 764. 765. 766. 767. 768. 769. 770. 771. 772. 773. 774. 775. 776. 777. 778. 779. 780. 781. 782. 783. 784. 785. 786. 787. 788. 789. 790. 791. 792. 793. 794. 795. 796. 797. 798. 799. 800. 801. 802. 803. 804. 805. 806. 807. 808. 809. 810. 811. 812. 813. 814. 815. 816. 817. 818. 819. 820. 821. 822. 823. 824. 825. 826. 827. 828. 829. 830. 831. 832. 833. 834. 835. 836. 837. 838. 839. 8

9,747,337,315

[illegible]

10.1366/00000000132600000000000000000000

21 JUL 2011

С. П. Давыдов, Ю. А. Давыдов

УДК 621.372.6.01

ALLIANCE

ACKNOWLEDGMENTS

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 ОНЫ 1-Р САРЫН 29 ӨДӨР

МАЛЧИН ӨРХИЙН ХӨЛӨӨНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

[illegible]

ՀԱՅԿԱՍՏԱՆԻ ՀԱՆՐԱՊԵՏՈՒԹՅԱՆ ՔՄ ԱՎՂԱՌԱՋԱՆՑԱՆԸ

2 нүсгээр зүйл. Малчин өсгийн холбооны эрх зүйн байдлын хувь тогтоомж

- 2.1. Малчин өрхийн хэлбэрчлэл нь Монгол Улсын эсвэг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тусгай хувьт, байдалтай холбоотой.